



МОНГОЛЫН ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧЛАГА

МОНГОЛ УЛСЫН НАЙМДУГААР БУЮУ 2013 ОНЫ НЭГТГЭЛИЙН ТАЙЛАН



2014 ОНЫ 12 ДУГААР САР



**Энэхүү тайлан болон хавсралтуудыг Монголын ОУИТБС-ыг
Монгол Улсад хэрэгжүүлэх үүрэг бүхий ажлын албаны
хүсэлтээр, санаачлагын зорилгын үүднээс МОУИТБС-ын
Үндэсний Зөвлөл болон Ажлын Хэсгийн оролцогч
талуудын хэрэгцээнд зориулсан болно.**

Энэхүү тайланд 1,2,8,9,12,14,15,18,19,20,21,22 дугаар хавсралтуудыг оруулсан болно. Харин 3,4,5,6,7,10,11,13,16,17,23 дугаар хавсралтуудыг тайланд хавсаргасан CD-нд оруулсан болно.

АГУУЛГА

ТОВЧЛОЛУУД БА ТОДОРХОЙЛОЛТУУД	1
1. ОРШИЛ	8
1.1 Зорилго	8
1.2 ОУИТБС-ын нэгтгэлд оролцогч талууд	8
1.3 Тайлангийн бүтэц	8
1.4 Талархал	9
2. ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУРААНГУЙ	10
2.1 Танилцуулга	10
2.2 МОУИТБС-ын нэгтгэл тайлангийн үр дүнгийн хураангуй	10
2.3 Засгийн газрын орлого	10
2.3.1 Олборлох салбараас Засгийн газарт орсон орлого	10
2.3.2 Ажлын даалгаврын шаардлагын дагуу хийгдсэн судалгаанууд	14
2.3.3 Бусад асуудлууд	14
2.4 Олж илрүүлсэн гол зүйлс	14
2.4.1 Нэгтгэлийн хамрах хүрээ	15
2.4.2 Баталгаажуулалт	17
2.4.3 Гэрээ ил тод болгох	18
2.4.4 Нэгтгэлийн үр дүн	19
2.4.5 Нэгтгэлд хамрагдсан боловч нэгтгэлийн ажилд оролцоогүй аж ахуйн нэгжүүд	21
2.4.6 Улсын төсвийн тайлагнал	22
2.4.7 Шийдэгдээгүй зөрүүнүүд	23
2.4.8 Нэгтгэлийн ажлын хугацаа	23
2.4.9 Оролцогч байгууллагуудын хариу өгсөн байдал	23
2.5 Нэгтгэлийн үр дүнгийн шинжилгээ	24
2.5.1 Хамгийн их орлого төвлөрүүлсэн компаниуд	24
2.5.2 Компаниудын уул уурхайн байршил	24
2.5.3 Компаниудаас 2013 онд улсын төсөвт төвлөрүүлсэн орлого	25
2.5.4 Орон нутгийн төсөвт төлсөн татвар, төлбөрийн шинжилгээ	26
2.5.5 Компаниудаас үзүүлсэн хандив, дэмжлэгийн шинжилгээ	26
2.5.6 Шийдэгдээгүй зөрүүний шинжилгээ	27
3. МОНГОЛЫН УУЛ УУРХАЙН САЛБАР	28
3.1 Уул Уурхай	28
3.1.1 Нүүрс	29
3.1.2 Зэс	29
3.1.3 Төмрийн хүдэр	31
3.1.4 Алт	31
3.1.5 Хайлуур жонш	32
3.1.6 Молибдени	32
3.1.7 Цайр	32
3.1.8 Уран	32

3.1.9 Стратегийн ач холбогдол бүхий орд	32
3.1.10 Гар аргаар ашигт малтмал олборлолт ба бичил уул уурхай	34
3.1.11 Хайгуул	34
3.1.12 Боловсруулалт	37
3.2 Газрын тос ба Байгалийн хий	37
3.2.1 Газрын тос	37
3.2.2 Байгалийн хий	40
3.2.3 Боловсруулалт	40
3.3 Үйлдвэрлэл	40
3.3.1 Ашигт малтмал	40
3.3.2 Газрын тос	41
3.4 Эдийн засагт оруулсан хувь нэмэр	41
3.5 Засгийн газрын байгууллагууд	44
3.5.1 Татварын алба	44
3.5.2 Гаалийн ерөнхий газар	45
3.5.3 Нийгмийн даатгалын ерөнхий газар	45
3.5.4 Газрын тосны газар	45
3.5.5 Төрийн өмчийн хороо	45
3.5.6 Уул уурхайн яам	45
3.5.7 Байгаль орчин ногоон хөгжлийн яам	46
3.5.8 Хөдөлмөрийн яам	46
3.5.9 Цөмийн энергийн газар	47
3.5.10 Хүний хөгжлийн сан	47
3.5.11 Нийгмийн даатгалын сан	48
3.6 Төрийн Өмчит Аж Ахуйн Нэгж	48
3.6.1 Уул уурхайн салбар дахь төрийн өмчит аж ахуйн нэгжүүд	48
3.6.2 Газрын тосны салбар дахь төрийн оролцоо	55
3.7 Төсвийн Хуваарилалт	56
3.7.1 Төрийн санхүүгийн тогтолцоо	56
3.7.2 Төсвийн хууль тогтоомж	56
3.8 Орлогын Хуваарилалт	57
3.8.1 Ерөнхий мэдээлэл	57
3.8.2 Хүний хөгжил сан	58
3.8.3 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан	59
3.9 Уул уурхайн салбарыг хөгжүүлэх бодлого	60
3.10 Тусгай зөвшөөрөл олгох журам	62
3.10.1 Уул уурхай	62
3.10.2 Лиценз олголтын ерөнхий байдал	64
3.10.3 Уул уурхайн кадастр	66
3.10.4 Газрын тос	68
4. НЭГТГЭЛИЙН ХАМРАХ ХҮРЭЭ БА АРГА АРГАЧЛАЛ	70
4.1 Танилцуулга	70
4.2 Нэгтгэл тайлангийн хамрах хүрээ	70

4.2.1 Олборлох Үйлдвэрийн Ил Тод Байдлын Санаачлага (ОУИТБС)	70
4.2.2 Тайлангийн маягт	71
4.2.3 Төлбөрийн урсгал	71
4.3 Тайлагнагч Байгууллагууд	73
4.3.1 Засгийн Газар	73
4.3.2 Компаниуд	73
4.4 Материаллаг байдлын босго	74
4.5 Материаллаг зөрүү	74
4.6 Нэгтгэлийн хандлага ба арга аргачлал	75
4.6.1 Ерөнхий хандлага	75
4.6.2 Баталгаажуулалт	75
4.7 Зөрүүг тодорхойлох ажлын чиглэл, хоорондын уялдаа	77
4.8 Аргачлал	78
4.8.1 Мэдээллийн түүвэр	78
4.8.2 Мэдээллийн харьцуулалт	79
4.8.3 Мэдээллийн Нэгтгэл	79
4.9 ОУИТБС-ын талуудын оролцооны схем	81
4.10 Бусад хийгдсэн ажлууд	82
5. САНХҮҮГИЙН УРСГАЛЫН НЭГТГЭЛ	83
5.1 Нэгтгэлийн хураангуй	83
5.1.1 Танилцуулга	83
5.1.2 Анхлан тайлагнасан санхүүгийн нийт урсгал	83
5.1.3 Ажлын хэсгийн хуралдаанд танилцуулсан санхүүгийн нийт урсгал	85
5.1.4 Нэгтгэлийн дараах санхүүгийн нийт урсгал	85
5.2 ШИЙДЭГДЭЭГҮЙ ЗӨРҮҮНҮҮД	87
5.2.1 Танилцуулга	87
5.2.2 Шийдэгдээгүй зөрүү санхүүгийн урсгалаар	87
5.2.3 Шийдэгдээгүй зөрүүний шалтгааны тойм	89
5.3 Нэгтгэлд хамрагдсан компаниудын бусад мэдээлэл	91
6. АЖЛЫН ДААЛГАВАРТ ШААРДСАН НЭМЭЛТ СУДАЛГААНУУД	93
6.1 Сангийн сайдын 2010 оны 45 дугаар тушаалын биелэлт	93
6.2 Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын мөрдөлт болон санхүүгийн тайлан аудитлагдсан байдал	94
6.3 Уулын ажлын төлөвлөгөөний биелэлтийн судалгаа	95
6.4 Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн мэдээ	100
6.5 Ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл	102
6.5.1 Ерөнхий мэдээлэл	102
6.5.2 Ашиглалтын болон хайгуулын хамгийн олон лиценз эзэмшигч	102
6.5.3 Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн хөдөлгөөн	103
6.5.4 Газрын тос, байгалийн хийн тусгай зөвшөөрлийн хөдөлгөөн	103
6.6 Олборлох компаниуд орон нутгийн засаг захиргаатай Монгол улсын Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн дагуу байгуулсан гэрээ	104
6.6.1 Хуулийн заалт	104

6.6.2 Аргачлал	104
6.7 Төрийн болон орон нутгийн өмчит компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн судалгаа	105
7. БУСАД АСУУДЛУУД	106
7.1 Дэд бүтцийн хөрөнгө оруулалт болон бартерын солилцоо (хэлцэл)	106
7.2 Нийгмийн хөрөнгө оруулалтаарх зардал (компаниудын зүгээс үзүүлсэн хандив, дэмжлэг).....	108
7.3 Тээвэр	109
7.4 Ашиг хүртэгч.....	110
8. ЗӨВЛӨМЖ.....	111
8.1 ОУИТБС-ын биелэлт.....	111
8.2 Нэгтгэлийн цар хүрээ.....	111
8.2.1 Засгийн газрын мэдээлэл	111
8.2.2 Компанийн сонголт	111
8.2.3 Материаллаг байдал	112
8.2.4 Урьдчилсан судалгаа.....	112
8.3 Баталгаажуулалт	113
8.3.1 Засгийн газрын хүлээж авсан дүн	113
8.3.2 Компанийн төлөлт.....	114
8.4 Гэрээ ил тод болгох	114
8.5 ОУИТБС-ын талаарх ойлголт, оролцогч талуудын хамтран ажилласан байдал	115
8.6 ОУИТБС-ын мэдээллийн сан	115
8.7 Кадастрын цахим бүртгэлийн зарим мэдээллийг оновчтой болгох	116
Хавсралт 1(а) Шийдэгдээгүй эцсийн зөрүү- (Компаниудаар).....	117
Хавсралт-1(б) Анхны нэгтгэл, хийгдсэн тохируулга, тохируулгын дараах нэгтгэл-(санхүүгийн урсгалаар)	119
Хавсралт-1(в) Анхны нэгтгэл, хийгдсэн тохируулга, тохируулгын дараах нэгтгэл-(компаниар).....	122
Хавсралт 2. Хамрагдсан компаниудын жагсаалт.....	128
Хавсралт 8. Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын хэрэгжилт	135
Хавсралт 9. Удирдлагын хариуцлагын захидал.....	147
Хавсралт 12. 2013 оны Уулын ажлын төлөвлөгөө, гүйцэтгэлийн судалгаа.....	151
Хавсралт 14. Гэрээний судалгаа	159
Хавсралт 15. Төрийн өмчит компаниудын Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн судалгаа	168
Хавсралт 18. Байгаль орчныг хамгаалах тусгай дансанд 2013 онд төвлөрүүлсэн орлого	172
Хавсралт 19 (а) Компаниудаас 2013 онд үзүүлсэн хандив, дэмжлэгийн дэлгэрэнгүй.....	184
Хавсралт 19 (б) Үүнээс хөгжлийн санд үзүүлсэн хандив, дэмжлэг	205
Хавсралт 20. Орон нутгийн төсөвт төлсөн татвар, төлбөр, хураамж, торгуулийн дэлгэрэнгүй.....	206
Хавсралт 21. Компаниудын ажиллагсдын тоо.....	224
Хавсралт 22. Компанийн 5-аас дээш хувийн хувьцаа эзэмшигчдийн судалгаа	233

Товчлолууд ба Тодорхойлолтууд

АМГ	Ашигт малтмалын газар
АХ	Ажлын хэсэг (ОУИТБС)
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
АТӨЯХАТ	Автотээвэр, өөрөө явагч хэрэгслийн албан татвар
АТГ	Авто тээврийн газар
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
АМХАТЗ	Ашигт малтмалын хайгуул болон ашиглалтын тусгай зөвшөөрөл
Ам.доллар	Америкийн нэгдсэн улсын мөнгөн тэмдэгт (доллар)
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
АНУ	Америкийн нэгдсэн улс
АМГГУУКХ	Ашигт малтмалын газрын Геологи, уул уурхайн кадастрын хэлтэс
АМГУУСХ	Ашигт малтмалын газрын уул уурхай судалгааны хэлтэс
БОНХЯ	Байгаль орчин, ногоон хөгжлийн яам
БГД	Баянгол дүүрэг
БОА	Байгаль Орчны Алба
БО	Байгаль орчин
БОНС барьцаа	Байгаль орчин нөхөн сэргээх барьцаа
БШУЯ	Боловсрол, Шинжлэх Ухааны Яам
БНГ	Байгалийн нөөцийн газар
БЗД	Баянзүрх дүүрэг
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БХГ	Бүтээгдэхүүн хуваах гэрээ
ГЕГ	Гаалийн ерөнхий газар
ГТГ	Газрын тосны газар
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
ГТНАТ	Газрын тосны нөөц ашигласны төлбөр
ГТХАТЗ	Газрын тосны хайгуул болон ашиглалтын тусгай зөвшөөрөл
ЗДТГ	Засаг даргын тамгын газар (нийслэл, аймаг, дүүрэг сум)
ЗД	Засаг дарга
ЗБҮӨАТ	Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар
ЗАСГИЙН	Монголын засгийн газар
ЗАСГИЙН	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
ИГХХУС	Иргэдийг гэмт халдлагаас хамгаалах, урьдчилан сэргийлэх
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ИНБ	Иргэний нийгмийн байгууллага
МБСГ	Мэргэжлийн боловсрол, сургалтын газар
ММНБИ	Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт
МОУИТБС	Монголын олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга
МУУҮА	Монголын уул уурхайн үндэсний ассоциаци
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
МХГ	Мэргэжлийн хяналтын газар (аймгийн)
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
НБОУХ	Нягтлан бодогчдын Олон Улсын Холбоо
ОУИТБС	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга
ОТХАЗ	Олон талт хамтын ажиллагааны зөвлөл
ОНЗЗ	Орон нутгийн засаг захиргаа

ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
УУЯ	Уул уурхайн яам
УНДЕГ	Улсын нийгмийн даатгалын ерөнхий газар
УТОХГ	Улсын төсвийн орлого хяналтын газар
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ҮЗ	Үндэсний зөвлөл
ҮХЭХАТ	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар
СЭЗБЗАСГИЙН	Санхүү, эдийн засгийн бодолго зохицуулалтын газар
СХД	Сонгинохайрхан дүүрэг
ССАЖЯ	Соёл Спорт, Аялал Жуулчлалын Яам
СЯ	Монгол Улсын Сангийн яам
СБД	Сүхбаатар дүүрэг
СЭЗХ	Санхүү, эдийн засгийн хэлтэс
ССБТГ	Хөдөлмөрийн яамны Санхүү, сангийн бодлого төлөвлөлтийн газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ТАН	Төлсөн авсанаа нийтэл
ТЕГ	Татварын ерөнхий газар
ТӨХ	Төрийн өмчийн хороо
ТӨК	Төрийн өмчит компани
ТББ	Төрийн бус байгууллага
Төг.	Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт (төгрөг)
ХГБХТ	Хүүхэд гэр бүл хөгжлийн төв
ХХСТХ	Хүний хөгжлийн сангийн тухай хууль
ХХЕГ	Хил хамгаалах ерөнхий газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХК	Хувьцаат компани
ХЯ	Монгол Улсын Хөдөлмөрийн яам
ЦЭГ	Цөмийн энергийн газар
ЧД	Чингэлтэй дүүрэг
ЭХЭМҮТ	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв

**“ХАРТ НОЙРС” ЛТД
МЭРГЭШСЭН НЯГТЛАН БОДОГЧИД**

89 High Street Thame, Oxfordshire
3EH England

Tel: 44 01844 21 88 36

Website: www.hart-nurse.co.uk

**“УЛААНБААТАР АУДИТ
КОРПОРАЦИ” ХХК**

“Маргад Центр” Төв 4 дүгээр давхар,
Чингэлтэй дүүрэг, 5 дугаар хороо,
Их тойруу, Улаанбаатар хот
Монгол Улс

Утас: 976-11-321844, 329430, 70110744

Факс: 976-11-321844

Вебсайт: www.ulaanbaatar-audit.mn

**Монголын Олборлох Үйлдвэрлэлийн Ил Тод
Байдлын Санаачилгын Ажлын Хэсэг
МОУИТБСАА**

Монгол Улсын ОУИТБС-ын Ажлын Алба
Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, Амарын гудамж,
Туушин компаний байр, 314 тоот

2014 оны 12 сарын 15-ний өдөр

Англи Улсын “Харт Нойрс” Лтд ба Монгол Улсын “Улаанбаатар Аудит Корпораци” ХХК-ийн консерциум нь Монголын ОУИТБСАА-ны зүгээс МОУИТБС-ын 8 дугаар тайлан буюу 2013 оны Нэгтгэлийн ажлыг (“Гэрээт ажил”) хийхээр сонгогдон, гэрээ байгуулсан билээ.

Монголын уул уурхайн болон газрын тосны үйлдвэрлэл, хайгуулын үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжүүдээс 2013 онд Засгийн газарт төлсөн материаллаг төлбөр хийгээд Засгийн газрын хүлээн авсан материаллаг орлогын урсгалын аудитын нэгтгэлийн гэрээт ажлыг 2014 оны 007 дугаар сарын 23-наас 2014 оны 101 дүгээр сарын 15-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ.

Монголын ОУИТБС-ын Ажлын хэсгээс баталсан Гүйцэтгэх ажлын даалгаврт тусгагдсан ажлуудыг Холбогдох үйлчилгээний олон улсын стандарт 4400 буюу Санхүүгийн мэдээлэлд тохиролцсон горимуудыг гүйцэтгэх гэрээт ажлын стандартын дагуу хийж гүйцэтгэсэн.

Бид олж илрүүлсэн зүйлсээ энэхүү тайлан, түүний хавсралтуудаар тайлагнаж байна. Учир нь гүйцэтгэсэн горимууд нь нэгтгэлийн болон шалгах ажлыг АОУС буюу Шалгах Ажлын Олон Улсын Стандартын дагуу гүйцэтгэх зорилго агуулаагүй бөгөөд бидний зүгээс энэхүү тайланд харуулсан тодорхой мэдээллүүд, тэдгээртэй холбогдох аливаа гүйлгээнүүдэд ямар нэгэн баталгаа өгөх үүрэггүй юм.

Энэхүү тайлан нь Ажлын даалгаварт тусгагдсан зүйлсийн хүрээнд Ажлын хэсгийн оролцогч талууд болон Үндэсний Зөвлөлд мэдээлэхэд зориулагдсан болно.

Тус тайлан нь зөвхөн заагдсан зүйлсийн хүрээнд хийгдсэн бөгөөд аливаа нэгэн нэгжийг бүхлээр нь хамарсан санхүүгийн тайлангуудийн хүрээнд хийгдээгүй.

**“Харт Нойрс” Лтд
Мэргэшсэн Нягтлан бодогчид**

**“Улаанбаатар Аудит
Корпораци” ХХК**

1. ОРШИЛ

Энэхүү тайлан нь Монголын ОҮИТБС-ын наймдугаар тайлан буюу 2013 оны Нэгтгэлийн гэрээт ажлын тайлан юм.

Энэхүү тайлан нь Ажлын даалгаварт тусгагдсан зүйлсийн хүрээнд Ажлын хэсэг болон Үндэсний Зөвлөлд мэдээлэхэд зориулагдсан болно.

1.1 ЗОРИЛГО

Энэхүү Гэрээт ажлын зорилго нь ОҮИТБС-ын Стандарт (2013)-ын дагуу Монгол Улсын Засгийн газрын хүлээж авсан орлого болон уул уурхай, газрын тосны салбарын компаниудын төлбөрийн олон нийтэд ил тод, найдвартай байдлыг хангахад оршино. Үүнтэй уялдуулан энэхүү гэрээт ажлаар 2013 онд уул уурхай, газрын тосны салбараас хүлээж авсан материаллаг төлөлтийн нэгтгэл болон шинжилгээг тус салбарын тодорхой онцлогийн дагуу хийгдсэн нэмэлт тайлагнал зэргийг багтааж байна.

1.2 ОҮИТБС-ЫН НЭГТГЭЛД ОРОЛЦОГЧ ТАЛУУД

МОҮИТБС-ын Үндэсний зөвлөлийн шийдвэрийн дагуу уул уурхайн компаниудаас материаллаг төлбөр авч буй Засгийн газрын байгууллага болон энэхүү төлбөрийг төлж буй компаниуд нь энэхүү нэгтгэл тайланд оролцох шаардлагатай.

Нэгтгэлд оролцсон ЗГ-ын байгууллагуудын жагсаалтыг **Хавсралт 4-а, б, Хавсралт 5-д** харуулсан болно.

Тайлангийн шаардлагын дагуу компаниудын бүрэн жагсаалтыг **Хавсралт 2-т**, харин компаниудын мэдээллийг **Хавсралт 6-д** харуулав.

1.3 ТАЙЛАНГИЙН БҮТЭЦ

Энэхүү тайлан нь дараах бүтэцтэй:

1. Оршил
2. Гүйцэтгэлийн хураангуй
3. Монголын олборлох салбарын байдал
 - 3.1 Уул уурхай
 - 3.2 Газрын тос, байгалийн хий
 - 3.3 Үйлвэрлэл
 - 3.4 Эдийн засгийн хувь нэмэр
 - 3.5 Засгийн газрын байгууллагууд

- 3.6 Төрийн өмчит аж ахуйн нэгж
 - 3.7 Төсвийн үйл явц
 - 3.8 Орлогын хуваарилалт
 - 3.9 Уул уурхайн салбарын бодлого
 - 3.10 Лиценз олголтын журам
-
- 4. Нэгтгэл тайлангийн хамрах хүрээ болон арга аргачлал
 - 5. Нэгтгэл тайлангийн үр дүн
 - 6. Ажлын даалгаварт шаардсан нэмэлт судалгаанууд
 - 7. Бусад асуудлууд
 - 8. Зөвлөмж
 - 9. Хавсралт

1.4 ТАЛАРХАЛ

Засгийн газрын харьяа байгууллагууд болон уул, уурхайн компаниудын гол албан тушаалтнуудтай уулзах, тэдэнтэй холбоо тогтоох, холбогдох газруудад захидал явуулах, хүлээн авах зэрэгт дэмжлэг, туслалцаа үзүүлсэн Монголын ОҮИТБС-ын Ажлын албаны нарийн бичгийн дарга, зохицуулагч Ш. Цолмон тэргүүтэй хамт олонд “Харт Нойрс” Лтд болон “Улаанбаатар аудит корпораци” ХХК-ийн хамтарсан консерциумын хамт олон чин сэтгэлийн талархал илэрхийлье.

2. ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУРААНГУЙ

2.1 ТАНИЛЦУУЛГА

Энэ хэсэгт бид дараах зүйлсийг багтаалаа. Үүнд:

1. МОУИТБС-ын нэгтгэл тайлангийн үр дүнгийн хураангуй
2. ЗГ-ын олборлох салбараас орсон орлогын хураангуй
 - а. Хүлээн авагч байгууллагаар
 - б. Төлбөрийн урсгалаар
3. Ажлын даалгаврын дагуу хийгдсэн судалгааны ажлууд
4. Тайланд тусгагдсан бусад асуудлууд

Мөн тайлангийн 2.4-т бид олж ирүүлсэн гол үр дүнгийн тайланг оруулав.

Нэгтгэл тайлангийн үр дүнгийн нарийвчлалыг уг тайлангийн **5 дугаар хэсэг мөн Хавсралт 1-д** оруулсан.

2.2 МОУИТБС-ЫН НЭГТГЭЛ ТАЙЛАНГИЙН ҮР ДҮНГИЙН ХУРААНГУЙ

ЗГ-ын тайлагнасан /Сая төгрөгөөр/	Шийдэгдээгүй зөрүү		Компаниудын тайлагнасан /Сая төгрөгөөр/
	ЗГ-ын тайлагнасан дүн компаниудын дүнгээс илүү /Сая төгрөгөөр/	Компаниудын тайлагнасан дүн ЗГ-ын дүнгээс илүү /Сая төгрөгөөр/	
1,576,014	245	(282)	1,576,051

Хүснэгт-1

Шийдэгдээгүй зөрүүнүүд нь материаллаг бус байна.

2.3 ЗАСГИЙН ГАЗРЫН ОРЛОГО

2.3.1 ОЛБОРЛОХ САЛБАРААС ЗАСГИЙН ГАЗАРТ ОРСОН ОРЛОГО

2.3.1.1.ТӨРИЙН БАЙГУУЛАГУУЛЛАГУУДЫН ХҮЛЭЭЖ АВСАН НИЙТ ОРЛОГО

Нэгтгэлд оролцсон Засгийн газрын байгууллага тус бүрээр тайлагнасан ЗГ-ын нийт төлбөрийг нэгтгэл тайланд орсон дүнгийн хамтаар харуулав:

Сая төгрөгөөр	2013 онд СЯ-ны нэгтгэсэн компанийн нийт орлого ¹	2013 оны ОҮИТБС-н тайланд тайлагнасан орлого	Эзлэх хувь
Сангийн Яам	70,429	70,428	100
Татварын Ерөнхий Газар	1,032,598	965,340	93
Байгаль Орчин, Ногоон Хөгжлийн Яам	1,793	1,292	72
Ашигт Малтмалын Газар	35,064	20,843	59
Газрын Тосны Газар	192,828	190,979	99
Гаалийн Ерөнхий Газар	79,789	70,947	89
Хөдөлмөрийн Яамны Санхүү, сангийн бодлого төлөвлөлтийн газар ²	9,000	13,376	149
Улсын Мэргэжлийн Хяналтын Газар	9,909	1,514	15
Нийгмийн Даатгалын Ерөнхий Газар	141,504	117,460	83
Монгол улсын Цөмийн Энергийн Газар	2,957	1,658	56
Дэд дүн-Засгийн Газар	1,575,871	1,453,837	92
ЗДТГ (аймаг, нийслэл, сум, дүүрэг)			
- аймаг	-	46,807	
- нийслэл	-	20,049	
- сум	-	53,222	
- дүүрэг	-	2,099	
Дэд дүн-Орон нутгийн засаг захиргаа²	107,747	122,177	113
Нийт дүн	1,683,618	1,576,014	92

Хүснэгт-2

(Дэлгэрэнгүйг Хавсралт-1, 3, 20-оос харна уу).

¹Сангийн яам нь 2013 онд олборлох үйлдвэрлэл эрхэлж буй 1,617 компанийн орлогыг нэгтгэж ирүүлсэн.

²Олборлох салбараас орсон орлогын дүнд 2013 оны нэгтгэл тайланд хамрагдсан 250 компанийн орлогын эзлэх хувь өндөр байгаа нь ЗГ анхны нэгтгэлдээ зарим орлогыг дутуу нэгтгэснээс шалтгаалсан байна.

Дээрх хүснэгтээс Засгийн Газрын олборлох салбараас хүлээж авсан орлогыг хүлээн авагч Төрийн байгууллагуудаар харж болно. Дараах графикаар томоохон дүнтэй орлого хүлээж авсан төрийн

байгууллагуудыг тусад нь, 10 тэрбум төгрөгнөөс бага орлоготой төрийн байгууллагуудыг "Бусад" гэсэн хэсэгт харуулав.




График-1

Дараах диграммд ЗГ-ын хүлээж авсан нийт орлогыг улсын болон орон нутгийн төсвөөр харуулав.




График-2

Дараах диграммд нэгтгэлд хамрагдсан компаниудаас ЗГ-ын хүлээж авсан нийт орлогыг улсын болон орон нутгийн төсвөөр харуулав.



График-3

2.3.1.2 Нийт орлогын урсгал

	Сая төгрөгөөр
Улсын төсөвт төлсөн албан татвар, төлбөр, хураамж, ногдол ашиг	1,450,066
Татвар	492,923
Төлбөр	668,216
Үйлчилгээний хураамж	29,278
Төрийн өмчийн ноогдол ногдол ашиг	70,429
ЗГ-ын хүлээж авсан урьдчилгаа төлбөр	187,666
Бусад	1,553
Орон нутгийн төсөвт төлсөн албан татвар, төлбөр, хураамж, ногдол ашиг	86,752
Орон нутгийн төсөвт төлсөн татвар	14,556
Төлбөр	60,582
Орон нутгийн өмчийн ноогдол ашиг	7,817
Бусад	3,797
Төрийн байгууллагад өгсөн хандив, дэмжлэг	39,197
Бусад	-
Дүн	1,576,014
Зөвхөн ЗГ-аас тайлагнасан зүйлс	1,576,014
Зөвхөн компаниудаас тайлагнасан зүйлс	1,576,051

Хүснэгт-3

2.3.2 АЖЛЫН ДААЛГАВРЫН ШААРДЛАГЫН ДАГУУ ХИЙГДСЭН СУДАЛГААНУУД

Ажлын даалгаварт заасны дагуу бид Нэгтгэл тайланд шинээр шинжилгээ, судалгааны ажил хийсэн, тухайлбал:

1. Сангийн сайдын 2010 оны 145 дугаар тушаалын биелэлтийн судалгаа (тайлангийн 6.1-р хэсгээс үзнэ үү).
2. Компаниудын 2013 оны санхүүгийн тайланд СТОУС-ын мөрдөлтийн талаар хийсэн судалгаа (тайлангийн 6.2-р хэсгээс үзнэ үү).
3. Уулын ажлын ба Байгаль Орчныг хамгаалах жилийн төлөвлөгөөний биелэлтийн судалгаа (тайлангийн 6.3 ба 6.4-р хэсгээс үзнэ үү).
4. Компаниудын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн судалгаа (тайлангийн 6.5-р хэсгээс үзнэ үү).
5. Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн дагуу олборлох салбарын компаниуд болон орон нутгийн засаг захиргааны хооронд байгуулсан гэрээний биелэлтийн судалгаа (тайлангийн 6.6-р хэсгээс үзнэ үү).
6. Төрийн болон орон нутгийн өмчит компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийн судалгаа (тайлангийн 6.7-р хэсгээс үзнэ үү).

Энэхүү тайлан нь 2013 оны ОУИТБС-ын стандартад "Олборлох үйлдвэрүүдийг хамарсан мэдээлэл оруулах шаардлагатай" гэж заасны дагуу боловсруулагдсан болно. Тайлангийн 3 дугаар хэсэгт энэхүү шаардлагад нийцэх мэдээллүүдийг багтаасан.

2.3.3 БУСАД АСУУДЛУУД

1. Дэд бүтцийн хөрөнгө оруулалт болон бартерын солилцооны гэрээ (тайлангийн 7.1-р хэсгээс үзнэ үү).
2. Нийгмийн шинжтэй зардал (тайлангийн 7.2-р хэсгээс үзнэ үү).
3. Тээвэр (тайлангийн 7.3-р хэсгээс үзнэ үү).
4. Ашиг Хүртэгч (тайлангийн 7.4-р хэсгээс үзнэ үү).

2.4 ОЛЖ ИЛРҮҮЛСЭН ГОЛ ЗҮЙЛС

Тайлангаас үүсэх гол үр дүнг энэ хэсэгт тайлбарласан байгаа. Тайлангийн 8-р бүлэгт Монгол Улсын ОУИТБС-ын үйл явцтай холбоотой хэд хэдэн зөвлөмжүүдийг өгсөн байгаа, мөн өмнөх тайланд засч залруулах, шинэчлэх явцыг хэрэгжүүлэхийг зөвлөсөн.

2.4.1 НЭГТГЭЛИЙН ХАМРАХ ХҮРЭЭ

2.4.1.1 МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Монголын ОУИТБС-ын Үндэсний зөвлөл нь 2010 оны 06 дугаар сарын 24 хуралдаанаараа олборлох үйлдвэрлэлийн компаниудын зүгээс төрийн байгууллагуудад нийт 10 мянган төгрөгөөс дээш хэмжээний мөнгийг (татвар, төлбөр, хураамж, бусад орлогын нэр төрөл тус бүр дээр) төлсөн л бол тайлагнаж байх ёстой хэмээн тогтоожээ. Улмаар 2013 оны 12 дугаар сарын 23-нд Үндэсний зөвлөлөөс нэгтгэл тайланд хамрагдах 250 компанийг сонгосон байна. 2013 оны нэгтгэлд ашиглах тайлагналын маягтыг 2014 оны 01 дүгээр сарын 3-нд баталсан. Уг маягтад 2010 оны 06 дугаар сарын 24-нд тогтоосон төлбөр дээр нэмэгдэж орсон төлбөрүүд байгаа ч үүнийг нэгтгэл тайлангийн Ажлын удирдамжид тусгаагүй байна. МОУИТБС-ын Ажлын албаны зүгээс бидэнд ЗГ-ын олборлох салбарын компаниудаас хүлээж авсан төлбөрийн мэдээлэл болон нэгтгэлд хамрагдах компаниудын жагсаалтыг гаргаж өгсөн.

2.4.1.2 ЗАСГИЙН ГАЗРЫН ТАЙЛАН

Сангийн Яам Төр, Засгийн болон орон нутгийн засаг захиргааны байгууллагуудаас авсан мэдээллийг нэгтгэн ЗГ-ын хүлээж авсан төлбөрийг харьцуулдаг. Зарчмын хувьд өмнөх жилүүдийн нэгтгэл тайлан мөн энэ процессоор явагдсан бөгөөд ОУИТБС-ын шинэ шаардлагын дагуу энэхүү процессоор ЗГ-ын дүнг татварын урсгалаар (жил бүрийн нэгтгэлийн урсгалд багтаадаг) нь харуулдаг. Мэдээллийг шалгах явцад баталгаажуулалтын албан ёсны процесс байхгүй (2.3, 2.4-өөс харах), зарим мэдээлэл нь алдаатай байгааг (дараагийн бүлгийг харах) ажигласан. Гэхдээ эдгээр нь материаллаг бус хэмжээтэй байсан. Иймэрхүү мэдээллийн баталгаажуулалт нь Нэгтгэл тайлан 2013 оны Ажлын даалгаврын хэсэг биш юм.

2.4.1.3 КОМПАНИЙН СОНГОЛТ

Сангийн яамнаас гаргаж өгсөн ЗГ-ын хүлээж авсан төлбөрийн жагсаалтаас хамгийн их дүнтэй төлөлт хийсэн 250 компаниудыг авч үзэхэд уг компаниудаас 91 компанийг нэгтгэл тайланд хамруулаагүй нь ажиглагдсан.

МОУИТБС-ын Ажлын алба уг жагсаалтыг шалгаж үзээд тухайн компаниудыг Сангийн Яамнаас оруулсан хэдий ч олборлох салбарт идэвхитэй үйл ажиллагаа явуулдаггүй, гол үйл ажиллагаа нь ашигт малтмал, газрын тос юм уу байгалийн хийн салбар биш учраас нэгтгэл тайлангаас хассан гэж тайлбарласан.

Дээр дурдсан шалтгаанаар хасагдсан 91 компанийн оронд сонгосон 91 компанийг авч үзэхэд 20 компанийн төлсөн төлбөр нь Үндэсний зөвлөлөөс тогтоосон босго буюу 40 сая төгрөгөөс доош байгааг олж мэдсэн. Эдгээр компаниуд Үндэсний зөвлөлөөс гаргасан материаллаг байдлын түвшний шийдвэрийн дагуу бол нэгтгэлийн ажлын цар хүрээний гадна үлдэж байгаа юм.

Бид сонголт хийсэн суурийг мөн Ажлын албаны зүгээс нэгтгэлээс хассан аргачлалыг ч шалгаагүй ба Сангийн яаманд тайлагнасан анхны сонголтод асуудал байгаа бололтой. Уг жагсаалтад олборлох үйл ажиллагаа явуулдаггүй эсвэл гол үйл ажиллагаа нь олборлох бус компаниуд байгааг тэмдэглэж байна. Үүнийг дараа жилийн нэгтгэл тайлангаас өмнө шийдвэрлэх нь зүйтэй гэж зөвлөж байна (8-р бүлэг).

Бид 2013 оны нэгтгэл тайлангийн Ажлын удирдамжид заасны дагуу Ажлын хэсгээс сонгосон компаниудыг багтаалаа.

Бид дээр дурдсан асуудлыг харгалзаж үзэн ОУИТБС-ын тайлагналын материаллаг байдлын босгын тал дээр Үндэсний зөвлөлд дэмжлэг болгох үүднээс дараах мэдээллийн шинжилгээг хийлээ.

ЗГ-ын хүлээж авсан төлбөрийн шинжилгээ – СЯ-наас өгсөн мэдээлэл

Хязгаар	Компаний тоо	Төлөлтийн дүн мян.төгрөг	Нийт өссөн хувь	Хүлээн авсан төлбөрийн хязгаарт эзлэх %
>100 тэрбум	4	1,065,508,549	62.7%	62.7%
< 100 тэрбум > 50 тэрбум	2	145,931,013	71.3%	8.6%
< 50 тэрбум > 25 тэрбум	5	191,603,891	82.5%	11.3%
< 25 тэрбум > 10 тэрбум	5	81,339,216	87.3%	4.8%
< 10 тэрбум > 5 тэрбум	6	44,495,848	89.9%	2.6%
<5 тэрбум > 1тэрбум	35	80,745,602	94.7%	4.7%
<1 тэрбум > 900 сая	6	5,724,797	95.0%	0.3%
< 900 сая > 250 сая	90	39,250,020	97.3%	2.3%
< 250 сая > 100 сая	96	17,097,787	98.3%	1.0%
<100 сая	1,368	28,523,149	100.0%	1.7%
Нийт	1,617	1,700,219,871		

Хүснэгт 4

Дээрх хүснэгтээр Засгийн газар 1,617 компаниас 1.7 их наяд төгрөгийн төлбөр хүлээж авсан ба хамгийн том 4 компанийн төлбөр 1.06 их наяд буюу нийт төлбөрийн 62.7% -ийг эзэлж байна. Уг 4 компани нь:

- “Эрдэнэт Үйлдвэр” ХХК
- “Оюу Толгой” ХХК
- “Петрочайна Дачин Тамсаг” ХХК
- “Монголын Алт МАК” ХХК

153 компаниас 250 сая төгрөгөөс дээш төлбөр хүлээж авсан нь жагсаалтад орсон нийт төлбөрийн 97.3%-ийг эзэлж байна. Дээр нь 96 компани нэмж оруулахад санхүүгийн хүрээг ердөө 1%-иар нэмэгдүүлж байгаа ч тайлагнах компанийн тоог бараг гуравны хоёроор өсгөж байна.

Энэ аргачлал нь цаашдын хүчин чармайлт, үр өгөөжийг үнэлэхэд сургамжтай байж болох юм.

2.4.1.4 ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭЛЛИЙН ТАЙЛАГНАЛ БА ХАРЬЦУУЛАЛТ

Компаниудын жагсаалтыг бэлтгэж байгаа үндэслэлийг эргэн харах шаардлагатай ба уг жагсаалтыг шалгах процессыг хийсэн аливаа өөрчлөлттэй харьцуулан бүхлээр нь баримтжуулах шаардлагатай байна.

Нэгтгэлд оролцогч Засгийн газрын байгууллагууд нь зөвхөн Сангийн Ямаар дамжуулан тайлагнахаас илүү тус тусдаа шууд тайлагнадаг болохыг харгалзаж үзэх нь зүйтэй. Ингэснээр тайлагналын процессыг илүү ил тод болгох боломжтой.

2.4.2 БАТАЛГААЖУУЛАЛТ

2.4.2.1 УДИРДЛАГЫН ХАРИУЦЛАГЫН ЗАХИДАЛ - КОМПАНИУД

Бид компаниудын удирдлагад ОУИТБС-ын маягтын дагуу гаргаж өгсөн тайлангийн хариуцлагатай байдлыг “Удирдлагын хариуцлагын захидал”-аар баталгаажуулах хүсэлт гаргасан. Компаниудын ирүүлсэн мэдээлэлд найдаж болох эсэхийг үүгээр баталгаажуулах учраас тайлангийн нэг чухал хэсэг юм. ЗГ-ын орлогын 20%-ийг бүрдүүлж буй 35 компани Удирдлагын хариуцлагын захидал ирүүлээгүй байна (Хүлээж авсан захидлын талаарх дэлгэрэнгүйг **Хавсралт 9-өөс харна уу**. Мөн тайлангийн 8-р бүлэгт энэ хэсэгтэй холоотой зөвлөмжийг орууллаа).

2.4.2.2 АУДИТЫН ТАЙЛАН - КОМПАНИУД

Компаниудаас гаргуулсан хариуцлагын мэдэгдлийн бас нэг хэлбэр нь компаниудын тайлагнасан дүн нь Олон улсын стандартын дагуу аудитлагдсан санхүүгийн тайлантай нь уялдаж буй эсэхийг нягтлах явдал байсан. Тиймээс бид компаниудаас 2013 оны санхүүгийн аудитын тайлангийн хуулбарыг гаргаж өгөхийг хүссэн.

45 компани аудитын тайлангаа өгөөгүй. Харин аудитын тайлангаа гаргаж 205 өгсөн компаниудаас 10 компанийн тайлан аудитаар баталгаажсан байна (дэлгэрэнгүйг 6.2-оос харна уу).

2.4.2.3 КОМПАНИЙН ТОО БАРИМТЫН АУДИТ

Нэгтгэлийн зорилгоор компаниудын тайлагнасан тоон мэдээллийн аудитын нотлох баримтыг сайжруулснаар Монголын ОУИТБС-ын процессын найдвартай байдал хангагдана. Олон оронд томоохон компаниудын ОУИТБС-ын тайланг тухайн компанийн аудиторын гарын үсгээр баталгаажуулах практик бий. Монгол Улс ОУИТБС-ын нэгтгэл тайланг 8 дах жилдээ гаргаж байгаагийн хувьд энэ хэсгийг сайжруулах шаардлагатай байна.

2013 онд ОУИТБС-ын тайлангаа гаргаж өгсөн компаниудаас 10 компанийн ОУИТБС-ын тайлан аудитаар баталгаажсан байна.

Ингэж хувийн голлох компаниудаас аудитын баталгаажуулалт авахын хажуугаар төрийн өмчит аж ахуй нэгжүүдээс ч ижил төрлийн баталгаажуулалт гаргуулах нь зүйтэй.

2.4.2.4 ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭЛЛИЙН БАТАЛГААЖУУЛАЛТ

Төрийн байгууллагууд жил бүр Үндэсний Аудитын Газраар аудит хийлгэх үүрэгтэй байдаг. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой, мөн орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой ААН-үүд жил бүр аудитаа Үндэсний Аудитын Газар эсвэл уг газраас томилогдсон мэргэжлийн аудитын байгууллагаар хийлгэдэг.

Засгийн газрын тайланд Сангийн Яамны Төрийн нарийн бичгийн дарга гарын үсэг зурдаг. Гэвч ЗГ-ын тайланд ямар нэг хариуцлагын мэдэгдэл юм уу баталгаажуулалт ОУИТБС-ын Хараат бус нэгтгэгчид гаргаж өгөөгүй бөгөөд ЗГ-ын уг гарын үсэг юуг төлөөлж буй нь тодорхойгүй байна. Энэ нь нэгтгэлийн зорилгоор ЗГ-ын дүнг шалгах ажлын нэг хэсэг учраас сайжруулах хэсэг юм.

2.4.3 ГЭРЭЭ ИЛ ТОД БОЛГОХ

ОУИТБС-ын Стандартын 3.12-т: а) Санаачлагыг хэрэгжүүлэгч орнууд нь ашигт малтмал, байгалийн хий, газрын тос олборлохоор хийсэн бүх гэрээ, гэрээний нөхцлийн талаарх мэдээллийг ил тод болгоход хүчин чармайлт гарган ажиллана. б) ОУИТБС-ын тайланд ашигт малтмал, байгалийн хий, газрын тос олборлохоор хийсэн гэрээ, лицензийг ил тод болгох тал дээр Засгийн газар ямар бодлого барин ажиллаж буйг тайлбарлан оруулсан байх шаардлагатай гэж заасан байдаг.

Бид газрын тосны компаниудад Бүтээгдэхүүн хуваах гэрээний талаар хандсан боловч компаниуд БХГ олон хуудастай, зузаан учраас хуулбарыг гаргаж өгөхгүй, харин Газрын тосны газраас уг гэрээний хуулбарыг гаргуулж авахад тэдний зүгээс эсэргүүцэх зүйлгүй гэж хариулсан.

Бид Уул уурхайн сайдад Монголын ОУИТБС-ын 2013 оны тайланг бэлтгэхтэй холбогдуулан Газрын тосны газарт мэдээлэл авах хүсэлт гаргах тухай тайлбарлан энэ талаар ЗГ-ын бодлогын талаар мэдэгдэл хийхийг хүсч албан бичиг хүргүүлсэн. Мөн хэрэв уг хүсэлттэй холбоотой нууцлалын асуудал байгаа бол ЗГ энэ тал дээр ямар арга хэмжээ авах төлөвтэй байгаа талаар тайлбарлахыг мөн хүссэн.

Уул уурхайн дэд сайд бидэнд дараах хариултыг өгсөн: “ОУИТБС-ын 2013 оны нэгтгэл тайланд оруулах Бүтээгдэхүүн хуваах гэрээний үндсэн нөхцлүүд нь өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжоор ямар нэгэн нууцлалын зүйлд хамруулсан зохицуулалт байхгүй байна. Иймд танай гаргасан хүсэлтэд нөлөөлөх нууцлалын асуудал байхгүй гэж үзэж байна.”

Бид Газрын тосны газрын ахлах албан тушаалтнуудтай уулзаж, БХГ-ний хуулбар гаргаж өгөхийг хүссэн. Тэд нууцлалын асуудал байгаа учраас гэрээлэгч компаниудын зөвшөөрөлгүйгээр хуулбарыг гаргаж өгөх боломжгүй гэж тайлбарласан. Ингэхдээ загвар БХГ-ний 12 дугаар зүйлд нууцлалын заалт байгаа талаар ишлэж тайлбарласан. Харин 12 дугаар зүйл нь зөвхөн тухайн зүйлдээ орсон мэдээллийг

хамарч байгаа болохоос биш БХГ дэх ЗГ-ын оролцоотой холбоотой асуудал хамаагүй гэдгийг ажигласан.

Уулзалтын дараа бид Газрын тосны газарт дараах мэдээллийг хүссэн албан бичиг хүргүүлсэн:

- Бүтээгдэхүүн Хуваах Гэрээ нэг бүрийн гарын үсэг зурсан талууд
- Бүтээгдэхүүн Хуваах Гэрээ нэг бүрт заасан Монгол улсын Засгийн газрын хүртэх хувь оролцоо

Газрын тосны газар мөн л нууцлал гэсэн үндэслэлээр гаргаж өгөхөөс татгалзсан.

2.4.4 НЭГТГЭЛИЙН ҮР ДҮН

2.4.4.1 НЭГТГЭЛИЙН ТОЙМ

Засгийн газрын байгууллага болон компаниудаас ирсэн анхны тайланг харьцуулахад анхны нэгтгэлийн зөрүүний дүн нь өмнө жилүүдийнхээс бага байгаа нь анзаарагдсан. Нэгтгэлийг дүгнэхэд, зөрүүний нийт дүн бага бөгөөд төрийн байгууллагуудын хүлээн авсан дүн компаниудын дүнгээс их, багаар тайлагнасан дүнг харахад мөн их хэмжээтэй биш байна.

2013 оны санхүүгийн нийт урсгал

(сая төгрөгөөр)

№	Үзүүлэлт	Анхны нэгтгэл			Тохируулга			Тохируулгын дараа		
		ЗГ	Компани	Зөрүү	ЗГ	Компани	Зөрүү	ЗГ	Компани	Зөрүү
1	Улсын төсөвт төлсөн албан татвар, төлбөр, хураамж, ногдол ашиг	1,473,336	1,428,787	44,549	(20,792)	23,604	(44,396)	1,452,544	1,452,392	153
1.1	Татвар	518,064	548,698	(30,634)	(25,140)	(55,741)	30,601	492,923	492,957	(33)
1.2	Төлбөр	666,425	623,566	42,859	4,270	46,932	(42,662)	670,695	670,497	197
1.3	Үйлчилгээний хураамж	30,571	19,395	11,176	(1,292)	9,883	(11,175)	29,278	29,278	1
1.4	Төрийн өмчийн ногдол ашиг	70,429	70,434	(6)	-	(6)	6	70,429	70,429	-
1.5	Засгийн газрын хүлээн авсан урьдчилгаа төлбөрүүд	187,666	128,705	58,961	-	58,961	(58,961)	187,666	187,666	-
1.6	Бусад	182	37,990	(37,808)	1,371	(36,425)	37,796	1,553	1,565	(12)
2	Орон нутгийн төсөвт төлсөн албан татвар, төлбөр, хураамж, ногдол ашиг	114,609	113,781	828	(30,336)	(29,392)	(943)	84,273	84,389	(116)
2.1	Орон нутгийн төсөвт төлсөн албан татвар	14,733	14,324	409	(177)	244	(421)	14,556	14,568	(12)
2.2	Төлбөр	65,696	64,501	1,195	(7,593)	(6,350)	(1,243)	58,103	58,151	(48)
2.3	Орон нутгийн төрийн өмчийн ногдол ашиг	7,815	18	7,797	2	7,799	(7,797)	7,817	7,817	-
2.4	Бусад	26,365	34,938	(8,573)	(22,568)	(31,085)	8,518	3,797	3,853	(56)
3	Төрийн байгууллагад өгсөн хандив, дэмжлэг	11,684	22,517	(10,833)	27,512	16,753	10,759	39,197	39,270	(74)
	Нийт	1,599,629	1,565,086	34,544	(23,615)	10,965	(34,581)	1,576,014	1,576,051	(37)

Хүснэгт 5

Нэгтгэлд хамрагдах шаардлагатай компанийн тоо тогтмол өсч байгаатай холбогдуулан бид Үндэсний зөвлөлд олборлох салбарын компаниудын өргөн хүрээтэй оролцоо болон уг салбарт учруулж буй тайлагналын дарамтыг эргэн харахыг санал болгож байна. Материаллыг байдлын асуудлыг тайлангийн 2.3.1.3-р хэсгээс харна уу.

МОУИТБС-ын 2013 оны нэгтгэл тайланд хамрагдсан компанийг доорх хүснэгтгээр харуулж байна.

(Дэлгэрэнгүй жагсаалтыг **Хавсралт-2-оос харна уу**).

Үйл ажиллагаа	Тоо
Ашигт малтмалын олборлолт	120
Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч	100
Хайгуул болон олборлолт	20
Газрын тосны хайгуул	6
Газрын тосны олборлолт	2
Цацраг идэвхт ашигт малтмалын хайгуул	2
Нийт	250

Хүснэгт 6

Жил бүрийн нэгтгэл тайланд орсон компанийн тоо

	Он							
	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013
АМГ-т бүртгэлтэй лиценз эзэмшигч компанийн тоо					1,900	1,840		1,691
ОУИТБС-ын тайлан гаргасан компаниудын тоо	64	102	115	129	264	300	1,531	1,198
Сангийн яамнаас гаргасан тайланд хамрагдсан компаниудын тоо	137	184	184	363	478	518	1,829	1,617
Монгол улсын нэгдсэн тайланд хамруулахаар Үндэсний зөвлөлөөс шийдвэрлэсэн компаниудын тоо	25	38	46	101	150	200	200	250
Анхны нэгтгэлийн цэвэр зөрүү*-(сая төгрөгөөр)	(96,827)	(23,442)	(47,149)	(265,508)	11,133	477,553	150,374	34,544

Хүснэгт 7

Доорх хүснэгтэд анхны зөрүү нь 60 тэрбум төгрөгнөөс давсан компаниудыг нэг бүрээр, бусад компаниудыг нийт (эерэг, сөрөг) дүнгээр харууллаа. Үүнээс харахад 250 компанийн анхны нийт зөрүүний ихэнх нь хүснэгт 8-д дурдсан 6 компани дээр үүссэн бөгөөд тайлагнасан нийт дүн 1,599,629 сая төгрөгтэй харьцуулбал дөнгөж 2 хувийг эзэлж байгаа нь томоохон биш байсан.

Хэдий тийм боловч Хараат бус нэгтгэгч, ЗГ болон тайлагнагч компаниуд аль алинаас гаргасан хүчин чармайлтын ихээхэн хэсэг нь тайлагнасан нийт дүнгээр аваад үзэхэд материаллаг бус дүнгүүдийг тодорхойлох ажил руу чиглэгдсэн байна.

Томоохон зөрүүг дараах хүснэгтээр харуулж байна.

д/д	Компанийн нэр	Эерэг зөрүү [1](+)	Хувь	Сөрөг зөрүү [2](-)	Хувь	Цэвэр зөрүү [3]
1	Таван толгой ХК	68,017	38	-	-	68,017
2	Петрочайна дачин тамсаг ХХК	49,768	28	-	-	49,768
3	Эрдэнэт үйлдвэр ХХК	34,236	19	-	-	34,236
4	Энержи ресурс ХХК	-	-	(60,653)	42	(60,653)
5	Оюу Толгой ХХК	-	-	(34,267)	24	(34,267)
6	Саусгоби сэндс ХХК	-	-	(9,740)	7	(9,740)
7	Бусад	25,496	14	(38,313)	27	(12,817)
	Нийт	177,517	100	(142,973)	100	34,544

Хүснэгт 8

[1]- ЗГ-ын хүлээн авсан дүн компанийн төлсөн дүнгээс их

[2]- ЗГ-ын хүлээн авсан дүн компанийн төлсөн дүнгээс бага

[3]- Эерэг сөрөг зөрүүний нийлбэр дүн

Нэгтгэл тайланд хамрагдах шалгуурыг эргэн харах нь зүйтэй гэж бид зөвлөж байна. Ингэснээр МОУИТБС-ын зорилтуудад олборлох салбарт аливаа шаардлагагүй дарамт учруулалгүйгээр хүрч болох ба мөн ингэснээр ЗГ-ын нөөцийг уг салбарын үнэ цэнийг нэмэгдүүлэхэд чиглүүлэх юм. Цахим бүртгэлийн систем боловсруулж, тайлагналын түвшинг дээшлүүлэхийн зэрэгцээ тайланд шаардагдах ажиллагаа багасч байгааг бид ойлгож байна.

2.4.4.2 НЭГТГЭСЭН ЗҮЙЛСИЙН ОНЦЛОГ

ОУИТБС-ын тайлагнал сайжирч, зөрүү багасч байгаа тухай бид дээр дурьдсан ч зарим асуудал хэвээр байна. Үүнд:

- Компаниуд төлбөрөө мөнгөн сууриар бус аккруэл сууриар тайлагнасан.
- Зарим тохиолдолд мэдээлэл бэлтгэхдээ хангалттай ач холбогдол өгөөгүй.
- Компаниуд Гаалийн ерөнхий газарт төлсөн гаалийн татвараа нэгтгэлд багтсан эсэхээс үл хамааран бүтнээр нь гаалийн албан татварт тайлагнасан.
- Зарим тохиолдолд тайлагнасан дүнтэй холбоотой нотлох баримт болон хангалттай тайлбар авахад бэрхшээлтэй байсан.

Энэ нь харилцаа холбоог сайжруулах болон сургалт явуулах шаардлагатайг харуулж байгаа ба ингэснээр цаашдын нэгтгэлийн ажил сайжрах юм. Мөн компаниуд ОУИТБС-ын тайлагналын шаардлагыг өөрсдийн тайлагналыг системдээ багтаах хэрэгтэй байна.

ЗГ-ын тайланд томоохон материаллаг дүн бүхий орлогыг орхигдуулсан алдаа гараагүй бөгөөд хамгийн онцлох зүйл гэвэл ЗГ 2013 онд “Оюу Толгой” ХХК-иас нийт 40,597 сая төгрөг хүлээж авсан гэж тайлагнасан байна. Гэхдээ энэ нь тус компаниас 2013 онд мөнгөөр хүлээн авсан санхүүгийн урсгал биш байсан. Учир нь Оюутолгой ХХК нь 2013 онд ногдуулсан 40,597 сая төгрөгийн татварыг 2010 онд төлсөн 50 сая ам.долларын урьдчилгаа төлбөрөөс суутган тооцуулсан ба уг төлбөрийг МОУИТБС-ын 2010 оны нэгтгэл тайланд “Засгийн газрын хүлээн авсан урьдчилгаа төлбөр” гэсэн ангилалд оруулан нэгтгэж байсан дүн юм.

2.4.5 НЭГТГЭЛД ХАМРАГДСАН БОЛОВЧ НЭГТГЭЛИЙН АЖИЛД ОРОЛЦООГҮЙ АЖ АХУЙН НЭГЖҮҮД

Нэгтгэлд хамрагдсан бүх төрийн байгууллагууд нь нэгтгэлийн явцад нэгтгэгчээс хүссэн мэдээллийг гаргаж өгсөн.

Доорх компаниас бусад бүх компаниуд тайлангаа гаргаж өгсөн:

- Монголболгаргео ХХК

Доорх 2 компаниас анхны нэгтгэлээр үүссэн зөрүүгийн шалтгааныг тодруулах, зөрүүг тохируулах зорилгоор, хэд хэдэн удаа хүсэлт гаргасан боловч хариу өгөөгүй болно.

- Бужгар Орд ХХК

- Угалзан Цамхаг ХХК

Эдгээр компаниудтай холбоотой мэдээллийг доор харууллаа:

.5.1 Монголболгаргео ХХК

Ерөнхий №	Компанийн Нэр	Бүртгэлийн №	Анхны зөрүү (мян.төгрөг)		Зөрүү
			ЗГ	Компани	
108	Монголболгаргео ХХК	5340624	160,710.1	-	160,710.1

Хүснэгт 9

Уул уурхайн кадастрийн бүртгэлээс харахад энэ компанид 3-н ашиглалтын тусгай зөвшөөрөл байна.

Үүнд:

- MV 000015 Баянхонгор аймгийн Бөмбөгөр суманд Далд-2
- MV 000311 Баянхонгор аймгийн Баян-Овоо суманд Жаргалантын ам
- MV 000456 Баянхонгор аймгийн Галуут суманд Мухар эрэг, Өвөрчулуут, Сайрын худаг

Тус компани 2011 оны ОУИТБС-ын тайланд 612 сая, 2012 оны тайланд 400 сая төгрөгийн төлбөрийг төлсөн гэж тайлагнасан боловч бас л уг төлсөн төлбөрийн болон ЗГ-ын хүлээж авсан тайлангийн хоорондын зөрүүнд тайлбар өгөөгүй байна.

Тус компанийн орхигдуулсан төлбөр нь материаллаг бус байна.

2.4.5.2 Бужгар Орд ХХК

Ерөнхий №	Компанийн Нэр	Бүртгэлийн №	Анхны зөрүү (мян.төгрөг)		Зөрүү
			ЗГ	Компани	
41	Бужгар Орд ХХК	5222443	45,025.9	116,871.6	(71,845.7)

Хүснэгт 10

Шийдэгдээгүй зөрүү нь материаллаг бус байна

2.4.5.3 Угалзан цамхаг ХХК

Ерөнхий №	Компанийн Нэр	Бүртгэлийн №	Анхны зөрүү (мян.төгрөг)		Зөрүү
			ЗГ	Компани	
177	Угалзан цамхаг ХХК	5171881	96,274.5	81,395.1	14,879.4

Хүснэгт 11

Шийдэгдээгүй зөрүү нь материаллаг бус байна

2.4.6 УЛСЫН ТӨСВИЙН ТАЙЛАГНАЛ

Олборлох салбараас Монгол улсын эдийн засагт үзүүлж буй хувь нэмрийг хянаж үзэхэд ЗГ-ын нийтэлсэн орлогын дүн нь уг салбараас хүлээж авсан бүх орлогыг тодорхойлохгүй байгааг ажиглалаа. Жишээ нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар. ЗГ-ын тайлагналын суурь тогтолцоог

сайжруулснаар иймэрхүү мэдээллийг хялбархан тайлагнах боломжтой болох байх. Үндэсний Зөвлөл Сангийн Яамтай энэ асуудлаар цаашид ярилцах нь зүйтэй.

2.4.7 ШИЙДЭГДЭЭГҮЙ ЗӨРҮҮНҮҮД

Шийдэгдээгүй нийт зөрүү нь санхүүгийн хувьд материаллаг биш байна. Бидний ажигласнаар Засгийн газар талаас шалтгаалан шийдэгдээгүй үлдсэн зөрүүний 67 хувийг Орон нутгийн засаг захиргааны байгууллага, 29 хувийг Гаалийн ерөнхий газар, 4 хувийг Сангийн яам эзэлж байна.

Гаалийн ерөнхий газартай харилцаж ажиллахад хүндрэлтэй байсан ба үүссэн зөрүүг шийдвэрлэх тал дээр шуурхай дэмжлэг үзүүлээгүй.

2.4.8 НЭГТГЭЛИЙН АЖЛЫН ХУГАЦАА

Нэгтгэл тайлангийн ажил эхэлсэн хугацаа нь олборлох үйлдвэрлэл эрхэлж буй компаниудын ид ажлын үе, мөн ихэнх Төр, Засгийн байгууллага болон аж ахуйн нэгжүүдэд ажиллагсдын ээлжийн амралтын үетэй давхцаж байсан учраас, компаниуд болон Төр, Засгийн байгууллагаас тайлангийн явцад тодруулах мэдээлэл албан бичигт дурьдсан хугацаанд ирээгүй, хугацаа их алдсан.

2.4.9 ОРОЛЦОГЧ БАЙГУУЛЛАГУУДЫН ХАРИУ ӨГСӨН БАЙДАЛ

Ерөнхийдөө оролцогч байгууллагуудын хариулт хангалттай байлаа. Гэхдээ ОУИТБС-ын үндэс суурь болон нэгтгэл ажлын учир шалтгааныг зарим компанийн ажилтнуудад тайлбарлах шаардлагатай үе хэд хэд гарсан бөгөөд энэ талаар нэмэлт ажил шаардлагатай байна.

Ялангуяа дараах байгууллагуудтай харилцахад бэрхшээлтэй байлаа. Үүнд:

- Гаалийн ерөнхий газар
- Баянгол дүүргийн Татварын хэлтэс
- Сонгинохайрхан дүүргийн Өмч, газрын харилцааны алба
- Сүхбаатар дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс
- Сүхбаатар дүүргийн Татварын хэлтэс
- Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс

Дээрх байгууллагууд мэдээллээ удаан гаргаж өгдөг мөн мэдээлэл өгөхдөө заавал ахлах албан тушаалтнаас зөвшөөрөл авдаг зэрэг нь бэрхшээл учруулсан.

Оролцогч байгууллагуудын оролцооны үнэлгээг **Хавсралт 16, 17-д** харуулав.

2.5 НЭГТГЭЛИЙН ҮР ДҮНГИЙН ШИНЖИЛГЭЭ

2.5.1 ХАМГИЙН ИХ ОРЛОГО ТӨВЛӨРҮҮЛСЭН КОМПАНИУД

Улс болон орон нутгийн төсөвт хамгийн их орлого төвлөрүүлсэн 10 компанийг өмнөх онтой нь зэрэгцүүлбэл:




График 4

Дээрх диаграмаас харахад 2 оны байдлаар “Эрдэнэт Үйлдвэр” ХХК хамгийн өндөр орлогыг төвлөрүүлсэн байна.

2.5.2 КОМПАНИУДЫН УУЛ УУРХАЙН БАЙРШИЛ

Ашигт малтмалын нөөц аль орон нутагт илүү их зонхилж байгааг ОУИТБС-ын нэгтгэлийн тайланд орсон 250 компаниудын мэдээлэлд үндэслэн гаргахад дараах байдалтай байна.




График 5

2.5.3 КОМПАНИУДААС 2013 ОНД УЛСЫН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛСЭН ОРЛОГО

Монгол Улсын Засгийн газарт 2013 оны татварын жилд төвлөрүүлсэн татвар, төлбөр, хураамж, хандив, дэмжлэгийн хэмжээг нэгтгэлд хамрагдсан 250 компанийг үйл ажиллагааны чиглэлээр нь бүлэглэн авч үзвэл дараах байдалтай байна.

(сая төгрөгөөр)





График 6

2013 онд Засгийн газрын хүлээн авсан орлогын 52 хувийг зэс, молибден, 22 хувийг нүүрс, 12 хувийг газрын тосны орлого эзэлж байна.

2.5.4 ОРОН НУТГИЙН ТӨСӨВТ ТӨЛСӨН ТАТВАР, ТӨЛБӨРИЙН ШИНЖИЛГЭЭ

Орон нутгийн төсөвт төлсөн 82,980,700 мянган төгрөгийн татвар, төлбөр, торгуулийг доорх хүснэгтэнд хүлээн авсан аймаг тус бүрээр харуулж байна. Хүлээн авагч болон татвар, төлбөрийн төрөл тус бүрээр **Хавсралт-20-д харуулсан** болно.

Хүлээн авагч аймгууд	Орлогын дүн (мян.төг)	Эзлэх хувь
Өмнөговь	43,452,814	52
Орхон	12,575,688	15
Булган	11,513,259	14
Нийслэл	3,444,855	4
Сэлэнгэ	2,859,754	3
Төв	2,165,238	3
Дорнод	1,545,283	2
Бусад	5,423,808	7
Дүн	82,980,700	100




Хүснэгт 12, График 7

2.5.5 КОМПАНИУДААС ҮЗҮҮЛСЭН ХАНДИВ, ДЭМЖЛЭГИЙН ШИНЖИЛГЭЭ

Компаниудаас 2013 онд Төрийн байгууллага болон орон нутгийн засаг захиргааны байгууллагад 39.27 тэрбум төгрөгийн хандив, дэмжлэг үзүүлсэн гэж тайлагнасаны дагуу холбогдох байгууллагуудаас тайлбар, нотолгоо авч зохих тохируулгыг хийсний эцэст 39.20 тэрбум төгрөгийн хандив, дэмжлэг хүлээн авсан байна. Хамгийн их хандив, дэмжлэг хүлээн авсан байгууллагыг нэрээр нь 800 сая төгрөгнөөс доош хандив, дэмжлэг хүлээн авсан байгууллагыг “Бусад” гэж ангилан доорх хүснэгтээр харуулж байна. **Дэлгэрэнгүйг Хавсралт-19-өөс харна уу.**

Хүлээн авагч	Хүлээн авсан хандив (мян.төг)	Эзлэх хувь
Өмнөговь аймаг	16,717,916	43
Мэргэжлийн боловсрол, сургалтын газар	11,480,166	29
Налайх дүүрэг- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	4,178,810	11
Төв аймаг	1,865,308	5
Сүхбаатар аймаг	1,051,126	3
Бусад	3,903,178	10
Дүн	39,196,504	100



Хүснэгт 13, График 8

2.5.6 ШИЙДЭГДЭЭГҮЙ ЗӨРҮҮНИЙ ШИНЖИЛГЭЭ

Өмнө дурдсанчлан нэгтгэлийн шийдэгдээгүй зөрүү материаллаг биш байна. Шийдэгдээгүй хэвээр үлдэж буй зөрүүг дараах графикууаар харууллаа. Эхний график төрийн байгууллагаас шалтгаалан шийдэгдээгүй үлдсэн зөрүүг, харин дараагийн график компаниудыг тодотгон харуулж байна.

Уг зөрүү нь компани төлсөн болохоо нотлон анхан шатны баримтаа хувилж ирүүлсэн, харин төрийн байгууллагаас хүлээн аваагүй гэсэн хариу өгсөн. *(Дэлгэрэнгүйг хавсралт-23-аас харна уу).*

Төрийн байгууллагаас шалтгаалсан шийдэгдээгүй зөрүү




График 9

Компаниас шалтгаалсан шийдэгдээгүй зөрүү




График 10


Дээрх компаниуд нэгтгэл тайлангийн явцад мэдээлэл гаргаж өгөөгүйгээс шалтгаалан зөрүү шийдвэрлэгдээгүй үлдсэн байна.

3. МОНГОЛЫН УУЛ УУРХАЙН САЛБАР

3.1 УУЛ УУРХАЙ1

Монгол Улсын Засгийн Газар олборлох үйлдвэрүүдийг улс оронд ашиг оруулна хэмээн үзэж их дэмждэг. Монгол Улс нь гангийн үйлдвэрлэлд шаардлагатай коксжих нүүрсээр баялаг бөгөөд дэлхийн хамгийн том ган үйлдвэрлэгч орон болох Хятад улстай хил залгаа ойрхон оршдог бөгөөд гангийн 80 гаруй хувийн худалдааг Хятад улстай хийдэг. Хятад улс зэс-алтны хамгийн том хэрэглэгч улс байхын зэрэгцээ Энэтхэг улсад ч зэс-алтны зах зээл өсөх хандлагатай байнга энэ үед Монгол Улсад зэс-алтны хамгийн том уурхайн төсөл хэрэгжиж байгаа юм. Япон, Солонгос, Тайванийн мөн Оросын хэрэглэгчдийг ашигт малтмалын нөөцөөр хангах зорилготойгоор Транссибирийн төмөр замын болон Алс Дорнодын боомт хүртэл 1000 км төмөр замын холболт бий болгох хэтийн төлөвлөгөө байдаг. Нүүрс, зэсний зах зээлийг мөн төмөр, алт, мөнгө, жоншны худалдан авагчдыг олж чадна гэдэгт Монгол Улс найдаж байна.

Доорх газрын зургаар Монгол Улсын Ашигт малтмалын тухай хуульд заасны дагуу Монгол Улсын



Засгийн Газраас тодорхойлсон 15 чухал ашигт малтмалын орд газруудыг үзүүлж байна.

Эх сурвалж: www.unuudur.com

2020 он гэхэд Уул уурхайн салбараас орох орлого нь ДНБ-ийг гурав дахин өсгөх төлөвтэй байна. Олборлох үйлдвэрлэл нь цахилгаан станц, дэд бүтэц барих, нүүрс угаах, металл боловсруулах үйлдвэрүүд барих зэрэг Монгол Улсын эдийн засгийн өргөн хүрээг хамарсан үйл ажиллагаануудыг бий

¹ Эх сурвалж: "Уолл Стрийт" сэтгүүл, Рио Тинто груп; Шинэ интернационализмыг баримтлагч, Эмерсоны "Үйл ажиллагааны менежмент"; Хамгаалагч; Их Британийн радио телевизийн компани, Олон улсын валютын сан, "Монголын Уул Уурхай" сэтгүүл; "Нүүрс Монгол 2014" бага хурал, "Уул Уурхай" сэтгүүл; АНУ-ын Эрчим хүчний мэдээллийн удирдлага, Блүүмбэрг, Оксфордын бизнес групп; АНУ-ын Геологийн судалгаа; MD мэдээ; Санхүүгийн мэдээ; Ерөнхий Бизнес Мэдээллийн алба; Эрдэнэт үйлдвэр, Монгол Улсын эдийн засаг; ЭЗЭШХ, МУИС, УУ-н салбар дахь тэргүүлэгчид; Бичил уурхайн-хурдац, НҮБ-ын БОХ, Бэрэн уурхай ХК, Монголын дуу хоолой; Монголын Ресоурс Корпораци, Монгол мэдээ дамжуулагч, Монголын ЦЭГ.

болгож байна. Сүүлийн үеийн хууль тогтоомж нь уул уурхайн орлогын хариуцлагатай, тогтвортой зарцуулалтыг хангах асуудалруу чиглэгдэж байна.

Монгол Улсын Засгийн газар Төрийн өмчит Эрдэнэс Тавантолгой компанийн Таван Толгой нүүрсний уурхайн төслийг өргөжүүлэх зорилгоор нээлттэй зах зээл дээр гаргасан хувьцаанаас иргэн бүрт 536 ширхэг хувьцаа өгөхөөр амалсан.

3.1.1 НҮҮРС

Монгол Улсын хувьд Нүүрс нь үнэ болон хэмжээгээрээ экспортын хамгийн том бүтээгдэхүүн юм. Монгол Улсын хэмжээнд 300 гаруй мэдэгдсэн нүүрсний ордод 152 тэрбум тонн нүүрсний таамаг нөөц байгаагийн 19.5 тэрбум тонны нөөц нь нарийвчилсан эрэл хайгуулын үр дүнд аль хэдийн тогтоогдоод байна.

2012 оны байдлаар Монгол Улс нүүрс үйлдвэрлэлээрээ дэлхийд 20-д орж байсан. Нүүрс бол дотоодод ч олон улсад ч чухал чухал нөөц юм. 2014 онд Монгол Улсын нүүрсний экспорт 28,5 сая тоннд хүрч үүний 90% нь Хятад улсруу экспортод гарахаар төлөвлөгдөж байна. Нүүрсний экспортын хэмжээ 2009 онд нийт олборлосон нүүрсний 44%-д хүрч байсан бол энэ хувь 2012 он гэхэд 56%-иас илүү болсон байна. Үүний зэрэгцээ, 2012 онд үйлдвэрлэсэн эрчим хүчний 98%-ийг нүүрсний цахилгаан станцаас гаргаж авсан байна.

Таван толгой төсөл нь дэлхийн томоохон нүүрсний ордуудын нэг бөгөөд 6 сая тонны таамаг нөөцтэй. Төрийн өмчит Эрдэнэс Таван Толгой ХК нь тус ордын олборлолтын эрхийг эзэмшдэг бөгөөд тендерээр хамгийн өндөр оноо авсан оролцогч компаниар олборлолтын ажил гүйцэтгүүлдэг. 2012 оноос хойш Австралийн Макмахон Холдинг ХХК-нь тус ордын 6 хэсгийн 5-д нь үйл ажиллагаа явуулах гэрээтэй ажиллаж байгаа ба энэхүү гэрээ нь 2017 онд дуусах юм. “Монголын Уул уурхайн корпораци” буюу “ММС” үлдсэн нэг хэсэг дээр үйл ажиллагаа явуулж байгаа юм. Тус уурхайгаас олборлосон нүүрсний ихэнхийг Хятад улсын Хөнгөн цагааны корпораци руу гаргадаг байна.

3.1.1.1 НҮҮРС ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХЭТИЙН ТӨЛӨВ

Монгол Улсын нүүрсний зах зээл бараг бүхэлдээ БНХАУ-аас хамааралтай хэвээр байгаа боловч 2011 оны 1 дүгээр сард Монгол Улс үнэ тогтоолт дээр санал зөрөлдсөний улмаас тус улс руу гаргах нүүрсний экспортыг дөрвөн сарын хугацаагаар түр зогсоосон. Монгол Улс Владивосток боомтоор дайруулан тээврийн маршрут бий болгох замаар өөрийн харилцагчдыг тэлж дэлхий нийтэд нүүрсээ экспортлохыг зорьж байна.

3.1.2 ЗЭС

Монгол Улсын хэмжээнд зэс нь үнийхээ хувьд хоёр дахь, хэмжээнийхээ хувьд дөрөв дэхь том экспортын бараа юм. 2012 оны байдлаар Монгол Улсын зэсийн батлагдсан нөөц нь 12-14 сая тонн, таамаг нөөц нь 84 сая тонн байсан ба зэсийн нөөцөөрөө дэлхийд 12-т орж байсан байна. Монгол Улсын хэмжээнд зэс үйлдвэрлэх хоёр төсөл байдгийн нэг нь Оюу Толгойн орд юм. Оюу толгой

уурхай нь Монгол Улсын өмнөд хэсэг Говийн бүсэд орших ба нийслэл Улаанбаатар хотоос өмнө зүгт 550 км-т оршдог. Нөгөө нь Эрдэнэт орд бөгөөд Улаанбаатар хотоос баруун хойд зүгт 250 км-ийн зайд оршдог.

3.1.2.1 ОЮУ ТОЛГОЙ ТӨСӨЛ

Анх 1983 онд Монгол-Зөвлөлтийн хамтарсан экспедиц Оюу Толгойн ордод хайгуул хийж зэсийн нөөц байгааг олж тогтоосон байна. ЗХУ задарсны дараа 1997-1999 оны хооронд Австралийн “Би Эич Пи Минералс” компани нь төв болон өмнөд орд дээр хайгуулын ажлыг үргэлжлүүлэн хийсэн боловч компанийн хайгуулын төсвийг багасгасны улмаас хайгуулын ажлыг зогсоосон байна. 2000 оны 5 дугаар сараас 2002 оны 9 дүгээр сарын хооронд Канадын Айвенхоу компани хайгуул хийж тусгай зөвшөөрөлтэй талбайн боломжийг баталсан байна. Уурхайн барилгын ажил 2010 онд эхэлсэн, ба 2013 оны 7 дугаар сарын байдлаар 76 мянган тонн зэсийг олборлон тээвэрлэх үед барилгын эхний үе шат ашиглалтанд орсон байсан.

Өмнөговь аймгийн Ханбогд суман дахь Оюу Толгой уурхайн нь ил болон далд уурхайн хосолсон төсөл юм. Энэхүү төслийг Монгол Улсын Засгийн газар (34%) болон Туркойс Хилл Ресурс (66%, үүнээс Англи-Австралийн Рио Тинто компани 51%-ийг эзэмшдэг) хамтран эзэмшиж байна. 2010 оноос хойш Рио Тинто компани Оюу Толгой төслийг удирдаж байна.

Рио Тинто компани Оюу Толгойн орд нь нөхөгдөх зэсийн 2.7 сая тонн, нөхөгдөх алтны 1.7 сая унци нөөц байгаагаас харахад уг төсөл нь ойрын 50 жилдээ үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх боломжтой гэж үзэж байна. Оюу Толгой төсөл нь уурхай ашиглагдах хугацааны туршид жил бүр дунджаар 430 мянган тонн зэс, 425 мянган унци алтыг үйлдвэрлэх төлөвтэй байгаа бөгөөд нь нийт нөөцийн хувьд дэлхийн хамгийн том гурван алт, зэсийн уурхайнуудын нэгэнд тооцогддог. 2020 он гэхэд Монгол Улсын ДНБ-ний гуравны нэгийг Оюу Толгой ХХК дангаараа бүрдүүлэхээр тооцож байна. 2013 оны 5 дугаар сарын байдлаар Рио Тинто уурхайн талбайг хөгжүүлэхэд 6.2 тэрбум ам.доллар зарцуулсан байна.

3.1.2.1.1 Оюу Толгой уурхайн хэтийн төлөв

Далд уурхайн барих ажлыг багтаасан төслийн 2-р үе шат нь усны хангамж, санхүүжилтийн нөхцөл, илүү зардал, өмнөх техник эдийн засгийн үндэслэл, төлөгдөөгүй татварын тооцоо зэрэг асуудлын улмаас хойшлогдсон. 2014 оны 9 дүгээр сард Монгол Улсын Уул уурхайн дэд сайд О.Эрдэнэбулган барилгын хоёр дахь үе шат 2015 оны эхний улиралд эхэлнэ гэж мэдэгдсэн байна.

3.1.2.2 ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР

Эрдэнэтийн Уулын Баяжуулах үйлдвэр нь анх 1978 онд Монгол Улс болон ЗХУ-ын Засгийн газар хоорондын гэрээний дагуу тус тус 51%, 49%-ийн Монгол-Оросын төрийн эзэмшлийн хамтарсан компани болон байгуулагдсан байна. Тус уурхай жил бүр 480 мянган тонн зэс гаргадаг ба энэ нь Монгол Улсын нийт экспортын орлогын 18.8% -ийг эзэлдэг юм байна.

3.1.2.2.1 Эрдэнэт Үйлдвэрийн хэтийн төлөв

2012 оноос хойш тус Үйлдвэр нь сэлбэг, металл болон каучукан бүтээгдэхүүн, хэлбэршүүлсэн хуванцар бүтээгдэхүүн зэргийг агуулсан машин засварын заводын импортыг орлуулах бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэх чадавхийг хөгжүүлсээр байна. Үйлдвэр нь Эрдэнэтийн нисэх буудлыг дахин нээх төлөвлөгөөтэй байна.

3.1.3 ТӨМРИЙН ХҮДЭР

Төмрийн хүдэр нь Монгол Улсын экспортод үнийхээ хувьд гурав дахь, харин хэмжээнийхээ хувьд хоёр дахь том бараа юм. Монгол Улс нь дэлхийн нийт нөөцийн ойролцоогоор 0.6%-ийг эзэлдэг ба 985 сая тонн бүхий төмрийн хүдрийн нөөцтэй байна. 2014 оны 3 дугаар сарын байдлаар Монгол Улсад 9 төмрийн хүдрийн төсөл уурхай байгаагаас 6 нь үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр 6 уурхай төмрийн хүдэр болон төмрийн баяжмалыг тэнцүү хэмжээгээр үйлдвэрлэж байна. Одоо байгаа есөн уурхай 2014-2030 оны хооронд 281 сая тонн төмөр үйлдвэрлэнэ гэсэн тооцоо байна.

Монгол Улсын төмрийн хүдрийн ордын төмрийн агууламж 30-35 хувь байгаа нь ган үйлдвэрлэлийн хайлуулах зууханд шаардагдах бүтээгдэхүүнийг 62% хүртэл чанартай болгоход харьцангуй энгийн, эдийн засгийн хувьд хэмнэлттэй болгож байна. Энэ нь ялангуяа Монголын геополитикийн хувьд чухал ач холбогдолтой хөрөнгө юм. Хятадын төмрийн уурхайнууд төмрийн хамгийн анхаарал татсан ордуудыг шавхан ашиглаж байгаа нь тус улсын төмрийн хүдрийн чанарыг 35%-иас 18% болтол бууруулж байна. Иймээс Монгол Улсын төмрийн ордууд Хятадын боомтоос хол орших бүс нутгийн төмрийн хүдрийн үйлдвэрүүдийг хангах явдал эрс нэмэгдэж байна. Энэ нь уг бүс нутгийнхан Өмнөд Америк, Австрали зэргэ улсаас төмрийн хүдэр импортлоход хэтэрхий хол байдагтай холбоотой.

3.1.4 АЛТ

Монгол Улс 2013 онд 8,904 кг орчим алт олборлосон бөгөөд үүнээс 7,559 кг-ыг экспортод гарган 310 сая ам.долларын орлого олсон байна. Улаанбаатар хотоос 100 км орчим зайтай орших Бороогийн алтын уурхайд 2003 оноос хойш олборлолт явуулж байгаа бөгөөд нөөц нь дуусах дөхөөд байна. Тус уурхай нь Монгол Улсын алтны үндсэн ордын нэг юм. Үүний зэрэгцээ Оюу толгой нь алтны 1,800 тонны нөхөгдөх нөөцтэй гэсэн тооцоо байдаг. Харин шороон орд дээр хувиараа алт олборлогчид Монгол Улсын алтны олборлолтын дийлэнх хувийг гүйцэтгэжээ. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх асуудалд анхаарал хандуулснаар 2009 онд усны эх, сав газар болон ойн нөөц бүхий газарт алт олборлохыг хориглосон хууль батлагдсан нь сүүлийн жилүүдэд олон тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоход хүргэсэн⁹.

3.1.5 ХАЙЛУУР ЖОНШ

Хайлуур жонш буюу фтор нь өнгөт болон хар төмөрлөгөөс гадна хими, анагаах ухаан, оптикийн салбарт өргөнөөр хэрэглэгддэг газрын шүлтэт металл юм.

Манай орон энэ түүхий эдийн олборлолт, экспортоор 1980-аад онд дэлхийд тэргүүлдэг байжээ. Манай улс жилд 400 мянган/тн хайлуур жонш олборлож байна. Олборлолтын хэмжээгээрээ дэлхийд гуравдугаарт буюу БНХАУ, Мексикийн дараа ордог юм.

3.1.6 МОЛИБДЕНИ

БНХАУ-д молибдений баяжмалын эрэлт буурсан байгаа учир зах зээл ерөнхийдөө удаашралтай байгаа билээ. Гэвч молибдений гол уурхайнууд үйлдвэрлэлээ тогтоосон хэмжээгээр, тогтмол явуулсаар байна.

2013 он гэхэд, молибдений үйлдвэрлэл нь 3.8 мянган тонн (47% -ийн агууламжтай) буюу өмнөх оны мөн үеийнхээс 4.7% -иар буурсан хэдий ч Монгол Улс молибдени үйлдвэрлэлээрээ дэлхийд н 13-т орж байна.

3.1.7 ЦАЙР

Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд геологийн судалгааны өнөөгийн түвшинд цайр, хар тугалганы 15 орд, 120 орчим илрэл нээгдэн судлагдсан байна. 2013 оны байдлаар Монгол Улс 104 мянган тонн цайрын баяжмал олборлосон байна.

3.1.8 УРАН

Монголд ураны томоохон ордууд байдаг ба 30-62 мянган тоннын нөөц бий гэсэн тооцоо байдаг. Өнөөгийн байдлаар Монгол Улс уран экспортлоогүй байна.

Монгол Улсад ураны 15 орд газар байгаа бөгөөд үүний 3 нь стратегийн ач холбогдол бүхий (Мардайн гол, Гурванбулаг, Дорнодын) орд юм.

Монгол Улсад 2013 оны байдлаар 14 аж ахуйн нэгж цацраг идэвхит уул уурхайн салбарт 68 тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа ба, 3.2 тэрбум төгрөгийн тусгай зөвшөөрлийн төлбөр төлсөн байна.

3.1.9 СТРАТЕГИЙН АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ ОРД

Стратегийн ач холбогдолтой эрдэс баялагт ус, газрын тос, байгалийн хий, цацраг идэвхт ашигт малтмал, газрын ховор элементийг хамааруулах ба “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд” гэдэгт Монгол Улсын Их хурлын 2007 оны 27 дугаар тогтоолын 01 дүгээр хавсралтад заагдсан нэр бүхий 15 ордыг хамааруулна.

Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тодорхойлолт: "Үндэсний аюулгүй байдал, улсын болон бүс нутгийн түвшинд улс орны эдийн засаг, нийгмийн хөгжилд болзошгүй нөлөөтэй байж болох ; эсхүл тухайн жилд нийт ДНБ-ний 5% -иас илүү үйлдвэрлэх боломжтой эсвэл үйлдвэрлэж байгаа ордын хэмжээ юм".

“Ашигт малтмалын тухай” хуулийн 9 дүгээр зүйлийн 1.5-д “Засгийн газар нь стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг тогтоох тухай саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ” гэж заасан байна.

Стратегийн ач холбогдол бүхий ордуудын нөөц:

Ордын Нэрс	Ашигт малтмалын Төрөл	Нөөц (мян.тонн)	Найрлага
Нарийн Сухайт	Шатдаг Нүүрс	126,000	-
Багануур	Бор Нүүрс	600,000	-
Эрдэнэт	Зэс, Молибден	1,200,000	0.51% Зэс болон 0.012 Молибдени
Гурван Булаг	Уран	0.0161	-
Оюу Толгой	Зэс, Молибден	26,300 (Зэс) 0.019 (Мөнгө)	-
Таван Толгой	Шатдаг Нүүрс	6,400,000	-
Шивээ Овоо	Бор Нүүрс	646,000	-
Мардай	Уран	0.0011	-
Морнод	Уран	0.0289	-
Төмөртэй	Төмөр	229,000	51.15 Төмөр
Цагаан Суварга	Зэс, Молибдени	10,600	0.42% Зэс болон 0.011 Молибдени
Бүрэнхаан	Фосфор	192,000	21.1 Фосфор
Төмөртэйн Овоо	Цайр	7,700	11.5% Цайр
Асгат	Мөнгө	6,400	351.08г/тонн Мөнгө
Бороо	Алт	0.025	1.6г/тонн Алт

Эх сурвалж: Монголын Ашигт малтмалын газар

Хүснэгт-14

3.1.10 ГАР АРГААР АШИГТ МАЛТМАЛ ОЛБОРЛОЛТ БА БИЧИЛ УУЛ УУРХАЙ

Монгол Улсад ойролцоогоор 100 мянга гаруй гар аргаар ашигт малтмал олборлогчид байдаг ба Монгол Улсын 21 аймгийн 19-д нь олборлолт эрхэлж, нийт хөдөө орон нутгийн ажиллах хүчний 20% -ийг бүрдүүлж байна. Бичил уурхайчдын дийлэнх хэсэг нь (80%-90%) алт, үлдсэн хэсэг нь хайлуур жонш, нүүрс олборлож байна. Хайлуур жоншийг хөнгөн цагаан, шингэн шатахуун, хөргөх бодис, ган гэх мэт үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн болгон ашигладаг ба үнэт эдлэлд ч хэрэглэж болдог байна.

Цаг агаарын илт өөрчлөлт, хахир хатуу өвөл, газар тариалангийн өгөөжийн бууралт, эдийн засгийн эрс өөрчлөлт, болон сүүлийн арван жил дэх алтны үнийн өсөлт зэрэг нь Монгол улсад гар аргаар ашигт малтмал олборлогчид нэмэгдэхэд ихээхэн нөлөөлсөн юм. Бичил уурхайн олборлогчид хуучин фермерийн ажилчид, малчид, үйлдвэрийн ажилчид байдаг ба сэхээтнүүд ч байдаг.

Монгол Улс Бичил уурхайчдын эерэг хувь нэмрийг дэмжих тусгай хөтөлбөртэй. 2005 онд Тогтвортой бичил уурхай төслийг Ашигт малтмалын газар, (одоо Уул уурхайн яамтай), Швейцарийн Хөгжил хамтын ажиллагааны агентлаг хамтран байгуулсан байна. Одоогоор тус төсөл нь гурав дахь үе шатандаа явж байгаа ба 2014 оны сүүл хүртэл үргэлжлэх юм. Монгол Улсын Засгийн Газартай хамтарсан энэхүү төслийн нэг ололт нь ямар ч мөнгөн ус, цианид хэрэглэхгүй боловсруулах үйлдвэр хөгжүүлэхэд нь туслах явдал юм.

2008 онд Засгийн газар өсөн нэмэгдэж буй бичил уурхайн салбарыг хуульчлах түр журам баталсан ба туршлагадаа тулгуурлан 2010 онд байнгын шинэ журмыг баталсан. Энэ журмаар бичил уурхай эрхлэгчдийн уурхайн газрын ашиглалт, орлогын албан татварын түвшин зэргийг тодорхойлсон. 2010 оны 12 дугаар сард Монгол Улсын Засгийн газар “Бичил уурхайгаар Ашигт малтмал олборлох тухай журам” баталсан.

3.1.11 ХАЙГУУЛ

3.1.11.1 ЦАЦРАГ ИДЭВХТ АШИГТ МАЛТМАЛЫН НӨӨЦ

2013 онд цацраг идэвхт ашигт малтмалын хайгуулыг 67 хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшдэг 13 аж ахуйн нэгж нийт 1,890,513 га талбайд хийсэн байна. Үүнээс 2 аж ахуйн нэгж хайгуулын үр дүнгийн тайлан, ордын нөөцийн тооцоог боловсруулж, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэн хүргүүлсэн байна.

3.1.11.2 БУСАД АШИГТ МАЛТМАЛ

2014 оны 7 дугаар сард шинэчлэн найруулсан “Ашигт малтмалын тухай” хуулийн 33 дугаар зүйлийн 1.1-1.4-д хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайн гектар

тутамд жил бүр тухайн тусгай зөвшөөрөлтэй талбайн гектар тутамд дараахь хэмжээнээс багагүй үнэ төлнө

- 33.1.01 дүгээр зүйл: тусгай зөвшөөрлийн 2 - 3 дах жилд 0,5 америк доллар;
- 33.1.2 дугаар зүйл: тусгай зөвшөөрлийн 4 - 6 дах жилд 1,0 америк доллар;
- 33.1.3 дугаар зүйл: тусгай зөвшөөрлийн 7 - 9 дэх жилд 1,5 америк доллар.
- 33.1.4 дүгээр зүйл: тусгай зөвшөөрлийн 10-12 дах жилд 10 америк доллар.

2013 онд явуулсан томоохон хайгуулын үйл ажиллагаа:

Д/Д	Компанийн нэр	Ашигт малтмалын төрөл	Лицензийн дугаар	Талбайн хэмжээ (га)	Төлөвлөсөн зардал сая төг	Бодит зардал сая төг	Га тутамд сая төг
1	Цагаан өвөлжөө ХХК	нүүрс	17162 а	17,432.00	39.80	14,951.80	0.86
2	Галакси майнинг монголиа ХХК	зэс	8525 х	110,944.40	253.60	10,311.60	0.09
3	Энх тунх орчлон ХХК	нүүрс	12600 х	50,022.20	114.30	4,443.80	0.09
4	Шарын гол ХК	нүүрс	1498а	1,826.20	4.20	3,733.50	2.04
5	Хүннү говь алтай ХХК	нүүрс	10135 х	2,077.40	4.70	3,669.00	1.77
6	Хүннү алтай минералс ХХК	нүүрс	8968 х	24,882.80	64.50	3,624.70	0.17
7	Оюутолгой ХХК	зэс, алт	6709а	8,489.90	19.40	3,578.80	0.42
8	Сод газар ХХК	молибден	10439 х	2,363.10	4.80	3,300.60	1.40
9	Монголиан нэншнл рийр ийрт корп ХХК	газрын ховор элемент	12335 а	91.40	0.40	3,086.70	33.77
10	Этүгэн эе ХХК	нүүрс	12648 х	56,162.10	128.40	2,471.80	0.04
	Нийт			274,291.40	634.20	538,172.30	0.19

Хүснэгт-15

Эх сурвалж: Монгол Улсын Ашигт Малтмалын Газраас ирүүлсэн мэдээлэл

Нүүрс, зэсийн хайгуул явагдсаар байгаа хэдий ч одоогоор хийгдэж буй төмрийн хүдрийн нэмэлт хайгуулын үйл ажиллагаа байхгүй харин уг салбарын хувьд дотооддоо боловсруулах чадавхиа сайжруулах тал дээр анхаарч байна.

3.1.11.3 ГАЗРЫН ТОС

3.1.11.3.1 2012 онд Бүтээгдэхүүн хуваах гэрээтэй талбайд хийгдсэн хайгуулын ажил

№	БХГ-т талбай	Гэрээлэгч	Гүйцэтгэх ажил	Хэмжих нэгж	Гүйцэтгэсэн ажлын хэмжээ
1	Хөхнуур XVIII	“Эн Пи Ай” ХХК	Хоёр хэмжээст чичирхийллийн судалгаа	тууш.км	1,096
			Хайгуулын 1 цооног	тууш.м	2,350
2	Баянтүмэн XVII	“Магнай трейд” ХХК	Хоёр хэмжээст чичирхийллийн судалгаа	тууш.км	536

№	БХГ-т талбай	Гэрээлэгч	Гүйцэтгэх ажил	Хэмжих нэгж	Гүйцэтгэсэн ажлын хэмжээ
3	Дарьганга XXIV	"Алекспро инвестмент" ХХК	Хоёр хэмжээст чичирхийллийн судалгаа	тууш.км	210
4	Цагаан Элс XIII Зүүнбаян XIV	"Гоби энерги партнерс" ХХК	Пассив сейсмийн судалгаа	ф.ц	210
			Хоёр хэмжээст чичирхийллийн судалгаа	тууш.км	335.63
			Хайгуулын 2 цооног	тууш.м	1,748
5	Төхөм X (урд)	"Монголын алт МАК" ХХК	Соронзон хайгуул	тууш.км	2мянган
			Хоёр хэмжээст чичирхийллийн судалгаа	тууш.км	345.3
6	Тариач XV	"Голден Сий петролеум" ХХК	Хайгуулын 2 цооног	тууш.м	3,694
7	Төхөм X (хойд)	"Сансарын геологи хайгуул" ХХК	Хоёр хэмжээст чичирхийллийн судалгаа	тууш.км	528.9
			Хайгуулын 1 цооног	тууш.м	1,320
8	Галба XI	"Зон Хэн Юу Тиан" ХХК	Хайгуул, үнэлгээний 4 цооног	тууш.м	4,296

Хүснэгт-16

3.1.11.3.2 2013 онд Бүтээгдэхүүн хуваах гэрээтэй талбайд хийгдсэн хайгуулын ажил

№	БХГ-т талбай	Гэрээлэгч	Гүйцэтгэх ажил	Хэмжих нэгж	Гүйцэтгэсэн ажлын хэмжээ
1	Хөхнуур XVIII	"Эн Пи АЙ" ХХК	Параметр, хайгуулын 3 цооногийн өрөмдлөг	тууш.м	5,313
2	Төхөм X (урд)	"Монголын Алт МАК" ХХК	Соронзон судалгаа	тууш.км	15 мянган
			Геологийн маршрут /1:200000/	тууш.км	300
3	Сүхбаатар XXVII	"Вульф Петролеум" ХХК	Хоёр хэмжээст чичирхийллийн судалгаа	тууш.км	453
4	Богд IV, Онги V	"КапКорп Монголиа" ХХК	Хоёр хэмжээст чичирхийллийн судалгаа	тууш.км	235

Хүснэгт-17

3.1.12 БОЛОВСРУУЛАЛТ

Ашигт малтмал боловсруулах хүчин чадал нь дараах байдалтай байна:

Компаний нэрс	Нөөцийн боловсруулалт	Ашиглалтад орсон он
Бэрэн уурхайн хүдэр баяжуулах төсөл	Төмөр	2007
Фокус метал нойтон баяжуулах үйлдвэр	Төмөр	2014
Алтайн Хүдэр боловсруулах төсөл	Төмөр	2011
Төмөртэй төмрийн хүдрийн баяжуулах	Төмөр	2014
Дарханы төмөрлөгийн төсөл	Төмөр	1994
Оюу Толгойн боловсруулах төсөл	Зэс	2013
“Монголын уул уурхайн корпораци” нүүрс угаах үйлдвэр	Нүүрс	2011

Хүснэгт-18

2014 оны 1 дүгээр сард Хүнд үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын (Хөдөө аж ахуй яамны газар) дарга Д.Ганболд Сайншандын ган гаргах, металлургийн байгууламж зэргийг багтаасан аж үйлдвэрийн цогцолбор төсөл нь 2018 оны эхээр дуусна гэж мэдэгдсэн байна.

2013 оны 8 дугаар сард Өмнөд Солонгосын ган үйлдвэрлэгч “Поско” групп “Монголын уул уурхайн корпораци”-тай экспортын зардлыг багасгаж, цэвэр түлш хэлбэрээр гаргах замаар нүүрсний үйлдвэрлэлд нэмүү өртөг шингээх боломжтой 2 тэрбум ам.долларын нүүрс шингэрүүлэх үйлдвэр барих хэлцэл хийснээ зарласан. Үүнтэй төстэй түншлэл 2012 оны 4 дүгээр сараас хойш Германы “ThyssenKrupp” компанитай хийгдэж байна. Хэдийгээр дотоодын газрын тосны олборлох болон цэвэршүүлэх төхөөрөмж нь хөгжлийнхөө шатанд байгаа ч нүүрс шингэрүүлэх төхөөрөмж нь Монгол Улсын түлшний дунд хугацааны шаардлагыг хангах боломжтой.

3.2 ГАЗРЫН ТОС БА БАЙГАЛИЙН ХИЙ²

3.2.1 ГАЗРЫН ТОС

3.2.1.1 ТОЙМ

Зөвлөлтийн геологичдын судалгааны үр дүнд 1947 онд Монголд газрын тосны нөөц байгааг олж илрүүлсний дараа багахан хэмжээний хүчин чадалтай боловсруулах үйлдвэр байгуулсан байна. Уг үйлдвэр 1969 онд олборлолтын цооногийн даралт буурсан, үйлдвэрт гал гарсан болон бусад эдийн засгийн шалтгаанаар татан буугдсан юм.

Зөвлөлт Холбоот улс задарсны дараа газрын тосны үйл ажиллагааны хөгжил дахин сэргэж, Монгол улсын Газрын тосны тухай хууль 1991 онд баталсан юм. Улмаар Засгийн газар “Газрын тос” хөтөлбөр хэрэгжүүлж, хэтийн төлөвтэй талбайнуудыг ялгаж, гэрээт талбай болгон олон улсын тендер зарлаж

² Эх сурвалж: Уурхайн дүр төрх; Петро Матад ХХК, Монголын уул уурхайн корпораци; Газрын тос ба шатдаг занар-2014 Монгол Улсын бага хурал; АНУ-ын Эрчим хүчний мэдээллийн удирдлага, АНУ-ын Геологийн судалгаан; Монгол Улсын УУЯ, Жэни Эрчим Хүч; Оксфорд бизнес групп; УБ шуудан; Шинэ Европ Бизнес

эхэлсэн 1993 онд анхны бүтээгдэхүүн хуваах гэрээг АНУ-ын хайгуулын “Соко” компанитай байгуулан гарын үсэг зурсан байна. 1997 онд улсын зүүн хэсэгт орших Тамсагийн сав газрын нэгэн цооногт анхны газрын тос гарч, удалгүй БНХАУ руу газрын тос экспортлож эхэлсэн..

Доорх зурганд одоогийн байдлаар Монгол улсад газрын тосны хайгуул болон олборлолт хийгдэж буй талбайн байршлыг харуулав.



Монгол Улс нь 2.3 тэрбум баррель батлагдсан газрын тосны нөөцтэй хэмээн Монгол Улсын Газрын тосны газраас мэдэгдсэн бөгөөд энэ нь 0.8 тэрбум баррелиар илүү байх магадлалтай хэмээн тооцжээ. 2010 оноос 2013 оны хооронд Монгол Улс нийт 13.4 сая баррель газрын тос үйлдвэрлэсэн. 2013 онд Монгол Улсын түүхий газрын тосны экспорт нь 515 сая ам. доллар болж нийт экспортын 12%-ийг бүрдүүлсэн байна.

3.2.1.2 ГАЗРЫН ТОСНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА БА ХАЙГУУЛ

Монгол улсад шатдаг занарын 13 сав газар байгаа ч одоогоор үйлдвэрлэл хэмжээнд буй хоёрхон сав газар байна

I. Тамсагийн сав газар

“Петрочайна дачин тамсаг” ХХК Тамсагийн сав газрын 2 блок дээр үйл ажиллагаа явуулдаг.

Блок XIX: 1998 оноос үйлдвэрлэл явуулж эхэлсэн бөгөөд; мөн блок XXI 2010 оноос үйлдвэрлэл явуулж эхэлсэн.

II. Зүүн Өмнөд Говийн сав газар

1953-1969 оны хооронд анхны газрын тос үйлдвэрлэж байсан Зүүн өмнөд говийн сав газарт “Синопек” Компани нь БХГ (Зүүнбаян)-97 талбайд үйлдвэрлэл явуулдаг. Энэхүү блок нь 2007 онд дахин сэргээгдэж 2012 оны 2-аар сарын 29-ны байдлаар 2.66 сая баррель газрын тос экспортолсон.

No	Талбайн нэр	БХГ-ний хүчин төгөлдөр болсон өдөр	Монгол Улсын Засгийн газрын тогтоол	Тусгай зөвшөөрөл эзэмшигч		Нэгтгэлд орсон эсэх	Үйл Ажиллага
				Компани	Улс		
1	Тосон-Уул XIX	1993.04.26	239	"Петрочайна дачин тамсаг" ХХК	БНХАУ	Тийм	Олборлолт
2	Тамсаг XXI	1996.08.07	183	"Петрочайна дачин тамсаг" ХХК	БНХАУ	Тийм	Олборлолт
3	Зүүнбаян 1997	1997.02.19	47	"Доншен газрын тос" ХХК	БНХАУ	Тийм	Олборлолт
4	Матад ХХ	2006.07.19	170	"Петро Матад" ХХК	Монгол улс	Тийм	Хайгуул
5	Богд IV	2009.07.29	235	"Капкорп Монголиа" ХХК	Их Британий Каймэний арал улс	Тийм	Хайгуул
6	Онги V	2009.07.29	235	"Капкорп Монголиа" ХХК	-	Тийм	Хайгуул
7	Тариач XV	2007.03.07	47	"Голден Сий Петролеум" ХХК	БНХАУ	Үгүй	Хайгуул
8	Галба XI	2009.05.20	147	"Зон Хэн Юу Тиан" ХХК	БНХАУ	Тийм	Хайгуул
9	Цайдам XXVI	2009.07.29	235	"Сансарын Геологи Хайгуул" ХХК	-	Үгүй	Хайгуул
10	Төхөм X (хойд)	2009.07.29	237	"Сансарын Геологи Хайгуул" ХХК	Монгол улс	Үгүй	Хайгуул
11	Номгон IX	2014.02.07	31	"Сансарын Геологи Хайгуул" ХХК	-	Үгүй	Хайгуул
12	Хөх нуур XVIII	2009.07.29	238	Эн Пи Ай ХХК	БНХАУ	Үгүй	Хайгуул
13	Нялга XVI	2007.06.20	148	"Шэймэн Ресурсес Лимитед" ХХК	Канад	Тийм	Хайгуул
14	Цагаан элс XIII	2009.05.20	148	"Гоби Энержи Партнерс" ХХК	Швейцарь улс	Үгүй	Хайгуул
15	Зүүнбаян XIV	2009.05.20	148	"Гоби Энержи Партнерс" ХХК	Швейцарь улс	Үгүй	Хайгуул
16	Сулинхээр XXIII	2009.07.22	224	"Шунхлай энержи" ХХК	Монгол улс	Үгүй	Хайгуул
17	Борзон VII	2009.07.29	236	"М Си Эс Холдинг" ХХК	Монгол улс	Үгүй	Хайгуул
18	Баянтүмэн XVII	2010.12.08	316	"Магнай трейд" ХХК	Монгол улс	Үгүй	Хайгуул
19	Дарьганга XXIV	2011.02.09	39	"Алекспро инвестмент" ХХК	БНХАУ	Тийм	Хайгуул
20	Төхөм X (урд)	2012.07.25	253	"Монголын алт" ХХК	Монгол улс	Үгүй	Хайгуул
21	Сүхбаатар XXVII	2013.01.05	2	"Вульф петролеум" ХК	Австрали	Тийм	Хайгуул

Хүснэгт-19

3.2.2 БАЙГАЛИЙН ХИЙ

Одоогийн байдлаар Монгол Улсад байгалийн хий олборлоогүй байна. 2013 онд Солонгосын “Гас Корпорейшн” компани төрийн өмчит “Эрдэнэс Таван Толгой” компанитай шинэ эрчим хүчний нөөц ашиглах хамтын ажиллагааны гэрээнд гарын үсэг зурсан.

3.2.3 БОЛОВСРУУЛАЛТ

Монгол улс газрын тос боловсруулах дотоодын хүчин чадлаар дутмаг. 2013 онд Монгол улс өдөрт ойролцоогоор 11 мянган баррель газрын тос (ихэвчлэн бензин, дизель тулш) импортлодог гэсэн тооцоо байдаг ба энэ маягаар 2003 оноос хойш өдөрт дунджаар 12 мянган баррелийг импортолж байна. Газрын тосны ойролцоогоор 98%-ийг ОХУ-аас импортоор авч үлдсэн хувийг Монголд газрын тос цэвэршүүлдэг Хятадын компаниас авах тооцоо байна. 2013 оны 5 дугаар сард Монгол улс “ПетроЧайна” компанитай Монголд олборлосон боловсруулаагүй нефтийг БНХАУ-д илүү боловсруулсан бүтээгдэхүүнээр харилцан солилцох гэрээ байгуулсан байна. Ингэж импортлосон газрын тос нь ОХУ-ын үйлдвэрээс одоогоор авч байгаа газрын тостой харьцуулахад дээд зэргийн чанар сайтай байх юм. Нефтийн бүтээгдэхүүний импортын Орос, Хятадаас хараат байдлыг багасгах зорилгоор “Хай Би Ойл” ХК 2013 оны 6 дугаар сард Хойд Солонгосын “Sungri Oil Refinery” газрын тосны компанитай хэлэлцээрт гарын үсэг зурсан.

3.3 ҮЙЛДВЭРЛЭЛ³

3.3.1 АШИГТ МАЛТМАЛ

Доорх хүснэгтээр сүүлийн жилүүдийн ашигт малтмалын үйлдвэрлэлийг харуулав:

Ашигт Малтмал	Хэмжих нэгж	2009	2010	2011	2012	2013
Нүүрс	мян.тн	14 442.1	25 161.9	32 029.7	29,926	30,123
Зэсийн баяжмал 35%-тай	мян.тн	371	357	347	348	533
Молибдений баяжмал 47%-тай	тн	5 125.0	4 677.1	4 163.1	4,050	3,869
Алт	кг	9 803.3	6 037.1	5 702.6	5,995	8,904
Хайлуур жонш	мян.тн	629	727	659	484	162
Хайлуур жоншны баяжмал	мян.тн	115	141	116	157	76
Төмрийн Хүдэр	мян.тн	1 379.0	3 203.2	5 678.3	7,561	6,011
Цайрын баяжмал	мян.тн	142	113	105	119	104
Гянт болдын баяжмал	тн	39	20	13	66	-
Давс	тн	5	-	-	569	658

Хүснэгт-20

Эх сурвалж: Үндэсний статистикийн эмхэтгэл 2013, хуудас 345

³ Эх сурвалж: Монгол Улсын Уул Уурхайн Эрчи Хүчгий Яам

3.3.2 ГАЗРЫН ТОС

Сүүлийн Жилүүдийн Газрын Тосны Үйлдвэрлэл:



График-11

Монгол улсын газрын тосны сарын хэрэгцээ одоогоор 60-70 мянган баррель байна. Дотооддоо боловсруулах үйлвэр байхгүйн улмаас уг хэрэгцээний 98 орчим хувийг импортлодог.





График-12

3.4 ЭДИЙН ЗАСАГТ ОРУУЛСАН ХУВЬ НЭМЭР⁴

3.4.1.1 ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН БА АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН

2014 оны 4 дүгээр сард Монгол Улсын ДНБ-д уул уурхайн эзлэх хувь 20% байсан нь 10 жилийн өмнөхөөс хоёр дахин их байна. Эдийн засгийн өсөлт 2010 онд 6.4%-тай байсан бол 2013 онд өсөлтийн хувь 12.5 болсон. Урьдчилсан таамаглалаар уул уурхайн томоохон төслүүдийн үйл ажиллагаа жигдэрснээр ДНБ-ний хэмжээ 2014-2017 оны хооронд хоёр оронтой тоогоор өснө гэж үзэж байна.

⁴ Эх сурвалж: Дэлхийн банк; НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр; ОУВС



Эх сурвалж: Үндэсний статистикийн эмхэтгэл 2013, хуудас 205, 341

График-13

3.4.1.2 ЭКСПОРТ

2013 онд Монгол улсын нүүрсний экспорт дараах байдалтай байна:

Экспортын хэмжээ (мян.тонн)	Экспортын дүн (сая ам.доллар)	Ашигт малтмалын экспортод эзлэх хувь /Үнийн дүнгээр/	Нийт экспортод эзлэх хувь /Үнийн дүнгээр /
18,188	1,116	29	26

Хүснэгт-21

2013 онд зэсийн экспорт дараах байдалтай байна:

Экспортын хэмжээ (мян.тонн)	Экспортын дүн (сая ам.доллар)	Ашигт малтмалын экспортод эзлэх хувь /Үнийн дүнгээр /	Нийт экспортод эзлэх хувь /Үнийн дүнгээр /
650	949	25	22

Хүснэгт-22

2013 онд төмрийн экспорт дараах байдалтай байна:

Экспортын хэмжээ (мян.тонн)	Экспортын дүн (сая ам.доллар)	Ашигт малтмалын экспортод эзлэх хувь, /Үнэ/	Нийт экспортод эзлэх хувь /Үнэ/
6,724	654	17	15

Хүснэгт-23

2013 онд боловсруулаагүй нефтийн экспорт дараах байдалтай байна:

Экспортын хэмжээ (мян.баррель)	Экспортын дүн (сая ам.доллар)	Ашигт малтмалын экспортод эзлэх хувь, /Үнэ/	Нийт экспортод эзлэх хувь /Үнэ/
5,244	515	14	12

Хүснэгт-24

Хүснэгт 21-24 дэх мэдээллийн эх үүсвэр: Гаалийн ерөнхий газар, Монголбанк

Уул уурхайн салбарын сүүлийн жилүүдийн экспортод эзлэх хувийг дараах графикаар үзүүлэв.




График 14

3.4.1.3 ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Үндэсний Статистикийн Хорооны мэдээлснээр, 2013 онд Монгол улсын нийт 1,103,600 хөдөлмөр эрхлэгчдийн 50,300 нь уул уурхайн салбарт ажиллаж байсан. Уул уурхайн салбар дахь ажил эрхлэлтийн тооцоололд гар аргаар олборлолт эрхлэгчид болон бичил уул уурхайн салбаруудыг оруулаагүй байна.

Сүүлийн жилүүдийн ажил эрхлэлтийн байдлыг доорх диаграммаар харуулав.




График 15

2013 онд энэхүү нэгтгэлд хамрагдсан 250 компаниас 181 компани нь ажиллагсдын тоогоо ирүүлсэн. Эдгээр 181 компанийн ажиллагсдын тоо нь 2013 оны уул уурхайн салбарт ажиллагсдын 50 орчим хувийг эзэлж байна. **Ажиллагсдын тооны судалгааг Хавсралт-21-ээс харна уу.**

3.5 ЗАСГИЙН ГАЗРЫН БАЙГУУЛЛАГУУД⁵

3.5.1 ТАТВАРЫН АЛБА

Үндэсний татварын алба нь Татварын ерөнхий газар, аймаг, нийслэл, дүүргийн татварын газар, хэлтэс, сумын татварын тасаг, татварын улсын байцаагчаас бүрдэнэ. Татварын ерөнхий газрын чиг үүрэг дараах байдалтай байна:

- Татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэх, татвар төлөгчийг мэдээллээр ханган зөвлөгөө өгөх, сургалт, сурталчилгаа явуулах
- Татварын хууль тогтоомжийн даган мөрдөлтөнд хяналт тавих
- Улс, орон нутгийн төсвийн орлогыг бүрдүүлэх
- Тус албаны цахим хуудсаны дагуу татварын алба одоогоор "Дэлхийн Татварын Стандарт"-ыг жишигт хүрэх таван жилийн хөтөлбөрийн дунд үедээ явж байна.

Үр дүнтэй мэдлэг ба ногоон эдийн засагт зориулсан татварын эрх зүйн орчинг бүрдүүлэх асуудлыг агуулсан Үндэсний татварын албаны хөтөлбөрийн хөгжлийн зорилго нь мэдээлэл технологийн шинэчлэлд суурилсан татварын удирдлагыг хөгжүүлэх, олон улсын туршлагыг нэвтрүүлэх мөн эрсдлийн удирдлагын арга техникийг боловсруулах хэрэгсэл болон эрсдэлтэй татвар төлөгчдөд аудит хийх зэргийг хөгжүүлэх юм.

⁵ Эх сурвалж: Санхүүгийн нэгдсэн үйлчилгээ; Монголын татварын алба; Монгол Улсын Гаалийн газар; Азийн Хөгжлийн Банк; Олон улсын хөдөлмөрийн байгууллага, Содон зөн; Монгол Улсын Газрын Тосны Газар, Монгол Улсын Төрийн өмчийн хороо, news.mn; Наутилус хүрээлэн; Монгол Улсын Эрчим хүчний яам, Монгол Улсын Ашигт малтмалын Газар, Герберт Смит Фрихилз

3.5.2 ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

Монгол Улсын Гаалийн ерөнхий газар нь улсын төсвийн ашигийг бүрдүүлэхээр татвар, хураамж хураах уламжлалт үүргээ нийгмийн сайн сайхныг дээдлэж, эдийн засгийн аюулгүй байдлыг хангах болгон өргөжүүлж байна.

Азийн хөгжлийн банк болон БНСУ-ын Засгийн газрын тусламжтайгаар хэрэгжүүлж буй хөтөлбөрийн хүрээнд Гаалийн байгууллага нь захиргааны байгууллага бус, үйлчилгээний байгууллага руу шилжиж байна. Гол зорилго нь хил дамнасан худалдааны явцад тулгарч буй аливаа хүнд суртал, бэрхшээлийг шийдвэрлэх үр дүнтэй гарцыг зорчигчдод бий болгох явдал байсан юм.

3.5.3 НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

Улсын нийгмийн даатгалын ерөнхий газар 1994 оны 5 дугаар сард Монгол Улсын Нийгмийн даатгалын тухай багц хууль бий болсноор байгуулагдсан бөгөөд төв зөвлөл, орон нутгийн салбар, нэгжийн бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. Тус байгууллагын зорилго нь тэтгэвэр, эрүүл мэнд, тэтгэмж, үйлдвэрлэлийн осол, ажилгүйдлийн даатгал зэргийг ажлуудыг удирдан явуулдаг.

3.5.4 ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР

Монгол Улсын ГТГ-ын зорилго нь газрын тосны салбарын хөгжил болон хөрөнгө оруулалтыг дэмжих Засгийн газрын бодлогыг мэдээлж дэмжлэг үзүүлэх явдал юм. ГТГ нь үйлчлүүлэгчдэд үр ашигтай, шударга үйлчилгээгээр хангахад чиглэгдсэн байдаг. ГТГ-ын одоогийн тэргүүлэх чиглэл нь Газрын тос олборлох болон цэвэршүүлэх бодлогыг хэрэгжүүлэх, уламжлалт болон уламжлалт бус газрын тосны хайгуулын үйл ажиллагааг дэмжиж хүчин чадлыг нэмэгдүүлэх зэргээс бүрдэнэ.

ГТГ нь засаг захиргаа, хайгуул, хяналт-шинжилгээ, үнэлгээ, ашиглалт, худалдан авалт, технологи, санхүү, хөрөнгө оруулалтын гэсэн 7-н хэлтэс албуудтай үйл ажиллагаа явуулж байна.

3.5.5 ТӨРИЙН ӨМЧИЙН ХОРОО

Төрийн өмчийн хороо нь төрийн өмчийн эд хөрөнгийг эзэмших, ашиглах, хамгаалах ажлыг эрхлэн гүйцэтгэх үүрэг бүхий Засгийн газрын үндсэн бүтцийн байгууллага юм.

3.5.6 УУЛ УУРХАЙН ЯАМ

3.5.6.1 АШИГТ МАЛТМАЛЫН ГАЗАР

Ашигт малтмалын газар нь Уул уурхайн яамны харьяа хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлийн өрөгдөл боловсруулах, олгох үүрэг бүхий ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг юм.

Ашигт Малтмалын Газар нь уг хуулийн 19.1.4 дүгээр зүйлийн шаардлагыг (хүсэлтэд дурдсан талбай нь ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хязгаарласан буюу хориглосон, тусгай хэрэгцээ, нөөцөд авсан, түүнчлэн хайгуулын тусгай зөвшөөрлөөр нэгэнт олгогдсон буюу түрүүлж ирүүлсэн өргөдөлд дурдсан талбайтай давхцсан) хангаагүй өргөдлийг хүлээж авахаас татгалзах, өргөдөл гаргагчид бичгээр мэдэгдэх ба тусгай зөвшөөрөл олгох боломжтой нь тогтоогдсон тохиолдолд тус талбай байрших Аймаг, Нийслэлийн Засаг даргад хүсэлтийг илгээнэ. Тэд сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн саналыг авч 30 хоногийн дотор төрийн захиргааны байгууллагад хариу өгөх бөгөөд энэ хугацаанд хариу өгөөгүй бол тухайн саналыг зөвшөөрсөн гэж үзнэ.

АМГ-ын бусад ажлын хураангуйг дараах байдлаар дүгнэж болох юм:

- ЗГ-т салбарын хөгжлийн бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх, шаардлагатай мэдээллээр хангах, энэ салбарт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлэх бүх талын таатай орчинг бүрдүүлэх.
- Ашигт малтмалын хуулийг хэрэгжүүлэх зорилгоор ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй холбоотой үйлчилгээ үзүүлэх.

3.5.6.2 ЭРДЭС БАЯЛГИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

Тус Зөвлөл нь тусгай зөвшөөрөлтэй талбайдын хайгуулын үйл ажиллагааны үр дүнгээр тодорхойлогдсон Монгол Улсын ашигт малтмалын нөөцийг бүртгэж архивлах ажлыг хариуцна.

3.5.7 БАЙГАЛЬ ОРЧИН НОГООН ХӨГЖЛИЙН ЯАМ

Тусгай зөвшөөрөл эзэмшигчид тусгай зөвшөөрлөө хүлээж аваад 30 хоногийн дотор байгаль хамгаалах төлөвлөгөө БОНХЯ-нд ирүүлэх ёстой байдаг ба яам уг тайланг хүлээн авч, хянах үүрэгтэй. .

Мөн яам нь компаниудын байгаль хамгаалах, нөхөн сэргээх ажилд төсөвлөсөн зардлын 50%-ийг тусгай дансанд төвлөрүүлдэг. Тухайн компани байгаль хамгаалах төлөвлөгөөгөө бүрэн хэрэгжүүлээгүй нөхцөлд уг 50%-ийг төлөвлөсөн зориулалтаар нь БОНХЯ зарцуулах эрхтэй..

3.5.8 ХӨДӨЛМӨРИЙН ЯАМ

Хөдөлмөрийн Яам нь иргэдийн хөдөлмөрийн гэрээ, ядуурлыг бууруулах, ажиллах нөхцлийг сайжруулах, амьдралын өртгийн асуудал зэргийг мөн Монгол Улсын нутаг дэвсгэр дээрх гадаадын иргэдийн хөдөлмөр эрхлэлт болон гаднаас ажиллах хүч авах асуудлуудыг хариуцаж ажиллах үүрэгтэй.

Тус яам нь ажил эрхлэлт болон зохистой ажлын орчныг дэмжих, мэргэжил чадварыг хөгжүүлснээр хүний нөөцийг сайжруулах, ажиллах хүчний өрсөлдөх, хөрвөх чадварыг дээшлүүлэх, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор бодлогоо хэрэгжүүлдэг.

Яам нь Төрийн захиргааны хэлтэс, Хөдөлмөр эрхлэлтийг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, хөдөлмөрийн харилцаа бодлого зохицуулалтын хэлтэс, ЖДҮ-ийн хөгжлийн хэлтэс, Мэргэжлийн

боловсролын газар, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын алба, санхүү, сангийн бодлого, төлөвлөлтийн газар гэсэн долоон газартай үйл ажиллагаа явуулж байна.

Тус яамны харъяа Засгийн газрын хэрэгжүүлэгч 5 агентлаг ажилладаг

- Хөдөлмөрийн төв бирж
- Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төв
- Хөдөлмөрийн судалгааны институт
- Хөдөлмөрийн эрүүл мэнд судалгааны төв
- Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан
-

3.5.9 ЦӨМИЙН ЭНЕРГИЙН ГАЗАР

"Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг байгуулах тухай" Засгийн газрын тогтоолын дагуу Цөмийн энергийн газар Монгол Улсын тохируулагч агентлагаар Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд үүргээ гүйцэтгэн ажилладаг.

Тус Агентлаг нь цөмийн энергийг ашиглах, цөмийн энергийн технологийг нэвтрүүлэх, Монгол Улсын төрийн бодлогын хүрээнд цөмийн энергийн талаар шинжлэх ухааны судалгааг зохион байгуулах, цөмийн болон цацраг идэвхт бодисын аюулгүй байдлыг хангах зохицуулалтыг хянах, үнэлэх үүрэгтэй.

Агентлаг нь гурван газартайгаар үйл ажиллагаагаа явуулдаг. Уг 3 газар нь Төрийн захиргааны удирдлагын газар, Цөмийн энергийн газар, Цөмийн болон цацрагийн хяналтын газар.

Тус агентлагийн гол хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь дараах хэлбэртэй байна.

- Цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги олборлох, цөмийн технологи ашиглах, цөмийн болон цацрагийн хамгаалалт, аюулгүй байдал, хяналтыг хангах талаархи төрийн бодлогыг хэрэгжүүлэх;
- Цацраг идэвхт ашигт малтмалын боловсруулалтын үйл ажиллагааг зохион байгуулах;
- Цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах, цөмийн технологийн хэрэглээ;
- Цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангах, илэрсэн зөрчлийг арилгах байх арга хэмжээ авах;

3.5.10 ХҮНИЙ ХӨГЖЛИЙН САН

УИХ-аас ашигт малтмал, уул уурхайн салбарын орлогоос хуримтлал үүсгэж, тогтвортой өсөн нэмэгдэх байнгын нөөц бүрдүүлэн иргэддээ тэгш хүртээх зорилгоор Хүний хөгжил сангийн тухай хуулийг 2009 оны 101 дүгээр сарын 18-ны өдөр баталсан. (Баялгийн сан хэрэгжиж эхэлснээр дуусгавар болох)

Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан иргэн бүрт 1.5 сая төгрөг олгох зорилтыг хангахтай холбогдуулан Хүний хөгжил сангаас 2010-2012 оны Хугацаанд нийт 923.5 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж, 1,867.0 тэрбум төгрөгийн зарлага гаргасан байна. (Бэлэн болон бэлэн бусаар иргэдэд хишиг, хувь хүртээж ирсэн)

3.5.11 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САН

1994 оны 05 дугаар сарын 31-нд Нийгмийн Даатгалын тухай хууль батлагдсан. Тус хуулиар Нийгмийн даатгалын төрөлийг тогтоож, шимтгэл төлөх, нийгмийн даатгалын санг бүрдүүлэх, зарцуулах болон тус байгууллагын болон байцаагчидийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлж, хэрэгжүүлэх зорилгоор

Уг хуулийн 12,1-д зааснаар Нийгмийн даатгалын сан тус бүрийн жилийн орлого, зарлагын төсвийг Улсын Их Хурал батална.

Нийгмийн даатгалын сангийн орлогын эх үүсвэр дараах байдалтай байна:-

- Даатгуулагчийн төлсөн нийгмийн даатгалын шимтгэл;
- Ажил олгогчийн төлсөн нийгмийн даатгалын шимтгэл;
- Сангийн чөлөөт үлдэгдлийг банкинд хадгалуулсны хүү, үнэт цаасны арилжаанаас олсон орлого;
- Нийгмийн даатгалын шимтгэл төлөх хугацаа хэтрүүлсэнд оногдуулсан алданги;
- Улсын төсвөөс олгох хөрөнгө;
- Бусад эх үүсвэр.

Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг хууль тогтоомжид заасан болзол журмын дагуу дор дурдсан зориулалтаар зарцуулна:

Тэтгэвэр, тэтгэмж олгох;

Нийгмийн даатгалын байгууллага, үндэсний болон салбар зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх;

Хууль тогтоомжид заасан бусад төлбөр, зардлыг санхүүжүүлэх.

Хуримтлалын сангийн хөрөнгийг Засгийн газрын бонд болон Монголбанкнаас гаргасан үнэт цаас худалдан авах, арилжааны банкинд байршуулах замаар нэмэгдүүлж болно.

Хуримтлалын сангаас Засгийн газрын бонд, Монголбанкны үнэт цаас худалдан авах хөрөнгийн хэмжээг нийгмийн даатгалын сангийн жил бүрийн төсөвт тусгаж, Улсын Их Хурал батална.

3.6 ТӨРИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН НЭГЖ⁶

3.6.1 УУЛ УУРХАЙН САЛБАР ДАХЬ ТӨРИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН НЭГЖҮҮД

ТӨХ-ны мэдээлснээр Төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээр бүртгэгдсэн 99 ААН-үүд байдаг байна.

Хамтарсан хувьцаат компани – 100% төрийн өмчийн	47
Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани	7
Төрийн өмчит үйлдвэр	25
Төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж	4
Хамтарсан үйлдвэр	5
Бусад аж ахуйн нэгж	11
Нийт	99

⁶ Эх сурвалж: АНУ-ын Геологийн судалгаа; Санхүү цаг үе; Монгол Улсын өсөлтийн групп; "Уул уурхай" журнал; Евроази Капитал; 2012 оны Монгол Улсын ОУИТБС-ын тайлан

Хүснэгт-25

Энэхүү жагсаалтад орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийг хамруулаагүй.

Төрийн өмчит болон орон нутгийн өмчит уул уурхайн компаниуд нь дараах байдалтай байна:

	Нэрс	Өмчийн хэлбэр	Ашигт Малтмал	Байршил
1	Эрдэнэс Монгол ХХК	Монгол Улсын Засгийн газар 100 хувь	Бор Нүүрс	Улаанбаатар
2	Эрдэнэс Таван толгой ХК	Эрдэнэс Монгол ХХК 100 хувь	Нүүрс	Улаанбаатар
3	Эрдэнэс Оюу Толгой ХХК	Эрдэнэс Монгол ХХК 100 хувь	Зэс, алт	Улаанбаатар
4	Багануур ХК	Эрдэнэс Монгол ХХК 75 хувь, Монголиан Нэшнл Коал Корпэрэйшн ХХК 21 хувь, бусад 4 хувь	Нүүрс	Улаанбаатар
5	Шивээ-Овоо ХК	Эрдэнэс Монгол ХХК 90 хувь, бусад 10 хувь	Нүүрс	Говь сүмбэр
6	Эрдэнэт үйлдвэр ХХК	Эрдэнэс Монгол ХХК 51 хувь, ОХУ-ын Засгийн газар 49 хувь	Зэс, молибдени	Орхон
7	Монголросцветмет ХХК	Монгол Улсын Засгийн газар 49 хувь, ОХУ-ын Засгийн газар 51 хувь	Нүүрс, Хайлуур Жонш, мөнгө	Улаанбаатар
8	Оюу толгой ХХК	Эрдэнэс ОюуТолгой ХХК 34 хувь, Канад 66 хувь	Алт, зэс	Улаанбаатар
9	Дарханы төмөрлөгийн үйлдвэр ТӨХК	Монгол Улсын Засгийн газар 100 хувь	Төмрийн хүдэр	Дархан-Уул
Орон нутгийн өмчит компаниуд				
1	Тавантолгой ХК	Орон нутгийн өмч 51 хувь, хувийн өмч 49 хувь	Нүүрс	Өмнөговь аймаг
2	Могойн гол ХК	Орон нутгийн өмч 48 хувь, хувийн өмч 52 хувь	Нүүрс	Хөвсгөл аймаг
3	Баянтээг ХК	Орон нутгийн өмч 70 хувь, хувийн өмч 30 хувь	Нүүрс	Өвөрхангай аймаг

Хүснэгт-26

3.6.1.1 ЭРДЭНЭС МОНГОЛ (100% ТӨР ЭЗЭМШДЭГ)

“Эрдэнэс Монгол” ХХК нь Монгол Улсын хамгийн том төрийн өмчит уул уурхайн компани бөгөөд Монгол улсын эзэмших, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд боловсруулахад Монгол Улсын Засгийн газрыг төлөөлөх зорилгоор байгуулагдсан байна.

3.6.1.1.1 “Эрдэнэс Монгол” ХХК-ийг үүсгэн байгуулах болсон үндэслэл:

Монгол Улсын Их Хурлын 2007 оны 27 дугаар тогтоолоор байгалийн баялгийг үр ашигтай, зүй зохистой ашиглах үүднээс тодорхой ашигт малтмалын ордуудыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод (цаашид САХБАМО гэх) хамааруулсан. Үүнтэй уялдуулан САХБАМО-ыг эдийн засгийн эргэлтэд оруулах, байгалийн баялгаа ашиглан төрийн өмчийг арвижуулах замаар Монгол Улсын нийгэм эдийн засгийн хөгжлийг хангах, ард иргэдэд тэгш хуваарилах, хишиг, хувь хүртээх зорилгоор УИХ-аас 2009 онд Хүний хөгжил сангийн тухай хуулийг баталсан байна.

Уг хуулиар САХБАМО-ын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн төрийн мэдлийн хувьцааг эзэмших эрхийг төрийн өмчит хуулийн этгээд хэрэгжүүлэхээр болсон байна.

“Эрдэнэс Монгол” ХХК (хуучнаар “Эрдэнэс МГЛ” ХХК) нь Монгол Улсын Засгийн газрын 2006 оны 101 дүгээр сарын 15-ны өдрийн 266 тоот тогтоол, Төрийн өмчийн хорооны 2007 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 52 тоот тогтоолоор байгуулагдсан ба 2010 онд Хүний хөгжил сангийн тухай хуулийн дагуу өөрчлөн зохион байгуулагдсан байна.


“Хүний хөгжил сангийн тухай” хуулийн 8.2-т “стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн төрийн мэдлийн хувьцааг эзэмших эрхийг төрийн өмчит хуулийн этгээд хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу Монгол Улсын Засгийн газраас “Эрдэнэс Монгол” ХХК-ийг Хүний хөгжил сангийн тухай хуулийн дагуу өөрчлөн зохион байгуулж, Засгийн газрын 2013 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 347 дугаар тогтоолоор “Эрдэнэс Монгол” ХХК-ийн дүрмийн шинэчилсэн найруулгыг баталсан байна.

“Эрдэнэс Монгол” ХХК-ийн дүрэмд зааснаар компани нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Хүний хөгжил сангийн тухай хууль, Компанийн тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, Цөмийн энергийн тухай хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон холбогдох бусад хууль, хууль тогтоомжийн бусад акт, компанийн дүрмийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

Компанийн дүрмийг дараах холбоосоор орж үзнэ үү.

<http://www.legalinfo.mn/annex/details/6041?lawid=9487>

3.6.1.1.2 Бүтэц зохион байгуулалт



“Эрдэнэс Монгол” групп нь Эрдэнэс Монгол корпораци болон 5 охин компаниас бүрдэнэ: -

Төрийн болон төрийн өмчийн оролцоотой, орон нутгийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг Хавсралт-15-аас харна уу.

3.6.1.1.3 Санхүүгийн урсгал

Нэгтгэлийн тайланд хамрагдсан нийт 250 компанийн 11 нь төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой, орон нутгийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компаниуд байсан.

Тэдгээрээс 5 аж ахуйн нэгж 2013 онд улсын болон орон нутгийн төсөвт ногдол ашиг төлсөн :

Төлбөрийг доорх хүснэгтээр харуулав

Сая төгрөгөөр

No.	Компаний Нэр	Дүн	Үүнээс	
			Улсын Төсөв	Орон Нутгийн Төсөв
1	Баянтээг ХК	16	-	16
2	Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр ТӨХК	2,129	2,129	-
3	Могойн Гол ХК	2	-	2
4	Таван Толгой ХК	7,799	-	7,799
5	Эрдэнэт үйлдвэр ХХК	68,300	68,300	-
	Нийт	78,246	70,429	7,817

Хүснэгт-27

3.6.1.2 ЭРДЭНЭС ОЮУ ТОЛГОЙ ХХК (ЭРДЭНЭС МОНГОЛ 34%)

"Эрдэнэс Оюу Толгой" ХХК нь 2009 оны 10 дугаар сарын 6-нд хийсэн Оюу Толгойн зэс-алтны ордыг хамтран хөгжүүлэх тухай Хөрөнгө оруулалтын гэрээний үр дүнд Оюу Толгой ХХК (ОТ)-ийн Засгийн газрын эзэмшдэг 34%-ийг хувьцаа эзэмшигчид гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулсанаар эзэмших болсон.

"Эрдэнэс Монгол" ХХК 2011 онд "Эрдэнэс Оюу Толгой" охин компанийг үүсгэн байгуулж "Оюу Толгой" ХХК-ийн хувьцааны 34 хувийг эзэмших эрхийг шилжүүлсэн.

Оюу Толгой төслийн нэг хэсэг болох 100 мянган тонн хүдэр өдөртөө боловсруулах хүчин чадал бүхий баяжуулах үйлдвэр нь 2012 оны 12 дугаар сард ашиглалтад орж, зэсийн баяжмал экспортлож эхэлсэн билээ.

Оюу Толгойн далд уурхайг 2016 онд ашиглалтад оруулахаар төлөвлөж буй бөгөөд энэхүү уурхай ашиглалтад орсноор ирээдүйд дэлхийн хэмжээний 5 том зэсийн уурхайн нэг болж Ази тивд олборлох нийт зэсийн 24%-ийг эзлэх болно.

3.6.1.3 ЭРДЭНЭС ТАВАН ТОЛГОЙ ХК (ЭРДЭНЭС МОНГОЛ 100%)

"Эрдэнэс Монгол" ХХК нь стратегийн ач холбогдол бүхий Тавантолгойн нүүрсний орд газарт ашиглалтын үйл ажиллагаа явуулах үүрэг бүхий "Эрдэнэс Таван Толгой" ХК-ийг өөрийн охин компанийн хэлбэрээр үүсгэн байгуулсан ба 2010 оны 8 дугаар сард үйл ажиллагааг нь эхлүүлсэн байна.

"Эрдэнэс Таван толгой" ХК 2011 оны 8 дугаар сараас БНХАУ руу нүүрс экспортолж эхэлсэн бөгөөд Таван толгойн нүүрсний ордын Цанхийн Зүүн хэсгийн талбайд 2012 оны 01 дүгээр сараас эхлэн гэрээт олборлогч Австралийн Макмахон компанитай хамтран ажиллаж байна.

Эрдэнэс таван толгой нүүрсний төсөл их хэмжээний хөрөнгө оруулалт шаардах учраас санхүүжилт босгох зорилгоор Эрдэнэс Таван Толгойн хувьцааг нээлттэй зах зээл дээр борлуулах юм.

3.6.1.4 "ШИВЭЭ ОВОО" ХК (ЭРДЭНЭС МОНГОЛ 90%)

"Шивээ Овоо" ХК нь 1990 онд Говь-Сүмбэр аймгийн нутагт орших Шивээ Овоогийн хүрэн нүүрсний ордод үйл ажиллагаагаа эхэлсэн бөгөөд 1995 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр шинэ бүтэц зохион байгуулалтаар ажиллаж байна. "Шивээ-Овоо" ХК-ийн нийт хувьцааны 90 хувийг төр, үлдсэн 10 хувийг хувьцаа эзэмшигчид эзэмшдэг. Шивээ-Овоо компанийн төрийн эзэмшлийн хувьцааг Засгийн газрын 100 дугаар тогтоолын дагуу 2013 оны 03 дугаар сарын 16-нд "Эрдэнэс Монгол" компанид шилжүүлснээр тус компанийн охин компани болсон байна.

3.6.1.5 "ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР" ХХК (ЭРДЭНЭС МОНГОЛ 51%)

"Эрдэнэт Үйлдвэр" ХХК нь анх 1978 онд Монгол-Оросын Засгийн газар хоорондын гэрээний дагуу Эрдэнэтийн Овоог түшиглэн байгуулагдсан ба зэс, молибдены хүдрийн олборлолт, баяжуулалтаар Ази тивд томоохонд тооцогдох үйлдвэр юм. Жилд дунджаар 26 сая тонн хүдэр боловсруулж 530 орчим

мян.тонн зэс, 4.5 орчим мян.тонн молибдены баяжмал үйлдвэрлэж байна. Тус компаний хувицааны 49%-ийг ОХУ-ын Засгийн газар, 51%-ийг Монгол Улсын Засгийн Газар тус тус эзэмшдэг бөгөөд Монгол Улсын Засгийн газрын 100 дугаар тогтоолын дагуу 2013 оны 03 дугаар сарын 16-нд монголын төрийн эзэмшлийн хувьцааг Эрдэнэс Монгол Компанид шилжүүлсэн байна.

Энэ нь хоёр улсын зэсийн төсөл дээр Монгол Улсын Засгийн газрыг төлөөлөх үүрэгтэй

3.6.1.6 БАГАНУУР ХК (ЭРДЭНЭС МОНГОЛ 75%)

Багануур ХК нь анх Төвийн эрчим хүчний системийн харъяа Дулааны цахилгаан станцуудыг нүүрсээр хангах зорилгоор байгуулагдсан бөгөөд 35 дахь жилдээ үйл ажиллагаагаа явуулж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 100 дугаар тогтоолоор Багануур ХК-ын төрийн мэдлийн хувьцааг Эрдэнэс Монгол компанид шилжүүлснээр тус компаний охин компани болсон байна.

3.6.1.7 МОНГОЛРОСЦВЕТМЕТ ХХК (49%-ИЙГ ТӨР ЭЗЭМШДЭГ)

“Монголросцветмет” ХХК нь Монгол Улсын хайлуур жоншны олборлолт үйлдвэрлэлийн салбарт тэргүүлэх зэргийн компани юм. Хэнтий аймагт Монголросцветмет компанийн эзэмшдэг хэд хэдэн хайлуур жонш боловсруулах уурхай байдаг.

“Монголросцветмет” ХХК нь хүчлийн болон металлургийн зэрэглэлтэй жоншны баяжмал аль алийг нь үйлдвэрлэдэг. Тус уурхай нь 120 мян.тонн баяжмалыг (90%-95% хольцгүй цэвэр) ОХУ руу химийн үйлдвэрт ашиглах зорилгоор ачуулсан байна.

3.6.1.8 ДАРХАНЫ ТӨМӨРЛӨГИЙН ҮЙЛДВЭР (100% ТӨР ЭЗЭМШДЭГ)

Дарханы төмөрлөгийн үйлдвэрийн нөөц 230 сая тонн бөгөөд стратегийн ордын жагсаалтанд орсон Сэлэнгэ аймгийн төмрийн хүдрийн ордын лицензийг эзэмшдэг байна. Өмнө нь тус тусгай зөвшөөрлийг Хятадын “Би Эл Ти” компани эзэмшиж байсан ба сайн чанарын хүдэр ихээхэн хэмжээгээр олборлосон байна.

“Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр” ТӨХК Металлурги-Уул уурхайн цогцолбор болохоор төлөвлөж байгаа юм. Төлөвлөгөөний хүрээнд, шинэ нойтон соронзон баяжуулах үйлдвэрийг энэ жилдээ багтаан үйл ажиллагааг эхлүүлэхийг зорьж байгаа бөгөөд барилгын ажил нь дууссан байна.

3.6.1.9 ТАВАНТОЛГОЙ ХК (51 %-ИЙГ ОРОН НУТАГ ЭЗЭМШДЭГ)

1967 оны 5 дугаар сараас эхлэн бие даасан улсын үйлдвэр болж, уурхайн эхлэлтийн балансыг зохиожээ. Тус уурхай нь зах зээлийн нөхцөлд зохицон 1994 оны 12 дугаар сарын 05-ны Засгийн газрын өмч хувьчлалын комиссийн хурлын 42 тоот тогтоолоор төрийн өмч давамгайлсан Тавантолгой ХК болсон байна.

3.6.1.10 МОГОЙН ГОЛ ХК (48%-ИЙГ ОРОН НУТАГ ЭЗЭМШДЭГ)

Могойн голын чулуун нүүрсний орд Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын нутагт Мөрөн хотоос баруун зүгт 223 км зайтай оршино.

Орон нутгийн 48 хувийн өмчтэй Могойн голын уурхай одоо хүчин чадлынхаа 10 хувийг ашиглан улирлын чанартай ажилладаг. Жилдээ 10 гаруй мянган тонн нүүрс борлуулдаг байна. “Могойн гол” компани нь 89.73 га газрыг хамарсан MV-000384 тоот ашиглалтын лицензтэй. Мөн 85.21 га газрыг хамарсан XV-013841 хайгуулын лицензтэй бөгөөд 2009 оны эхний байдлаар ашиглалтад бэлдсэн нөөц 2,207.9 мянган тонн, таамаг нөөц нь 11,441.6 мянган тонн гэсэн үзүүлэлттэй гарсан байна.

3.6.1.11 БАЯНТЭЭГ ХК (70%-ИЙГ ОРОН НУТАГ ЭЗЭМШДЭГ)

Баянтээг нүүрсний уурхай нь Монгол Улсын өмнө зүгт, Өвөрхангай аймгийн Нарийнтээл суманд байралдаг.

1962 онд жилд 25.0 мянгантонн нүүрс олборлох хүчин чадлаар байгуулагдаж, 1978 онд гүйцэтгэсэн нарийвчилсан хайгуулаар нөөцийг үйлдвэрийн зэрэгт шилжүүлэн 29.6 сая тоннийн нөөцтэй гэж тогтоосон байна.

Тус компани нь 1995 онд орон нутгийн эзэмшилтэй “Баянтээг” ХК болсон байна. Сууриа тавьсан цагаас хойш 50-н жилийн дотор 5,961 мянган м³ хөрс хуулалт хийсэн ба 4,861 мянган тонн нүүрс олборлож борлуулсан байна. Одоогоор тус компани нь Өвөрхангай, Баянхонгор, Архангай аймгуудын нүүрсний хэрэглээнд зориулж жилдээ 55.0-65.0 мянган тонн нүүрсээр хангадаг байна.

3.6.1.12 ТӨРИЙН ӨМЧИТ КОМПАНИУДЫН ЗАСАГЛАЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ СУДАЛГАА

Уул уурхайн яам болон Нээлттэй Нийгэм Форум 2014 оны 5-8 сарын хооронд төрийн өмчит уул уурхайн компаниудын засаглалын үнэлгээний судалгаа хийсэн.

Тус судалгаанд төрийн өмчит есөн уул уурхайн компанийг хамруулсан бөгөөд судалгааны дүнгээс үзэхэд манай улсад компанийн засаглалын зохицуулалт сайжирч, холбогдох дүрэм журам гарч байгаа ч судалгаанд хамрагдсан компаниудын засаглалын дундаж үнэлгээ хангалтгүй дүнтэй гарлаа. Ихэнхи компани авбал зохих онооны гуравны нэгийг л авсан бөгөөд зөвхөн Оюу Толгой ХХК талыг нь буюу 48 хувийн үнэлгээ авчээ. Компаниудын дундаж үнэлгээ 28 хувь байгаа Вьетнам, Филиппин, Тайланд, Хонконг зэрэг Азийн орнуудтай харьцуулахад даруй 1.5-2.5 дахин бага үнэлгээтэй байна. Ялангуяа, мэдээллийн ил тод байдал, чухал хэлцэл хийж буй байдал, хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлж байгаа байдал болон төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагаа хамгийн доголдолтой үзүүлэлтийн тоонд орж байна

Дэлгэрэнгүйг дараах линкээр орж үзнэ үү.

http://forum.mn/index.php?sel=project&menu_id=250&obj_id=4955#sthash.ss8R42nw.dpuf

Нээлттэй Нийгэм Форумын бэлтгэсэн Үнэлгээний үр дүнг доорх хүснэгтээр харууллаа.



График-16

3.6.2 ГАЗРЫН ТОСНЫ САЛБАР ДАХЬ ТӨРИЙН ОРОЛЦОО

Газрын тосны тухай хуулийг анх 1991 онд баталснаас хойш манай улсын эдийн засаг тэлж өссөн, газрын тосны салбар ч эрчимтэй хөгжсөн. 1991 оноос хойш Газрын тосны тухай хуулийг шинэчлээгүй, харин татварын хуулийг хэд хэдэн удаа өөрчлөн шинэчилсэн байдаг. Тиймээс хуучин хуульд цаг үетэйгээ нийцэхгүй зүйл заалт байсан.

Иймд УИХ хөрөнгө оруулагчдын оролцоог хангах замаар “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”-д нийцүүлэн Газрын тосны хуулийг бүхэлд нь шинэчлэн 2014 оны 7 дугаар сарын 1-нд баталсан байна.

Хууль шинэчлэгдэн батлагдсанаар:

- Газрын тосны салбарт төрийн байгууллагуудын чиг үүрэг, уялдаа тодорхойгүй байсныг цэгцэлсэн байна. Хуулийн 6 дугаар зүйлд Улсын их хурлын, 7 дугаар зүйлд Засгийн газрын оролцоог тодорхой заасан байна.
- Хөрөнгө оруулагчид бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулахын тулд олон шат дамжиж, цаг их алддаг байсан. Энэ хүнд суртлыг багасган, гэрээлэгчдийн аливаа өргөдөл хүсэлтэд хариу өгөх хугацааг хуульчилж эрх зүйн орчныг тодорхой, тогтвортой болгосон байна.
- Хайгуулын эхний таван жилд хөрөнгө оруулагчдыг НӨАТ болон гаалийн татвараас чөлөөлөх болсон байна.
- Өртөг нөхөгдөх зардлыг хянаж, баталгаажуулах чиг үүргийг төрийн аудитын байгууллагад шилжүүлсэн байна.
- Өмнө нь уламжлалт бус газрын тосны төрлийн бүтээгдэхүүнийг ашиглах тодорхой зохицуулалт байгаагүй, хатуу ашигт малтмал ч юм шиг, газрын тос ч юм шиг, аль агентлагаас зөвшөөрөл авах, ямар хуулиар явах нь тодорхойгүй байсан. Уламжлалт бус газрын тос болох нүүрсний давхаргын метан хий, шатдаг занар зэргийг эдийн засгийн эргэлтэд оруулж, хайгуул хийлгэн нөөцийг тогтоох эрх зүйн орчин бүрдүүлж өгсөн байна.

3.7 ТӨСВИЙН ХУВААРИЛАЛТ⁷

3.7.1 ТӨРИЙН САНХҮҮГИЙН ТОГТОЛЦОО

Монгол Улсын нэгдсэн төсөв нь доорх төсвүүдээс бүрдэнэ.

- Улсын төсөв,
- Орон нутгийн төсөв,
- Хүнийн хөгжлийн төсөв
- Нийгмийн даатгалын сангийн төсөв

УИХ-аас баталсан Засгийн газар бүрдүүлэн, зарцуулах төсвийг улсын төсөв гэнэ.

Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас баталсан аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын бүрдүүлэн, зарцуулах төсвийг орон нутгийн төсөв гэнэ. Орон нутгийн төсөв нь аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвөөс бүрдэнэ.

Хүний Хөгжлийн Сангийн тухай “Тайлангийн 3.5.10-р хэсэг”-т дурьдсан. Мөн уг “Тайлангийн 3.8-р хэсэг”-т орлогын хувиарлалтын талаар дурьдсан.

Нийгмийн Даатгалын Сангийн тухай “Тайлангийн 3.5.11-р хэсэг”-т дурьдсан.

Төсвийн орлого нь тогтворжуулалтын сангийн болон тэнцвэржүүлсэн орлогоос бүрдэнэ. Тэнцвэржүүлсэн орлого нь урсгал орлого, хөрөнгийн орлого, тусламжийн орлогоос бүрдэнэ. Татварын болон татварын бус орлогоос урсгал орлого нь бүрдэнэ. Татварын орлогод орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэл, хураамж, өмчийн татвар, дотоодын бараа болон үйлчилгээний татвар, гадаад худалдааны татварын орлого болон бусад татвар орно. Төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг, хүү, торгуулийн орлого, түрээсийн орлого, төсөвт газрын өөрийн орлого болон татварын бус бусад орлогоос татварын бус орлого бүрдэнэ.

3.7.2 ТӨСВИЙН ХУУЛЬ ТОГТООМЖ

Монгол Улсын төсвийн бодлого доор дурьдсан хуулийн хүрээнд зохицуулагдана.

3.7.2.1 Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, 2010

2010 оны 6 дугаар сард Монгол Улсын Их Хурлаас улсын ашигт малтмалын нөөцийг, тогтвортой өсөн нэмэгдэх, бага инфляцийн дагуу ашиглаж байгаа эсэхийг хангах зорилгоор Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг баталсан. Тухайн хууль хоёр зарчмын хэсгээс бүрдэнэ:

- ❖ Энэхүү хуулиар ирээдүй дэх тэнцвэрт алдагдлын хувь, өрийн зөвшөөрөгдөх хэмжээ, зарлагын өсөлтийн хувь болон төсвийн орлогын тооцооллын процесс зэргийг тодруулж өгсөн. Үүнд”

⁷ Эх сурвалж: Монгол Улсын Сангийн яам; Европын Сэргээн босголт ба Хөгжлийн банк; "Би Эл Ти" хуулийн фирм; ОУВС, "Уул уурхай" журнал; "Ди Эл Эй Папер" хуулийн фирм; "Олон улсын татвар" ярилцлага ; "Газрын тос ба байгалийн хий" сэтгүүл

- ЗГ-ын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдэл нь тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний 40 хувиас хэтрэхгүй байх.
 - Тухайн жилийн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь нь тухайн жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн хувь, тухайн жилийн өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн дунджийн аль ихээс хэтрэхгүй байна.
 - Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байна. /2013 оны төсвийн жилээс дагаж мөрдөнө./
- ❖ Төсвийн тусгай шаардлагад нийцүүлэн баталсан дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлээр төсвийн бодлогыг тодорхойлсон байх. Энэхүү хүрээ нь Засгийн газрын санхүүгийн зорилтуудыг, түүний хүлээгдэж буй төсвийн гүйцэтгэл, болон макро эдийн засгийн (ажил эрхлэлтийн түвшин, хэрэглээний үнийн индекс, гэх мэт) болон дараагийн гурван жилд төсвийн төсөөлөл (төсвийн тэнцэл, төсвийн хөрөнгө оруулалт, гэх мэт) агуулсан байх ёстой.

3.7.2.2 Төсвийн тухай хууль

Энэ хуулийн зорилт нь төсөв, түүний зарчим, тогтолцоо, бүрэлдэхүүн, ангиллыг тогтоож, төсвийн тусгай шаардлагыг хэрэгжүүлэх, төсвийн харилцаанд оролцогчийн эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлж, төсөв боловсруулах, батлах, зарцуулах, бүртгэх, тайлагнах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

3.7.2.3 Засгийн газрын тусгай сангийн тухай хууль

Энэ хуулийн зорилт нь Засгийн газрын тусгай сангийн төрлийг тогтоож, эдгээр санг бүрдүүлэх, зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах, хянахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

3.8 ОРЛОГЫН ХУВААРИЛАЛТ

3.8.1 ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

2011 оны Төсвийн тухай хуулинд олборлох салбараас орсон орлогын хуваарилалтыг тодорхой тусгасан байдаг.

- Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр,
- Ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр
- Газрын тосны нөөц нөөц ашигласны төлбөр
- Газрын тосны ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр

Улсын төсвийн орлогыг бүхэл дүнгээр хуваарилдаг учраас уул уурхайн салбарын орлогын хуваарилалтыг тусад нь харуулах боломжгүй.

Төсвийн тухай хуулийн 2011 оны нэмэлт өөрчлөлтийн дагуу олборлох үйлдвэрлэлийн олсон төлбөр, орлогын хуваарилалтыг доор үзүүлэв:

Олборлох салбарын Улсын төсөв бүрдүүлэх төлбөр	Хүний Хөгжил Сан	Улсын төсөв	Орон нутгийн хөгжлийн сан	Аймаг, нийслэл	Сум, дүүрэг
Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	70%	25%	5%		
Хүний хөгжлийн сангийн тухай хууль 3.2.2;					
Төсвийн тухай хууль 59.1.2					
Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд ашиглалтаас орсон төлбөр/ эсвэл зээлийн тодорхой хэсэг	Зарим хэсэг				
Хүний хөгжлийн сангийн тухай хууль 3.2.4					
Газрын тосны хайгуулын ба ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр		70%	30%		
Төсвийн Тухай хууль: 23.4.12; 59.1.5					
Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа хуулийн этгээдээс төрд ноогдох хувьцааны борлуулалт, хувьцааны ногдол ашгаас орох орлого, Хүний хөгжлийн сангийн тухай хууль 3.2.1	ЗГ-т ноогдох төлбөр				
Газрын тосны нөөц ашигласны төлбөр					
Төсвийн тухай хууль: 23.4.11; 23.6.9; 23.8.13		70%		20%	10%

Хүснэгт-28

Эх сурвалж: <http://www.legalinfo.mn/law/details/504>

3.8.2 ХҮНИЙ ХӨГЖИЛ САН

3.8.2.1 ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Хүний Хөгжил Сангийн орлого нь дараах эх үүсвэрүүдээс бүрдэнэ.

1. Эрдэнэт Үйлдвэр ХХК-ийн 2012 оны үйл ажиллагааны ногдол ашиг, Хүний хөгжил сангийн тухай хуулийн 3.2.1-т заасны дагуу,
2. Ашигт малтмалын орд газарт ашигт малтмал олборлох, боловсруулах үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээдийн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн 70 хувь;
3. Энэ хуулийн 5.1-д заасан хөрөнгө оруулалтаас орох цэвэр ашиг;
4. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд ашиглахтай холбогдуулан авсан урьдчилгаа мөнгө, зээлийн тодорхой хэсэг.

Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан иргэн бүрт 1.5 сая төгрөг олгох зорилтыг хангахтай холбогдуулан Хүний хөгжил сангаас 2010-2012 оны Хугацаанд

нийт 923.5 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж, 1,867.0 тэрбум төгрөгийн зарлага гаргасан байна. (Бэлэн болон бэлэн бусаар иргэдэд хишиг, хувь хүртээж ирсэн)

3.8.2.2 2013 ОНЫ ТӨСВӨӨС ХҮНИЙ ХӨГЖИЛ САНД ХУВААРИЛСАН ОРЛОГЫН ХУВААРИЛАЛТ:

1. Эрдэнэт Үйлдвэр ХХК-ийн 2012 оны үйл ажиллагааны ногдол ашиг тус 70.0 тэрбум, Хүний хөгжил сангийн тухай хуулийн 3.2.1-т заасны дагуу,
2. Ашигт малтмалын орд газарт ашигт малтмал олборлох, боловсруулах үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээдийн АМНАТ-ын улсын төсөвт ногдох хэсэг 397.6 тэрбум төгрөг
3. Хүний хөгжил сангийн тухай хуулийн 3.2.2-т заасны дагуу,
4. Засгийн газрын 2012 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдаанаар өгсөн чиглэлийн дагуу Оюутолгойн хөрөнгө оруулалтын гэрээнд өөрчлөлт оруулсанаар өсөн нэмэгдэх нөөц ашигласны төлбөр 154.4 тэрбум төгрөгийг Хүний хөгжил сангийн тухай хуулийн 3.2.2-т заасны дагуу төвлөрүүлэх боломжтой гэж төсөлд тусгасан.

Гэвч Төсвийн тодотгосон хуулиар уул уурхайн голлох нэрийн бүтээгдэхүүн болох зэс, нүүрсний борлуулалтын үнэ болон биет хэмжээ буурсанаас болж (нүүрсний биет хэмжээ 2.1 сая тонноор, алт тушаалтын хэмжээ 2.8 тонноор буурсан) голлох нөлөө үзүүлсэн байна. “Эрдэнэт Үйлдвэр” ХХК-ийн цэвэр ашиг буурсан, “Оюутолгой” ХХК-ийн гэрээнд өөрчлөлт оруулах асуудал шийдэгдээгүйгээс ХХС-д төвлөрөх АМНАТ-ийн орлогын төлөвлөгөөг 222.1 тэрбум төгрөгөөр бууруулж баталжээ.

	Орлогын Нэр төрөл	Анхны Төсөв	Тодотгосон Төсөв	Гүйцэтгэл	Зөрүү
1	Ногдол ашиг орлого ба хувьцааны борлуулалтын орлого (ХХС-ын тухай хуулийн 3.2.01 дүгээр зүйлийн дагуу)	70.0	68.3	68.3	-
2	Улсын төсөвт хуваарилах АМНАТ (ХХС-ын тухай хуулийн 3.2.2 дугаар зүйлийн дагуу)	551.4	329.3	325.0	(4.3)
3	Урьдчилгаа (ХХС-ын тухай хуулийн 3.2.4 дүгээр зүйлийн дагуу)	-	-	-	-
4	Банкны хүүгийн орлого	-	-	0.2	0.2
	Нийт орлого	621.4	397.6	393.5	(4.1)

Хүснэгт-29

3.8.3 ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН НЭГДСЭН САН

Тухайн шатны төсвийн ерөнхийлөн захирагч нь орон нутгийн хөгжлийг дэмжих зорилго бүхий Орон нутгийн хөгжлийн сантай байна гэж Монгол Улсын Төсвийн тухай хуулинд (60.1) заасан байдаг. Баг, хорооны Засаг дарга Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дараалал, арга замын талаар баг, хороодод

олон нийтийн нээлттэй санал асуулга явуулна. (63.1) мөн судалгаа болон асуулган дээр үндэслэн Аймаг, нийслэл нь орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгосон шилжүүлгийн 60-аас доошгүй хувийг сум, дүүргийн хөгжлийн санд энэ хуулийн 59.3-т заасан үзүүлэлтийг харгалзан хуваарилна. (59.2)

2013 оны төсвийн гүйцэтгэлээр орон нутгийн хөгжлийн санд АМНАТ-ийн орлогын 5 хувь болох 28.3 тэрбум төгрөгийг төсөвлөөд, Төсвийн тодотгосон хуулиар 4.8 тэрбум төгрөгөөр бууруулсан байна.

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас тухайн жил орон нутгийн төсөвт олгох шилжүүлгийг тодорхойлохдоо “Төсвийн тухай хууль”-ийн 59.3-д заасан итгэлцүүрийг үндэслэн тогтооно:

Улсын нэгдсэн төсвийн аудитын тайлангаар “Уул уурхайн салбараас орсон татварын орлогын хэмжээ 2013 онд 1,147.0 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 259.1 тэрбум төгрөгөөр буюу 29.2 хувиар нэмэгдсэн” гэсэн мэдээ байна. Энэ нь манай улсын нийт төсвийн орлогын 20 гаруй хувийг эзэлж байна.

Монгол Улсын 2013 оны төсвийн тодотголын задаргааг доорх линкнээс харна уу:

<http://www.iltod.gov.mn/?p=3095>

3.9 УУЛ УУРХАЙН САЛБАРЫГ ХӨГЖҮҮЛЭХ БОДЛОГО

Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны мөрийн хөтөлбөрт уул уурхайн салбарыг хөгжүүлэх чиглэлээр дараах бодлогыг хэрэгжүүлнэ гэж заасан. Үүнд:

- Нутаг дэвсгэрийн геологийн зураглал, эрэл, хайгуулын ажилд зарцуулж байгаа улсын төсвийн хөрөнгө оруулалтыг жил бүр нэмэгдүүлж, геомэдээллийн санг баяжуулах, эрдэс баялгийн нөөцийг өсгөн нэмэгдүүлэх замаар уул уурхайн салбарыг тогтвортой хөгжүүлэх бодлогыг дэмжих,
- Нутаг дэвсгэрийн геологийн тогтоц, ашигт малтмалын тархалтын зүй тогтол, хэтийн төлөвийг судлах зорилгоор улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа 1:50000 масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажилд 2016 онд нийт нутаг дэвсгэрийн 40 хувийг хамруулах,
- Геологийн салбарын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох ажлын хүрээнд
- Монголын үндэсний геологийн албыг шинээр байгуулах
- Эрдэс баялгийн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох
- Эрдэс баялгийн экспортыг нэгдсэн “Нэг цонх”-ны бодлогоор хэрэгжүүлэх
- Уул уурхайн салбарт хэрэгжиж байгаа төслүүдэд үндэсний аж ахуйн нэгжүүд давуу эрхээр бараа, ажил, үйлчилгээ нийлүүлэх, туслан гүйцэтгэгчээр ажиллах эрх зүйн орчныг бүрдүүлэх,
- Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын жагсаалтыг шинэчлэн, томоохон орд газруудыг эдийн засгийн эргэлтэд оруулахыг эрчимжүүлэх, Стратегийн ач холбогдол бүхий ордын төрийн эзэмшлийг нэгтгэн, корпорацийн зохион байгуулалтад оруулж, Хүний хөгжлийн сангийн тухай хуулийн дагуу иргэдэд давуу эрхийн хувьцаа олгоно,
- Алтны олборлолт, хадгалалт, борлуулалтыг ил тод болгох

- Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмыг боловсронгуй болгож, хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах
- Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга болон хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх санаачилга, тэдгээрийн зарчмууд болон стандартыг нэвтрүүлэх
- Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, олборлох, ашиглахыг хориглох тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, байгальд ээлтэй уул уурхайг хөгжүүлэх,
- Байгалийн нөөцийн эдийн засгийн стстистикийг шинэчилж, улсын эдийн засаг, санхүүд эрдэс баялгийн салбарын үзүүлж байгаа нөлөөллийн үзүүлэлтийг системтэй тооцоолох аргачлалыг холбогдох эрх бүхий байгууллагатай хамтран хэрэгжүүлэх тогтолцоог бий болгох,
- Эдийн засгийн өсөлтийн тогтвортой байдлыг хангахын тулд ашигт малтмалыг түүхий эд хэлбэрээр гаргахыг үе шаттай багасгах, түүнчлэн экспортолж байгаа бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинг олон улсын стандартад нийцүүлэн шат дараатай ахиулж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх бодлого баримтлах
- Дархан-Сэлэнгийн бүсийн төмрийн хүдрийн ордуудыг түшиглэн орчин үеийн техник, технологи бүхий төмөрлөгийн цогцолбор үйлдвэр барих
- Гадаадын шууд хөрөнгө оруулагчидтай харилцан ашигтай байх зарчмыг баримтлан ажиллах, уул уурхай, эрчим хүч, газрын тосны салбарт өмнө нь байгуулсан тогтвортой байдлын, хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн хуваах гэрээнүүдэд өөрчлөлт оруулах асуудлыг судалж, холбогдох өөрчлөлтүүдийг хөрөнгө оруулагч талтай харилцан тохирож хийх,
- Таван толгойн орд газрыг төрийн мэдэлд байлгах, Тус орд газрыг ашиглах зорилгоор олборлох үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгж, компанийг дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдыг татах замаар байгуулан ажиллуулна. Улмаар Тавантолгойн орд газрыг түшиглэн дотоод, гадаадын хөрөнгийн бирж дээр хувьцааг худалдах ажлыг УИХ-ын шийдвэрийн дагуу зохион байгуулна.
- Тусгай зөвшөөрлийн арилжаанд ил тод байдлыг бүрдүүлэх
- Байгаль орчинд ээлтэй, шилдэг техник, технологийг уул уурхайн үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлж, эдвэрэлд орсон талбайн тооллого хийж, буруутай этгээдээр нөхөн сэргээлгэж, цаашид нөхөн сэргээлтийн зардлыг улсын төсвийн тусгай санд байршуулдаг болгох,
- Уул уурхайн салбарын түүхий эдэд нэмүү өртөг шингээх бодлого хэрэгжүүлэн хагас болон эцсийн бүтээгдхүүн үйлдвэрлэн, экспортолж, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдхүүн үйлдвэрлэгчдийг татварын бодлогоор хөхүүлэн дэмжих
- Уул уурхайн салбараас эдийн засгийн хамаарлыг бууруулах, урт хугацааны тогтвортой хөгжлийг хангах, өрсөлдөх чадвар бүхий олон тулгуурт эдийн засгийг бий болгох нь эдийн засгийн бодлогын тэргүүлэх зорилт байна.

Эрдэс баялгийн салбарт дараах зүйлсийг хийж гүйцэтгэсэн байна. Тухайлбал:

- Монгол Улсын Их хурлын Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого батлах тухай 2014 оны 01 сарын 16 өдрийн 18 тоот тогтоол
- Газрын тосны тухай хуулийг шинэчлэн батлуулсан.
- Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан.

3.10 ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ЖУРАМ ⁸

3.10.1 УУЛ УУРХАЙ

3.10.1.1 ХУУЛЬ ТОГТООМЖ

3.10.1.1.1 Монгол Улсын Ашигт Малтмалын тухай хууль, 2006

2006 оны 7 дугаар сард Монгол Улсын Засгийн газраас ус, газрын тос, байгалийн хий, цацраг идэвхт болон түгээмэл тархацтай ашигт малтмалаас бусад төрлийн ашигт малтмал эрэх, хайх, ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор одоогийн ашигт малтмалын тухай хуулийг баталсан.

- ❖ Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өөрийн тусгай зөвшөөрөл бүхий талбайд ус, газрын тос, байгалийн хий, цацраг идэвхт ашигт малтмалаас бусад ашигт малтмалын хайгуул болон олборлолт хийх онцгой эрхтэй. Уул уурхайн лицензийг эхний ээлжинд 20 жилийн хугацаатайгаар олгодог бөгөөд дараа нь хоёр удаа тус бүр 10 жилийн хугацаатайгаар сунгаж болно.
- ❖ Хөрөнгө оруулалтын дүнгээс хамааран уул уурхайн тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Монгол Улсын Засгийн газартай 10-30 жилийн Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах эрхтэй. Тус гэрээгээр хөрөнгө оруулагчдад ААНОАТ, гаалийн албан татвар, НӨАТ, АМНАТ-ийн тогтвортой хувь болон бусад үйл ажиллагааны тогвортой шаардлагууд бий болгодог.
- ❖ Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрөл бүхий талбайнхаа ашигт малтмалын нөөцийг тогтоож, бүртгүүлбэл АМГ-тай олборлолтын өмнөх гэрээ байгуулж болох ба уг гэрээ нь ТЭЗҮ, уулын ажлын төлөвлөгөөгөө боловсруулж, олборлолтын лиценз авч, үйлдвэрлэл эхлүүлэх нэмэлт 3 жилийн хугацаа өгдөг

3.10.1.1.2 Нэмэлт өөрчлөлт, 2014

2014 оны 7 дугаар сард Монгол Улсын Засгийн газар “Ашигт малтмалын тухай” хуулинд 13 шинэ заалттай, хуучин заалтуудаа нилээд шинэчилсэн нэмэлт өрчлөлтийг оруулж баталсан байна. Үүнд:

- Үндэсний геологийн судалгаа болон бодлогын зөвлөлийг бий болгож уул уурхайн салбар дахь хууль эрх зүйн өөрчлөлтийг хянах
- Монгол Улсын хайгуул, болон олборлолтыг нээлттэй тайлбайг 8%-20% хүртэл нэмэгдүүлэх зорилгоор 2010 оны хайгуулын лицензийн хорио тавигдсан.
- Хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацааг 9 жил байсныг 12 жил болгон сунгаж ашиглалтын өмнөх гэрээ хийх шаардлагыг хассан.

⁸ Херберт Смит Freehills; Hogan Lovells хуулийн фирм

3.10.1.1.3 Монгол Улсын тусгай зөвшөөрөл олгох тухай хууль, 2001

2001 оны 2 дугаар сард Монгол Улсын Их Хурал ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл хүсэх үйл явцыг тодорхойлж, зохицуулах зорилгоор тусгай зөвшөөрөл олгох тухай хуулийг баталсан.

- ❖ Ашигт малтмалын хэрэг эрхлэх газраас олгогдож буй ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийг тухайн лицензийн харъяалагдах аймгийн Засаг дарга баталсан байх ёстой.
- ❖ Тус хууль нь орон нутгийн засаг захиргаа, өөрөө удирдах байгууллага болон улсын мэргэжлийн хяналтын газрын геологи, уул уурхайн тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн биелэлтэнд хяналт тавих үүрэг, хариулагыг тодорхойлсон.
- ❖ Ашиглалт болон хайгуулын тусгай зөвшөөрлийг зөвхөн Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан хязгаарлагдмал хариуцлагатай компани болон хувьцаат компанид олгоно. Монгол Улсын иргэн, гадаадын иргэнийг ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчээр бүртгэхийг зөвшөөрөхгүй.

3.10.1.1.4 Монгол Улсын Газрын тухай хууль, 2002

2002 оны 6 дугаар сард Монгол Улсын Их Хурлын баталсан Газрын тухай хуулинд Монгол Улсын бус иргэн болон байгууллагад гурван өөр төрлийн газрын эрх болон тэдгээрийн тус тусын ашиглагдах байдлыг заасан.

- ❖ 25%-иас дээш хүртэл хөрөнгийг гадаадын эх үүсвэрээс төлсөн гадаадын байгууллага, гадаадын иргэн болон Монгол Улсын байгууллага газар өмчлөх болон эзэмших эрх байхгүй харин ашиглах эрхтэй.
- ❖ Газар ашиглах эрхийг тухайн шатны төрийн захиргааны байгууллага баталсан байх ёстой. Төлбөл зохих хэмжээг зарлан тунхаглах эрх бүхий аймгийн төлөөлөгчдийн хурал (сонгогдсон албан тушаалтнуудын уулзалт)-аар уг төлбөрийн хэмжээг өөрчилж байдаг.

3.10.1.2 Цацраг Идэвхт Ашигт Малтмал

Цөмийн энергийн тухай хуулийн 18.9 дүгээр зүйлд "Төрийн захиргааны байгууллага нь тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл болон холбогдох бусад баримт бичгийг хянан үзэж тусгай зөвшөөрөл олгох шийдвэрийг энэ хуулийн 15.1.1- 15.1.4, 15.1.6; 15.1.7-д заасны дагуу 6-12 сарын дотор, мөн энэ хуулийн 15.1.5; 15.1.8-д заасаны дагуу үйл ажиллагааны онцлогийг харгалзан 1-3 сарын дотор гаргах үйл ажиллагааг хангана".

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2011 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн 181 дүгээр зарлигаар цацраг идэвхт ашигт малтмалын хайгуул /олборлолтын тусгай зөвшөөрлийг олгох шийдвэр гаргахын өмнө Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж байхыг үүрэг болгосон байна. Үүний дагуу цацраг идэвхт ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн асуудлыг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөр хэлэлцүүлсэний дараа шийдвэрлэж байна.

Тус газар нь одоогийн байдлаар тусгай зөвшөөрлийн шинэ бүртгэлийн систем /программ хангамжийг боловсруулж байгаа бөгөөд уг программ хангамжийг ашиглаж эхэлсэнээс хойш цахим хуудсанд тусгай зөвшөөрлийн мэдээллийг байршуулна. Уг мэдээлэлд цацраг идэвхт ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй холбоотой дэлгэрэнгүй мэдээлэл байхаас гадна, шинээр тусгай зөвшөөрөл хүссэн, тусгай зөвшөөрлийг хэсэгчилсэн ба бүтнээр нь буцаах өргөдөл болон хайгуулын тайлан, төлөвлөгөө зэргийг цахим сүлжээгээр хүлээн авдаг болох юм.

3.10.2 ЛИЦЕНЗ ОЛГОЛТЫН ЕРӨНХИЙ БАЙДАЛ

3.10.2.1 Ерөнхий мэдээлэл

Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хайгуулын талбайн хилийн дотор тусгай зөвшөөрлийн хугацаанд цацраг идэвхт ашигт малтмал эрэх, хайх онцгой эрхтэй бөгөөд хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий талбайн аль ч хэсэгт ашиглалтын тусгай зөвшөөрөл хүсэх эрхтэй.

Тусгай зөвшөөрлийн жил бүрийн төлбөр нь эхний жилдээ га тутамд 0.10 ам.доллар байх ба энэ нь тусгай зөвшөөрлийн хугацааны турш аажмаар нэмэгддэг байна. Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тодорхой хэмжээний зардал бүхий хайгуулын ажлыг тухайн тусгай зөвшөөрлийн 2 дахь жилээс эхлэн хийж гүйцэтгэнэ.

Хайгуулын тусгай зөвшөөрөл хүсэгч нь Ашигт малтмалын газарт хүсэлтээ гаргаж байх ёстой. Мөн тус газар нь ажлын 20 өдрийн дотор тусгай зөвшөөрөл олгох боломжгүй ямар нэгэн шалтгаан байвал өргөдөл гаргагсан этгээдэд мэдэгдэх шаардлагатай. Хэрэв сонгосон газар ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох боломжтой бол дүгнэлт гаргуулахаар аймгийн Засаг даргад мэдэгдэл өгч, Аймгийн засаг дарга 30 хоногийн дотор хариу өгөх бөгөөд энэ хугацаанд хариу өгөөгүй бол тухайн саналыг зөвшөөрсөн гэж үзнэ. Засаг даргын гаргасан эерэг дүгнэлт мөн (ямар ч дүгнэлт өгөөгүй) тохиолдлуудад тухайн тусгай зөвшөөрөл хүчин төгөлдөр болдог.

Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өөрийн тусгай зөвшөөрөл бүхий тайлбайдаа ашигт малтмалын хайгуул, олборлолт (ус, газрын тос, цацраг идэвхт ашигт малтмалаас бусад) явуулах онцгой эрхтэй. Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн үргэлжлэх хугацааг эхний ээлжинд 30 жилээр олгодог ба дараа нь 2 удаа тус бүр 20 жилийн хугацаатайгаар сунгагдаж болдог. Иймээс уул уурхайн тусгай зөвшөөрлийн хамгийн дээд хугацаа нь 70 хүртэл жил байна.

Хайгуулын Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрөл бүхий нийт талбайдаа ашиглалтын тусгай зөвшөөрөл хүсэх бүрэн эрхтэй. Ашигт малтмалын нөөц нь хүсэлт гаргаж буй тайлбайн хайгуулын үр дүнгийн тайлан, Эрдэс Баялгийн Зөвлөлд бүртгүүлсэн байдал мөн БОНБУ хийгдсэн зэргээр тодорхойлогдоно. Тусгай зөвшөөрөл хүсэгчийн хүсэлт гаргасан талбай нь олборлолт явуулах боломжгүй талбай давхцаж буй эсэх мөн ашигт малтмалын нөөцийн хэмжээ, үнэлгээ нь олборлолтоос үүсч болох экологийн хохирол учруулж болзошгүй эсэхийг нотлуулахаар уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хандана.

Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ашиглалт эхлэхээс өмнө АМГ-тай олборлолтын өмнөх гэрээ байгуулж болох ба уг гэрээ нь ТЭЗҮ, уулын ажлын төлөвлөгөөгөө боловсруулж, олборлолтын лиценз

авч, үйлдвэрлэл эхлүүлэх нэмэлт 3 жилийн хугацаа өгдөг. Энэхүү заалт нь 2014 оны 7 дугаар сард батлагдсан шинэчилсэн найруулгаар хүчингүй болсон.

3.10.2.2 Одоо ашиглаж байгаа лицензийн ерөнхий байдал

2013 оны байдлаар тусгай зөвшөөрөл эзэмшиж эмхэтгэсэн мэдээллийг хураангуй байдлаар Хүснэгт 30-д харуулж байна.

	ААН-ийн тоо	Лицензийн тоо	Үүнээс	
			Ашиглалтын	Хайгуулын
Цацраг идэвхт ашигт малтмал	14	68		68
Бусад ашигт малтмал	1,660	3,029	1,300	1,729
Газрын тос	17	21	3	18
Нийт	1,691	3,118	1,303	1,815

Хүснэгт-30

Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг тайлангийн **(Хавсралт-13-ийн “а,б,в,г”-ээс) харна уу.**

Тусгай зөвшөөрөл олголтын талаарх сүүлийн жилүүдийн эмхэтгэсэн мэдээллийг доорх График-17-д харууллаа.




График-17

Хүснэгт 31-т тусгай зөвшөөрлийг газар зүйн бүс нутгаар нарийвчлан авч үзүүлээ.

Аймаг	Тусгай зөвшөөрлийн тоо			Талбайн хэмжээ /га/			Нийт газар
	Ашиглалт	Хайгуул	Нийт	Ашиглалт	Хайгуул	Нийт	
Архангай	26	30	56	12,540.29	180,711.31	193,251.60	3%
Баян-Өлгий	25	49	74	8,742.14	411,959.85	420,701.99	9%
Баянхонгор	65	95	160	40,168.33	663,648.22	703,816.55	6%
Булган	55	41	96	19,605.38	474,163.66	493,769.04	10%
Говь-Алтай	18	123	141	4,431.16	2,005,389.74	2,009,820.90	14%
Говь-Сүмбэр	7	15	22	5,408.79	139,549.94	144,958.73	26%
Дархан-Уул	61	35	96	8,157.41	44,661.54	52,818.95	16%
Дорноговь	134	253	387	67,907.73	2,367,298.47	2,435,206.20	22%
Дорнод	57	115	172	40,050.45	789,396.52	829,446.97	7%
Дундговь	66	124	190	67,614.49	963,845.67	1,031,460.16	14%
Завхан	5	37	42	6,825.14	230,378.82	237,203.96	3%
Өвөрхангай	25	21	46	8,197.86	239,907.10	248,104.96	4%
Өмнөговь	67	203	270	448,879.19	3,533,226.85	3,982,106.04	24%
Сүхбаатар	45	123	168	29,739.23	1,817,817.25	1,847,556.48	22%
Сэлэнгэ	103	95	198	27,592.81	195,161.35	222,754.16	5%
Төв	376	202	578	66,536.00	420,497.01	487,033.01	7%
Увс	40	49	89	5,850.50	301,834.70	307,685.20	4%
Ховд	18	65	83	4,968.02	596,242.03	601,210.05	8%
Хөвсгөл	15	36	51	6,473.31	225,238.10	231,711.41	2%
Хэнтий	95	104	199	34,230.62	432,914.76	467,145.38	6%
Дүн	1303	1815	3118	913,918.85	16,033,842.89	16,947,761.74	11%

Хүснэгт-31

3.10.3 УУЛ УУРХАЙН КАДАСТР

3.10.3.1 АШИГТ МАЛТМАЛЫН ГАЗАР

Ашигт малтмалын газарт Дэлхийн банкны санхүүжилтээр “Уул уурхайн салбарын институцийг бэхжүүлэх техник туслалцааны төсөл”-ийн дэд хэсэг болох “Уул уурхайн кадастрын компьютержсэн системийг интернетийн орчинд байршуулах төсөл” 2012 оноос эхэлсэн ба 2014 онд амжилттай хэрэгжиж дууссан байна.

Энэхүү системийн хувьд орчин үеийн газарзүйн мэдээллийн систем болон хүчирхэг өгөгдлийн санд суурилагдсан, мэдээллийн аюулгүй байдал, найдвартай ажиллагааг бүрэн хангасан байна.

Ашигт малтмалын газрын кадастрын хэлтсийн дарга: Кадастрын үйл ажиллагааны үндсэн горимууд автоматчилагдаж, энгийн хялбар, түргэн шуурхай болсон ба уг системийг ашигласнаар ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаа түргэн шуурхай болж үйлчилгээний чанар сайжирч мөн кадастрын мэргэжилтнүүдийн хөдөлмөрийн бүтээмж дээшилж, ажлын ачаалал буурсан” хэмээн онцлон тэмдэглэсэн байна.

Түүнчлэн хэрэглэгчдэд тусгай зөвшөөрлийн бүртгэлийн талаарх мэдээллийг түгээх, зөвшөөрөл эзэмшигчдийн болон хайгуул, ашиглалт явуулж буй талбайн талаар илүү ил тод болгох боломж нээгдэхээс гадна уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг гадаад болон дотоодын хөрөнгө

оруулагчид дэлхийн аль ч өнцгөөс хаанаас ч кадастрын мэдээллийг цаг алдалгүй авах боломж бүрдэх юм.

Кадастрын цахим бүртгэлийн системд байршсан мэдээлэл нь ОҮИТБС-ын стандарт 3.9-ийн (а)-ийн шаардлагыг хангасан эсэх судалгааг харуулж байна.

Стандарт 3.9 (а)-ийн шаардлага	Кадастрын бүртгэлээр нээлттэй болсон байдал
1. Лиценз эзэмшигчид	1. Лиценз эзэмшигчид
2. Лиценз эзэмшигчдийн мэдээлэл	2. Лиценз эзэмшигчдийн мэдээлэл
3. Лицензийн талбайн солбицол	3. Лицензийн талбайн солбицол
4. Лиценз авахаар хүсэлт гаргасан	4. Лиценз авахаар хүсэлт гаргасан
5. Лиценз олгосон огноо	5. Лиценз олгосон огноо
6. Лицензийн хүчинтэй хугацаа	6. Лицензийн хүчинтэй хугацаа
7. Олборлосон бүтээгдэхүүний тухай	-
Стандартын шаардлагын 85.7 хувийг ил тод болгосон байна.	

Хүснэгт-32

Ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс 2011 оноос эхлэн уулын ажлын тайланг цахим хэлбэрээр авч байна. Энэ тайланд олборлосон бүтээгдэхүүний талаарх мэдээлэл багтсан байна.

Тус газрын хэлтэс, алба, тасгуудийн мэдээллийн (бүртгэлийн) сангуудыг нэгтгэх төсөл хэрэгжиж эхэлсэн байна.

Төслийн талаарх танилцуулга: Монгол Улсын Ашигт малтмалын газар (АМГ) болон ХБНГУ-ын Холбооны Гео шинжлэх ухаан, Байгалийн нөөцийн хүрээлэн (БГР)-тэй хамтран хэрэгжүүлэх “Монгол улсын эрдэс баялгийн эдийн засгийн чадамжийг дээшлүүлэхэд чиглэсэн техникийн хамтын ажиллагаа”-ны төсөл нь гэрээ хийгдэх шатандаа явж байна. Уг төслийг ХБНГУ-ын Засгийн газраас 1.6 сая еврогоор санхүүжүүлж байгаа бөгөөд 2 жилийн хугацаатай хэрэгжүүлнэ.

Төсөл нь Монгол Улсын эрдэс баялгийн салбарын төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудыг мэргэжлийн өндөр түвшинд боловсруулсан мэдээллээр хангахад Ашигт малтмалын газрын чадамжийг дээшлүүлэх, тодорхой ашигт малтмалын хайгуул, олборлолт, боловсруулах болон зах зээлд гаргахад стратегийн болон эдийн засгийн судалгаа хийх, эрдэс баялагийн салбарын хөрөнгө оруулалтийг нэмэгдүүлэх зорилгоор ашигт малтмалын ордуудын үнэлгээ хийх, мөн мэдээллийн нэгдсэн системтэй болох ажлуудыг дэс дараатайгаар хэрэгжүүлэх юм.

3.10.3.2 Цөмийн энергийн газар:

Тус газраас тусгай зөвшөөрлийн бүртгэлийн программыг шинээр хийж байгаа бөгөөд уг программыг ашиглаж эхэлснээр өөрийн вэб хуудсанд тусгай зөвшөөрлийн бүртгэлийн мэдээллийг байршуулна.

Уг мэдээлэлд цацраг идэвхт ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй холбоотой дэлгэрэнгүй мэдээлэл байхаас гадна цацраг идэвхт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл шинээр авах, хугацааг сунгуулах, хэсэгчлэн болон бүхэлд нь буцаах өргөдөл цахимаар хүлээж авах, мөн хайгуулын ажлын тайлан, төлөвлөгөөг цахимаар хүлээн авдаг болох юм.

3.10.3.3 Газрын тос:

Газрын тосны тусгай зөвшөөрөл болон Бүтээгдэхүүн хуваах гэрээг ил тод болгох талаар хуулийн ямар нэгэн заалт байхгүй байна.

3.10.4 ГАЗРЫН ТОС

3.10.4.1 ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ

3.10.4.1.1 Монгол Улсын Газрын тосны тухай хууль, 2014

2014 оны 7 дугаар сард УИХ-аас шинэ Газрын тосны тухай хуулийг тус улсад гадаадын хөрөнгө оруулалтыг татах, 1991 оны Газрын тосны тухай хуулийг өөрчлөх зорилготойгоор баталсан. Тус шинэ хуулиар газрын тосны хайгуул эрхлэгчдэд зарим боломжуудыг өгсөн боловч энэ урьд нь гарын үсэг зурсан гэрээний нөхцөл байдалд нөлөөлөхгүй юм. Ач холбогдол бүхий онцлог чанарууд нь:

- ❖ Хайгуул хийх хугацаа нь 8 жил байх ба тус бүр 2 жилээр 2 удаа сунгаж болно. Үйлдвэрлэл явуулах хугацаа нь 25 жил ба 5 жилээр 2 удаа сунгаж болно.
- ❖ Бүтээгдэхүүн хуваах гэрээнд компаниудын хүсэлтийн дагуу 180 хоногийн дотор Засгийн газар гарын үсэг зурж, баталгаажуулж болно.
- ❖ Монгол Улсын Засгийн газарт төлөх АМНАТ хамгийн багадаа 5% байх ёстой.
- ❖ Компаниуд эхний таван жилд нь гаалийн татвар, НӨАТ-аас чөлөөлөгдөх бөгөөд ОАТ- нь газрын тосны борлуулалтаас тооцогдоно.
- ❖ Хайгуул, үйл ажиллагаа, боловсруулалт ба үйлдвэрлэлийн зардал нь 100% нөхөгдөнө. Жилд олборлосон нийт газрын тосны 40 хүртэл хувийг зардал нөхөхөд зарцуулна
- ❖ Компаний хүсэлтээр тухайн компани нь газрын тос тээвэрлэх зорилгоор дамжуулах хоолой барих зөвшөөрөл авч болно

3.10.4.1.2 Монгол Улсын Газрын Тосны тухай хууль, 2005

2005 оны 7 дугаар сард УИХ-аас газрын тосны үйл ажиллагаатай холбоотой ангиллыг тодорхойлох зорилгоор Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль баталсан.

Газрын тосны бүтээгдэхүүний (ГТБ) импорт, бүтээгдэхүүн үйлдвэрлэл, газрын тосны худалдаа эрхлэх үйл ажиллагаануудыг уг хуулийн дагуу тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлдэг бол газрын тосны тээвэр болон хадгалах үйл ажиллагаа нь уг хуулийн хүрээнд явагдах боловч тусгай зөвшөөрөл авах шаардлагагүй.

2013 оны 12 дугаар сард уг хууль одоог хүртэл тусгай зөвшөөрөлгүйгээр үйл ажиллагаа явуулдаг байсан газрын тосны бүтээгдэхүүний жижиглэнгийн худалдааг уг тусгай зөвшөөрөл хийхээр болгож нэмэлт өөрчлөлт оруулсан.

3.10.4.1.3 Уул уурхайн сайдын 171 дүгээр тоот тушаалаар баталсан Газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөлтэй холбогдсон нарийвчилсан журам

Уул Уурхайн Сайдын 2013 оны 8 дугаар сарын 171 дүгээр тушаалаар баталсан ГТБ-ний тусгай зөвшөөрөлтэй холбогдсон журманд ГТБ-ийг импортлох, жижиглэнгийн худалдаа мөн бөөний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрлүүдийг компаниудад төрөл тус бүр дээр тусад нь олгоно гэж заасан байна.

3.10.4.2 ЕРӨНХИЙ

Уул уурхайн яамнаас Газрын тосны газартай БХГ хийсэн эсвэл тухайн нөөц бүхий ордод БХГ-гүйгээр тендэрт ялсан Монголын Компаниудад хайгуулын тусгай зөвшөөрөл олгохыг зөвшөөрнө. Тусгай зөвшөөрлийн үргэлжлэх хугацаа хамгийн ихдээ 8 жил байх ба 2 удаа тус бүр 2 жил хүртэл хугацаатайгаар сунгаж болно. Уламжлалт бус газрын тосны хайгуулын тусгай зөвшөөрөлийн үргэлжлэх хугацаа хамгийн ихдээ 10 жил байх ба цаашид нэг удаа хамгийн ихдээ 5 хүртэл жилээр сунгалт хийлгэж болно.

Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч олборлолт эхлүүлэхийг хүсч байгаа бол, хайгуулын хугацаа дуусахаас 90 хоногийн өмнө нөөцийн тооцооны тайланг Уул уурхайн яаманд танилцуулах ёстой. Яам нь Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн газрын тосны орд ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөөг батална. Газрын тосны ашиглалтын тусгай зөвшөөрлийн хугацаа 25 хүртэл жил байх бөгөөд тав хүртэл жилээр хоёр удаа сунгаж болно. Уламжлалт бус газрын тосны хайгуулын хугацаа 10-аас дээш жил байж болохгүй бөгөөд хамгийн ихдээ 5 хүртэл жилээр нэг удаа сунгаж болно.

4. НЭГТГЭЛИЙН ХАМРАХ ХҮРЭЭ БА АРГА АРГАЧЛАЛ

Тайлангийн энэхүү хэсэгт бид нэгтгэл тайланд хамрагдсан аж ахуйн нэгжүүд, Засгийн газрын төлбөрийн урсгал болон бусад хамааралтай асуудлуудыг орууллаа. Мөн аж ахуйн нэгжүүд болон төлбөрийн урсгалыг ямар үндэслэлээр сонгосон, нэгтгэлд ашигласан материаллаг байдлын босго болон ААН-үүдээс гаргаж өгсөн мэдээлэлдээ баталгаажуулалт хийсэн талаар тайлбарлана.

4.1 ТАНИЛЦУУЛГА

“Харт Нойрс” Лтд ба “Улаанбаатар Аудит Корпораци” ХХК-ийн (“Зөвлөхүүд”) консерциум нь Гэрээт ажлын даалгаварт тусгагдсан ажил үүргүүдийг хийх үүрэг хүлээсэн.

Энэхүү тайланд өөрөөр заагаагүй бол нэгтгэл нь бэлэн мөнгө болон бэлэн бусаар хийгдсэн төлбөрүүдийг нягтлан бодох бүртгэлийн мөнгөн суурийн дагуу хийгдсэн.

Гэрээт ажлыг гүйцэтгэхдээ бид оролцогч талуудаас ирүүлсэн тайлангийн маягтууд, мэдээ мэдээлэл болон тайлбарууд дээр тулгуурласан болно. Эдгээр мэдээллийн үнэн зөв болон бүрэн гүйцэд байдалд аливаа нэгэн нотолгоо хийгдээгүй болно.

Аливаа материаллаг дүн бүхий орлого, төлбөр тайлангийн маягтад бүртгэгдэлгүй орхигдсон тохиолдолд бидний гүйцэтгэсэн ажлаар илрүүлэхэд хангалтгүй юм. Тиймээс аливаа орхигдсон материаллаг дүн бүхий орлого эсвэл төлбөрүүд нь манай тайланд хамрагдахгүй болно.

Энэхүү тайланг Монгол, Англи хэл дээр бэлтгэв. Монгол болон Англи тайлангийн хооронд зөрүүтэй эсвэл зөрчилтэй зүйл гарсан тохиолдолд Англи хувийг баримтлана.

Энэхүү тайланд 2014 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийг хүртэлх хугацаанд хүлээн авсан мэдээллийг нэгтгэн оруулав. Энэ өдрөөс хойш хүлээн авсан мэдээллийг энэхүү тайланд оруулаагүй болно.

4.2 НЭГТГЭЛ ТАЙЛАНГИЙН ХАМРАХ ХҮРЭЭ

4.2.1 ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧЛАГА (ОУИТБС)

Монголын ОУИТБС-ын Үндэсний зөвлөл нь 2010 оны 06 дугаар сарын 24 хуралдаанаараа олборлох үйлдвэрлэлийн компаниудын зүгээс төрийн байгууллагуудад нийт 10.0 мянган төгрөгөөс дээш хэмжээний татвар, төлбөрийг (татвар, төлбөр, хураамж, бусад орлогын нэр төрөл тус бүр дээр) төлсөн л бол тайлагнаж байх ёстой хэмээн тогтоожээ. Мөн уг шийдвэрээр хамруулбал зохих төлбөрийн асуудлыг тодорхойлж Үндэсний статистикийн хорооны дарга, Сангийн сайдын хамтарсан тушаалаар баталсан байна. 2012 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн МОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн хуралдаанаар гишүүд нэгтгэлд хамрагдах компанийг нийт 40.0 сая төгрөгөөс дээш хэмжээний төлбөр төлсөн бол хамруулахаар тогтоосон байна.

2013 оны 12 сарын 23-ны өдрийн МОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн хуралдаанаар гишүүд нэгтгэлд хамрагдах нийт компанийн тоог заасан боловч Материаллаг байдлын босго үнийг тогтоогоогүй байна. 2013 оны Нэгтгэл тайланд 250 компанийг сонгосон байна.

4.2.2 ТАЙЛАНГИЙН МАЯГТ


2013 оны нэгтгэл тайланд ашиглах Тайлангийн маягыг Үндэсний статистикийн хорооны дарга, Сангийн сайдын 2014 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 1/3/1 тоот хамтарсан тушаалаар баталсан байна. Уг маягтын төлбөрийн урсгал нь Үндэсний зөвлөлийн 2010 оны 06 дугаар сарын 24-ны өдрийн хуралдааны шийдвэрээр тогтоосон төлбөрийн урсгалаас гадна өөр бусад төлбөрийг багтаасан болно.

4.2.3 ТӨЛБӨРИЙН УРСГАЛ

Засгийн газарт Олборлох салбараас газрын тос, байгалийн хийнээс төлж буй орлого болон материаллаг төлбөр мөн, ажлын хэсгээс хүлээн зөвшөөрсөн төлбөрийн маягт зэрэг нь дараах байдалтай байна.

Төлбөрийн урсгалын жагсаалт

Засгийн Газрын төлбөр хүлээн авагч агентлагуудыг дараах диаграммаар харуулж байна:



4.3 ТАЙЛАГНАГЧ БАЙГУУЛЛАГУУД

4.3.1 ЗАСГИЙН ГАЗАР

2013 оны нэгтгэлд оролцсон Засгийн газрын байгууллагууд:

4.3.1.1 Засгийн Газрын Байгууллагууд

- Сангийн яам
- Татварын ерөнхий газар
- Байгаль орчин, ногоон хөгжлийн яам
- Ашигт малтмалын газар
- Цөмийн энергийн газар
- Газрын тосны газар
- Гаалийн ерөнхий газар
- Хөдөлмөрийн яамны Санхүү, сангийн бодлого төлөвлөлтийн газар
- Нийгмийн даатгалын ерөнхий газар
- Төрийн өмчийн хороо

4.3.1.2 Орон Нутгийн Засаг Захиргаа

- (Аймаг, Нийслэл, Сум, Дүүрэг)-ийн Засаг Захиргаа

4.3.2 КОМПАНИУД

2013 онд МОҮИТБС-ын Ажлын албанд 1,198 компани тайлангаа өгсөн. Тус ажлын алба нь нэгтгэлийн зорилгоор аудитын консерциумд 240 компани (10 компани тайлангаа өгөөгүй)-ийн бэлтгэсэн тайланг ирүүлсэн.

Сангийн Яам нь ОҮИТБС 2013 оны нэгтгэл ажилд зориулж 1,617 оролцогч компаниудаас төлсөн Засгийн газрын орлогыг ОҮИТБС-ын Ажлын хэсгийн баталсан маягтын дагуу нэгтгэж гаргасан.

ОҮИТБС-ын Стандартад (Шаардлага 18(б)ii)-д заасны дагуу ОҮИТБС-ын нэгтгэл ажилд олборлох үйлдвэрлэлийн салбарт хамрагдах бүх лицензтэй эсвэл бүртгэлтэй компаниудыг хамруулах бөгөөд ОҮИТБС тайлагналын процесст оролцсон компаниудыг тэмдэглэх ёстой.

Засгийн газар нь өөр өөр жагсаалтыг тухайн зорилгодоо нийцүүлэн бэлтгэдэг. Тухайлбал АМГ лиценз эзэмшиж буй компаниудын жагсаалтыг бэлтгэдэг бол Сангийн яам татварын зорилгоор компаниудын жагсаалтыг тусад нь бэлтгэдэг. Эдгээр жагсаалтуудыг өөр өөр зорилгоор бэлтгэсэн учир хоорондоо адилгүй. СЯ-ны жагсаалтыг нэгтгэл тайланд хамрагдсан компаниудыг тодорхойлох зорилгоор ашигласан. Уг хоёр жагсаалтыг хоёуланг уг тайланд хамруулсан болно.

Хавсралт-2-т нэгтгэл тайланд хамрагдсан компаниудын жагсаалтыг харуулав.

Нэгтгэлд тайланд тайлагнагч 250 компанийн эрхэлж буй үйл ажиллагааны чиглэлийг доорх диаграмд харууллаа.

Компаниудын эрхэлж буй үйл ажиллаганы чиглэл




График-18

4.4 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН БОСГО

Үндэсний зөвлөл нь компаниудын тайлагнавал зохих материаллаг урсгалыг 2010 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн хуралдааны шийдвэрээр материаллаг төлбөрийн тайлагнах доод хэмжээг 10.0 мянган төгрөгөөс дээш хэмжээний татвар, төлбөр, хураамж болон бусад төлбөрийг төлсөн л бол тайлагнах ёстой” гэж тогтоосон, мөн 2013 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаар 250 компанийг 2013 оны нэгтгэл тайланд хамруулахаар сонгосон байна. 2013 оны нэгтгэлд ашиглах тайлангийн маягтыг 2014 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн Үндэсний Зөвлөлийн хуралдаанаар хүлээн зөвшөөрсөн. Хэдийгээр энэхүү ажлыг гүйцэтгэх ажлын даалгаварт заагаагүй ч уг тайлангийн маягтын төлбөрийн урсгал нь 2010 оны 06 дугаар сарын 24-ны өдрийн хуралдаанаар баталсан төлбөрийн урсгалаас гадна өөр төлбөрүүдийг багтаасан байна.

МОУИТБСАА-наас бидэнд олборлох салбарын компаниудын зүгээс Засгийн Газарт орох орлогын болон ААН-үүдийн жагсаалтыг өгсөн.

Бид компаниудын сонголтын талаар энэхүү тайлангийн 2.3.1 дүгээр хэсэгт дурьдаж, 8 дугаар бүлэгт зөвлөмж болгож оруулав.

4.5 МАТЕРИАЛЛАГ ЗӨРҮҮ

Компаниудын хийсэн төлбөр болон төрийн байгууллагуудын хүлээн авсан орлогын хоорондын зөрүү нь материаллаг байдлын босгоноос давсан тохиолдолд бид материаллаг хэмээн үзэж байна. Энэхүү алдааны материаллаг байдлыг татвар нэг бүрээр нь дүн шинжилгээ хийхэд ашиглагдах хамгийн бага босго бөгөөд үүнийг нэгтгэлийн үйл ажиллагааны хүрээнд тохируулга хийхээр ашигласан. Өөрөөр

хэлбэл зөвхөн 100.0 мянган төгрөгөөс дээш хэмжээний зөрүү гарах тохиолдолд шалгаж, тохируулгыг хийсэн.

4.6 НЭГТГЭЛИЙН ХАНДЛАГА БА АРГА АРГАЧЛАЛ

4.6.1 ЕРӨНХИЙ ХАНДЛАГА

Бидний энэхүү нэгтгэлийн ажилд хэрэглэсэн арга хандлагын талаар товч дурьдвал:

- Монголын ОУИБСАА-тай нягт харилцан ярилцаж, Монголын ОУИБС-ын заавар, журмуудтай танилцан, бүрэн гүйцэд ойлголт авч, холбогдох бичиг баримтуудыг үзэх, ялангуяа, тайлагнах маягтуудад зориулан боловсруулсан нягтлан бодох бүртгэлийн зарчмууд, аргачлал хандлагууд зэрэгтэй танилцсан.
- МОУИТБС-ын ажлын албанаас анхны тайлангуудыг авсан.
- Компани болон Засгийн газрын дүнг харьцуулж, анхны зөрүүг тооцож гаргасан.
- Хамрагдсан компаниудын маягтуудын мэдээллийг нэгтгэн хүснэгтлэх, эдгээр маягтуудад буруу зөрүү (шаардлагын дагуу мянгачлагдаагүй дүн) бөглөгдсөн зүйлсийг хасан (хувь хүний орлогын албан татвар гэх мэт) зохих тохируулгыг хийсэн.
- Тайлагнагдсан дүнг аль болох зөрүүгүй шийдвэрлэх зорилгын үүднээс нэгтгэлийн ажлыг гүйцэтгэсэн.
- Нэгтгэлийн явцад хийсэн тохируулгыг баримтжуулж, тайлбарласан.
- Үүссэн зөрүүг шийдвэрлэх зорилгоор ЗГ болон компаниудтай эргэх холбогдож, мэдээлэл авсан.
- Шийдвэрлэгдээгүй үлдсэн зөрүүгийн шалтгааныг тайлбарлаж, зохих зөвлөмжүүдийг өгсөн.

4.6.2 БАТАЛГААЖУУЛАЛТ

Монгол улсын хууль журамд компаниуд болон Засгийн Газрын байгууллагууд санхүүгийн тайландаа аудит хийлгэж, баталгаажуулах үүрэгтэй талаар доорх байдлаар заасан байдаг. Үүнд:

- Олборлох компаниуд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /НББОУС/-ын дагуу НББ-ын зарчим ашиглан, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/-д нийцүүлэн санхүүгийн тайлан тэнцэл гаргах үүрэгтэй⁹.
- Засгийн Газрын байгууллагууд нь Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/-д нийцүүлэн санхүүгийн тайлангаа гаргах үүрэгтэй.¹⁰
- 50 сая төгрөгөөс дээш хэмжээний нийт хөрөнгө бүхий олборлох үйл ажиллагаа эрхэлж буй компаниуд санхүүгийн тайлангаа аудитын байгууллага томилон баталгаажуулах шаардлагатай. Тус аудитын байгууллага нь аудитын ажлыг Аудитын олон улсын стандартад дагуу хийж гүйцэтгэнэ¹¹
- Төр, засгийн байгууллага, болон Монгол Улсын Засгийн Газар хувь эзэмшдэг ААН-үүд жил бүр санхүүгийн тайлангаа Үндэсний Аудитын Газраар аудитлуулж баталгаажуулах үүрэгтэй. Аудитын ажлыг хийж гүйцэтгэх болон тайлагнахдаа олон улсын стандартын дагуу хийж гүйцэтгэнэ.

Бид дор дурдсан үйл явцыг ОУИТБС-ын тайлангийн зорилгоор даган мөрдсөн.

4.6.2.1 Удирдлагын хариуцлагын захидал

Бид компаниудын удирдлагад ОУИТБС-ын маягтын дагуу гаргаж өгсөн тайлангийн хариуцлагатай байдлыг “Удирдлагын хариуцлагын захидал”-аар баталгаажуулж хүсэлт гаргасан. Компаниудаас хүлээн авсан хариунуудын дэлгэрэнгүйг **Хавсралт-9-д** тусган харууллаа.

Компаниудаас гаргуулсан хариуцлагын мэдэгдлийн бас нэг хэлбэр нь компаниудын тайлагнасан дүн нь Олон улсын стандартын дагуу аудитлагдсан санхүүгийн тайлантай нь уялдаж буй эсэхийг нягтлах явдал байсан. Тиймээс бид компаниудаас 2013 оны санхүүгийн аудитын тайлангийн хуулбарыг гаргаж өгөхийг хүссэн.

45 компани аудитын тайлангаа өгөөгүй. Харин аудитын тайлангаа гаргаж өгсөн компаниудаас 10 компанийн ОУИТБС-ын тайлан аудитаар баталгаажсан байна. (**Дэлгэрэнгүйг Хавсралт-8-аас харна уу**).

4.6.2.2 Засгийн газрын мэдээллийн баталгаажуулалт

Төрийн байгууллагууд жил бүр Үндэсний аудитын газраар аудит хийлгэх үүрэгтэй байдаг. Орон нутгийн төрийн байгууллагууд жил бүр аудитаа Үндэсний аудитын газар эсвэл уг газраас томилогдсон мэргэжлийн аудитын байгууллагаар хийлгэдэг.

Засгийн газрын хүлээн авсан төлбөрийн тайланд Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга гарын үсэг зурдаг. Гэвч ЗГ-ын тайланд ямар нэг хариуцлагын мэдэгдэл юм уу баталгаажуулалт ОУИТБС-ын Хараат бус нэгтгэгчид гаргаж өгөөгүй бөгөөд ЗГ-ын уг гарын үсэг юуг төлөөлж буй нь тодорхойгүй


⁹ НББОУС болон СТОУС-ын талаар нэмэлт мэдээллийг дараах холбоосоор орж харна уу <http://www.ifrs.org/IFRSs/Pages/IAS.aspx>

¹⁰ УСНББОУС-н зөвлөлийн талаар нэмэлт мэдээллийг дараах холбоосоор орж харна уу <http://www.ifac.org/public-sector>

¹¹ АОУС нь НББОУ-н Хорооноос Аудитын болон Баталгаажуулалтын Олон Улсын Зөвлөлөөр дамжуулан гаргасан: <http://www.ifac.org/auditing-assurance>

байна. Энэ нь нэгтгэлийн зорилгоор ЗГ-ын дүнг шалгах ажлын нэг хэсэг учраас сайжруулах шаардлагатай.

4.7 ЗӨРҮҮГ ТОДОРХОЙЛОХ АЖЛЫН ЧИГЛЭЛ, ХООРОНДЫН УЯЛДАА




4.8 АРГАЧЛАЛ

4.8.1 МЭДЭЭЛЛИЙН ТҮҮВЭР

ОУИТБС-ын Ажлын алба нь ЗГ-ын байгууллагууд, уул уурхайн болон газрын тосны үйлдвэрлэл, хайгуулын үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжүүдээс мэдээлэл цуглуулан авахдаа Үндэсний статистикийн хорооны дарга, Сангийн сайдын 2013 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 1/3/1 тоот хамтарсан тушаалаар батлагдсан “Маягт ОУИТБС”-1-7 гэсэн маягтыг ашигладаг.

Тайлангийн маягтын бүтцийг дараах байдлаар харуулж байна.



4.8.2 МЭДЭЭЛЛИЙН ХАРЬЦУУЛАЛТ

Уул уурхайн компани тус бүрийн Маягт №1, 2, 3 дээрх үзүүлэлт бүрээр тайлагнасан төрийн болон орон нутгийн төсөвт төлсөн татвар, төлбөрүүдийг Microsoft Excel-ийн хүснэгт ашиглан Засгийн Газрын байгууллагуудын бэлтгэсэн тайлантай (Монголын ОУИТБС-ын ажлын албанаас гаргасан Маягт № 6) компани тус бүрээр тулгасан болно.

Ийнхүү тулгах явцад үүссэн бүх зөрүүг тогтоосон шалгуурын дагуу ач холбогдолтой болон ач холбогдолгүй гэж ангилан хүснэгтэлсэн.

МОУИТБС-ын Маягт №1,2,3 дээр нэгтгэсэн дүнгүүдийг Засгийн газрын байгууллагууд болон ТЕГ-аас ОУИТБС-ын Маягт №6-ын дагуу ирүүлсэн мэдээллүүдтэй тулгасан.

4.8.3 МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ

Ач холбогдолтой зөрүү бүрийн хувьд дараах зүйлсийг тодорхойлно.

- ❖ Холбогдох Засгийн газрын байгууллагууд ба татварын албадаас (Маягт №6 дээрх дүнг харуулах үүднээс хүлээн авсан дүн буюу орлого хийгдсэн он, сар, өдөр, дүнгүүдийн дэлгэрэнгүй) дэлгэрэнгүй мэдээлэл авсан. Энэхүү дэлгэрэнгүйг уул уурхайн компаниудын төлсөн төлбөрүүдийн дэлгэрэнгүй мэдээлэлтэй тулган шалгахад ашигласнаар зөрүүнүүдийн боломжит тайлбаруудыг олж авсан.
- ❖ Уул уурхайн компаниудын бэлтгэсэн Маягт №1,2,3 нь тус компанийнхаа аудиторoor хянагдсан эсэхийг мэдсэний үндсэн дээр тухайн компанийн хувьд үүссэн зөрүүнүүдийн тоо хэмжээ, төрөл (үзүүлэлт) болон бусад холбогдох хүчин зүйлсийн талаар бид өөрсдийн мэргэжлийн үнэлэмж шүүмжлэлийг ашиглан дараахи байдлаар шийдвэр гаргасан. Үүнд:
 - Монголын ОУИТБС-ын Маягт №1 дээрх өгөгдлүүдийн үнэлгээний байдлыг хянаж үзсэн ба зөрүү үүсгэж байгаа зүйлсийг тодорхойлсон. Үүний тулд гүйцэтгэсэн горимууд нь үзүүлэлт бүрийн шинж чанараас хамаарч болно, түүнчлэн өөр бусад төрлийн эх сурвалж болох баримт бичгүүдийг ашиглах, дүн шинжилгээний хяналт, тоонуудыг батлан нотлохын тулд хийгдэх хараат бус тулган баталгаажуулалт зэргээс бүрдсэн. Хандлагын хувьд зөвхөн тодорхойлогдсон ач холбогдолтой зөрүүнүүдийн хувьд ч бус зарим тохиолдолд компанийн тайлагнасан бүхий л болон хэсэг өгөгдлүүдийг ч хамран хийгдэх шаардлага гарч байсан.
 - Монголын ОУИТБС-ын Маягт №1,2,3-аар ирүүлсэн тоонуудын тооцооллыг харж шалгахын тулд холбогдох компаниудын зүгээс тэдний тайланд тусгагдсан дүнгийн

дэлгэрэнгүй задаргааг (төлбөр хийгдсэн он, сар, өдөр болон дүнгүүд) авах хүсэлт гаргасан.

- Засгийн газрын байгууллага болон компаниудаас ирүүлсэн дэлгэрэнгүй мэдээлэл нь зөрүүтэйн улмаас зөрүүг тохируулах боломжгүй болсон тухайгаа компани болон санхүүгийн урсгал тус бүрээр шалтгааныг тайлбарласан.
- ❖ Хэрвээ дээрх үйл явцын хүрээнд зөрүүнүүд нь шийдвэрлэгдэх боломжгүй гэж тооцогдвол холбогдох Засгийн газрын байгууллагууд болон тухайн компанийн хүмүүстэй хамтарсан уулзалтыг зохион байгуулж, Ажлын хэсгээс дэмжлэг болон нэмэлт удирдамж аван тодорхой зөрүүг бууруулах арга хэмжээг авч ажилласан.
- ❖ Тулган шалгах явцад тодорхойлогдсон зөрүүнүүдийг ангилж, зөрүүгийн шалтгааныг (эсвэл шаардлагатай бол шийдэгдээгүй байдлаар нь үлдээх) тайлбарласан. Маягтуудыг бэлтгэх явцад голлон үүсдэг асуудлууд болон ОУИТБСАА-ны ажлын явцыг тодорхойлоход чиглэгдсэн зөвлөмжүүдийг өгсөн.

Гарсан зөрүүнүүдийг доорх байдлаар ангилан оруулсан.

- Эерэг зөрүү: Засгийн газрын байгууллагын хүлээн авсан хэмээн тайлагнасан нийт дүн нь олборлох үйлдвэрлэлийн компанийн зүгээс төлсөн хэмээн тайлагнасан дүнгээс илүү гарсан;
- Сөрөг зөрүү: Засгийн газрын байгууллагын хүлээн авсан хэмээн тайлагнасан нийт дүн нь олборлох үйлдвэрлэлийн компанийн зүгээс төлсөн хэмээн тайлагнасан дүнгээс дутсан;
- Цэвэр зөрүү: Эерэг болон сөрөг зөрүүний нийлбэр.

4.9 ОУИТБС-ЫН ТАЛУУДЫН ОРОЛЦООНЫ СХЕМ



4.10 БУСАД ХИЙГДСЭН АЖЛУУД

Ажлын даалгаварт заасны дагуу ОУИТБС-ын 2013 оны тайланд хэд хэдэн судалгаа хийхийг шаардсан.

Үүнд:

1. Бүх хандив, дэмжлэгийн судалгааг холбогдох компани, Засгийн газрын байгууллага тус бүрээр, Сангийн сайдын 2010 оны 45 дугаар тушаалын биелэлтийн судалгааг гаргасан. (Тайлангийн 6.1 хэсэг)
2. Тайлангийн нэгтгэлд оролцож буй компаниудаас тэдгээр компаниудын 2013 оны санхүүгийн нэгдсэн тайлан ямар аудиторроор баталгаажсан, санхүүгийн тайлагналын олон улсын стандарт мөрдөгдсөн эсэх судалгааг компани бүрээр гаргасан. (Тайлангийн 6.2 хэсэг)
3. Тайлангийн нэгтгэлд орж буй компаниудын байгаль орчны нөхөн сэргээлтийн тайлан болон жилийн уулын ажлын төлөвлөгөөний биелэлтийн судалгааг гаргасан (Тайлангийн 6.4, 6.5 хэсэг)
4. Тайлангийн нэгтгэлд орж буй компаниудын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн талаарх судалгааг гаргасан. (Тайлангийн 6.7 хэсэг)
5. Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар заалтын дагуу олборлох үйлдвэрлэлийн компаниуд, орон нутгийн захиргаатай байгуулсан гэрээний судалгааг гаргасан. (Тайлангийн 6.9 хэсэг)
6. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой, орон нутгийн өмчийн оролцоотой компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийн судалгаа гаргасан. (Тайлангийн 6.10 хэсэг)

Энэхүү тайлан нь 2013 оны ОУИТБС-ын стандартад “Олборлох үйлдвэрүүдийн нөхцөл байдлын талаарх мэдээллийг оруулна” гэсэн шаардлагын дагуу хийгдсэн бөгөөд 3 дугаар бүлэгт уг шаардлагад нийцэх мэдээллүүдийг оруулсан.

5. САНХҮҮГИЙН УРСГАЛЫН НЭГТГЭЛ

5.1 НЭГТГЭЛИЙН ХУРААНГУЙ

5.1.1 ТАНИЛЦУУЛГА

Энэ хэсэгт бид Засгийн газар болон Компаниудын тайлагнасан дүнг нэгтгэлд хамрагдсан төлбөрийн урсгал бүрээр нарийвчлан харууллаа. Үүнд:

- I. Анхны тайлан
- II. Ажлын хэсэгт хийсэн анхны танилцуулга
- III. Нэгтгэлийн дараах эцсийн үр дүн

Дээрх 3 шатанд тайлангийн төлбөрийн урсгал дараах байдалтай байна:

(сая төгрөгөөр)

	Засгийн газар	Компани	Зөрүү	%
Оролцогц ААН-үүдийн анхны тайлагнасан дүн	1,599,629	1,565,086	34,544	1
Тохируулга	176,653	213,360	(36,707)	-
2014 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн Ажлын хэсгийн хуралд анхны нэгтгэлийг танилцуулсан	1,776,282	1,778,446	(2,164)	0.10%
Тохируулга	(200,268)	(202,395)	2,127	-
Нэгтгэл тайланд тохируулагдсан дүн	1,576,014	1,576,051	(37)	0.00%

Хүснэгт-33

Тохируулгын үр дүн ба шийдэгдээгүй зөрүүний цаашдын дүн шинжилгээний талаар энэ хэсэгт орох болно. Шийдэгдээгүй үлдсэн зөрүү 37 сая төгрөг бөгөөд энэ нь материаллаг бус дүн юм.

5.1.2 АНХЛАН ТАЙЛАГНАСАН САНХҮҮГИЙН НИЙТ УРСГАЛ

(сая төгрөгөөр)

№	Үзүүлэлт	Анхны нэгтгэл		
		Засгийн газар	Компани	Зөрүү
1	Улсын төсөвт төлсөн албан татвар, төлбөр, хураамж, ногдол ашиг	1,473,336	1,428,787	44,549
1	Татвар	518,064	548,698	(30,634)
1	Төлбөр	666,425	623,566	42,859
1	Үйлчилгээний хураамж	30,571	19,395	11,176
1	Төрийн өмчийн ногдол ашиг	70,429	70,434	(6)
2	Засгийн газрын хүлээн авсан урьдчилгаа төлбөрүүд	187,666	128,705	58,961
2	Бусад	182	37,990	(37,808)
2	Орон нутгийн төсөвт төлсөн албан татвар, төлбөр, хураамж, ногдол ашиг	114,609	113,781	828

№	Үзүүлэлт	Анхны нэгтгэл		
		Засгийн газар	Компани	Зөрүү
2	Орон нутгийн төсөвт төлсөн албан татвар	14,733	14,324	409
2	Төлбөр	65,696	64,501	1,195
2	Орон нутгийн төрийн өмчийн ногдол ашиг	7,815	18	7,797
2	Бусад	26,365	34,938	(8,573)
3	Төрийн байгууллагад өгсөн хандив, дэмжлэг	11,684	22,517	(10,833)
	Дүн	1,599,629	1,565,086	34,544

Хүснэгт 34

Бид нэгтгэлийн ажлаар эхний тайлангийн гол зөрүүнүүдийг олж илрүүлсэн.

Анхны нэгтгэлийн зөрүү дараах шалтгааны улмаас үүссэн байна. Үүнд:

- Засгийн газар анхны тайландаа орон нутгийн төсөвт төлсөн төлбөр, торгууль, төсвийн байгууллагад өгсөн хандив, дэмжлэгийн дүнг бүрэн хамруулж, нэгтгэж чадаагүйгүйгээс анхны зөрүү үүссэн.
- Засгийн газар нь 2013 онд Оюутолгой ХХК-иас нийт 40,597 сая төгрөг хүлээн авсан гэж тайлагнасан боловч энэ нь тус компаниас 2013 онд мөнгөөр хүлээн авсан санхүүгийн урсгал биш байсан. Учир нь Оюутолгой ХХК нь 2013 онд ногдуулсан 40,597 сая төгрөгийн татварыг 2010 онд төлсөн 50 сая ам.долларын урьдчилгаа төлбөрөөс суутган тооцуулсан ба уг төлбөрийг МОУИТБС-ын 2010 оны нэгтгэл тайланд “Засгийн газрын хүлээн авсан урьдчилгаа төлбөр” гэсэн ангилалд оруулан нэгтгэж байсан дүн юм. Иймд Засгийн газар нь мөнгөөр хүлээн аваагүй татварыг тайлагнасан нь зөрүү үүсэхэд нөлөөлсөн байна. Оюутолгой ХХК-ийн суутгуулсан татварын дүнг задлан харуулбал дараах байдалтай байна. Үүнд:
 - ААНОАТ-т 3,300 сая төгрөг
 - Ашигт малтмалын нөөц ашигласны нэмэлт төлбөрт 21,154 сая төгрөг
 - НӨАТ-т 16,143 сая төгрөг
- Компаниуд ихэнхдээ гаальд төлсөн НӨАТ, гаалийн татвар, гаалийн хураамжийг бөөн дүнгээр нь гаалийн албан татварт тайлагнаснаар зөрүү үүссэн.
- Нэгтгэл тайланд хамрагдсан 250 компаниас 10 компани ОУИТБС-ын Ажлын албанд тайлангаа гаргаж өгөөгүйгээс 71,953 сая төгрөгийн зөрүү үүссэн.
- Нэр бүхий 94 компани анхны тайландаа ОУИТБС-ын маягтын “В” хэсгийн “Сайн дурын мэдээлэл”-д тусгагдах 108,418 сая төгрөгийн татвар, төлбөр, хураамж, хандив, дэмжлэгийн дүнг тайлагнаснаас зөрүү үүссэн.

- Компаниуд нь ОУИТБС-ын тайлангаа төлөлтөөр нь бус ногдуулалтаар нь бэлтгэж анхны зөрүү үүсгэсээр байна.

5.1.3 АЖЛЫН ХЭСГИЙН ХУРАЛДААНД ТАНИЛЦУУЛСАН САНХҮҮГИЙН НИЙТ УРСГАЛ

Бид Монголын ОУИТБС-ын наймдугаар буюу 2013 оны нэгтгэл тайлангийн ажлыг 2014 оны 07 дугаар сарын 23-наас эхлэн гүйцэтгэж эхэлсэн ба 2014 оны 10 дугаар сарын 10-ны өдөр ажлын хэсгийн анхны хуралдаанд шийдвэрлэгдээгүй зөрүүг 2.2 тэрбум төгрөгөөр танилцуулсан.

(сая төгрөгөөр)

Үзүүлэлт	Анхны нэгтгэл			Тохируулга			Тохируулгын дараа		
	ЗГ	Компани	Зөрүү	ЗГ	Компани	Зөрүү	ЗГ	Компани	Зөрүү
Улсын төсөвт төлсөн албан татвар, төлбөр, хураамж, ногдол ашиг	1,473,336	1,428,787	44,549	184,984	226,383	(41,399)	1,658,320	1,655,170	3,150
Татвар	518,064	548,698	(30,634)	183,597	215,608	(32,011)	701,661	764,306	(62,645)
Төлбөр	666,425	623,566	42,859	918	46,048	(45,130)	667,342	669,613	(2,271)
Үйлчилгээний хураамж	30,571	19,395	11,176	(700)	655	(1,354)	29,871	20,049	9,822
Төрийн өмчийн ногдол ашиг	70,429	70,434	(6)	-	(6)	6	70,429	70,429	-
Засгийн газрын хүлээн авсан урьдчилгаа төлбөрүүд	187,666	128,705	58,961	-	(111)	111	187,666	128,594	59,072
Бусад	182	37,990	(37,808)	1,168	(35,811)	36,979	1,350	2,179	(829)
Орон нутгийн төсөвт төлсөн албан татвар, төлбөр, хураамж, ногдол ашиг	114,609	113,781	828	(30,472)	(25,093)	(5,378)	84,137	88,688	(4,551)
Орон нутгийн төсөвт төлсөн албан татвар	14,733	14,324	409	(217)	218	(434)	14,516	14,542	(26)
Төлбөр	65,696	64,501	1,195	(7,510)	(1,973)	(5,537)	58,186	62,529	(4,343)
Орон нутгийн төрийн өмчийн ногдол ашиг	7,815	18	7,797	-	7,799	(7,799)	7,815	7,817	(2)
Бусад	26,365	34,938	(8,573)	(22,745)	(31,138)	8,393	3,619	3,800	(181)
Төрийн байгууллагад өгсөн хандив, дэмжлэг	11,684	22,517	(10,833)	22,141	12,072	10,070	33,826	34,589	(763)
Нийт	1,599,629	1,565,086	34,544	176,653	213,361	(36,707)	1,776,282	1,778,446	(2,164)

Хүснэгт-35

5.1.4 НЭГТГЭЛИЙН ДАРААХ САНХҮҮГИЙН НИЙТ УРСГАЛ

Нэгтгэл ажлын явцад материаллаг зөрүүг оролцогч талуудаас ирүүлсэн мэдээлэлд үндэслэн 37 сая төгрөг болтол бууруулсныг доорх хүснэгтээр харууллаа.

(сая төгрөгөөр)

Д/д	Үзүүлэлт	Анхны нэгтгэл		
		Засгийн газар	Компани	Зөрүү
1	Улсын төсөвт төлсөн албан татвар, төлбөр, хураамж, ногдол ашиг	1,452,544	1,452,392	153
1.1	Татвар	492,923	492,957	(33)
1.2	Төлбөр	670,695	670,497	197
1.3	Үйлчилгээний хураамж	29,278	29,278	1
1.4	Төрийн өмчийн ногдол ашиг	70,429	70,429	-
1.5	Засгийн газрын хүлээн авсан урьдчилгаа төлбөрүүд	187,666	187,666	-
1.6	Бусад	1,553	1,565	(12)
2	Орон нутгийн төсөвт төлсөн албан татвар,	84,273	84,389	(116)

Д/д	Үзүүлэлт	Анхны нэгтгэл		
		Засгийн газар	Компани	Зөрүү
	төлбөр, хураамж, ногдол ашиг			
2.1	Орон нутгийн төсөвт төлсөн албан татвар	14,556	14,568	(12)
2.2	Төлбөр	58,103	58,151	(48)
2.3	Орон нутгийн төрийн өмчийн ногдол ашиг	7,817	7,817	-
2.4	Бусад	3,797	3,853	(56)
3	Төрийн байгууллагад өгсөн хандив, дэмжлэг	39,197	39,270	(74)
	Дүн	1,576,014	1,576,051	(37)

Хүснэгт-36

Нэгтгэлийн явцад хийгдсэн том дүн бүхий тохируулгаас дурьдвал:

ГЕГ болон Оюутолгой ХХК-ийн хооронд үүссэн гаалийн татвартай холбоотой томоохон зөрүү нь 2 талын буруу тайлагналаас үүдэлтэй байсан ба нэгтгэлийн явцад 2 талаас ирүүлсэн мэдээллийг үндэслэн тохируулга хийсэн.

Засгийн газар нь “Эрдэнэт үйлдвэр” ХХК-иас хүлээн авсан ХХОАТ болон автотээврийн агаарын бохирдлын төлбөр зэрэг энэ нэгтгэлийн тайланд хамрагдахгүй татварын урсгалыг тайлагнасан тул 2 талын мэдээлэлд үндэслэн тохируулсан.

Мөн Засгийн газар нь “Эрдэнэт үйлдвэр” ХХК-иас төлсөн АМНАТ-аас 3,527 сая төгрөг, ААНОАТатвараас 500 сая төгрөг, нийт 4,027 сая төгрөгийг 2012 оны татварын хяналт шалгалтаар тавигдсан актын төлбөрт суутган тооцсон байна. Харин компани нь уг дүнгүүдийг тухайн татваруудын дүнд ч мөн бусад нөхөн төлбөр хэсэгт ч тусгаагүйгээс зөрүү үүссэн тул 2 талын мэдээлэлд үндэслэн тохируулсан.

Засгийн газар нь нь Оюутолгой ХХК-иас мөнгөөр хүлээн аваагүй 40,597 сая төгрөгийн татварыг хүлээн авсан гэж тайлагнасан тул Засгийн газрын талд бууруулах тохируулгыг хийсэн.

Компаниудын анхны тайлагнасан дүн, нэгтгэл ажлын үр дүнгээр гарсан тохируулагдсан дүнг, төлбөрийн урсгал болон компани бүрээр тайлагнан харуулсан мэдээллийн дэлгэрэнгүйг **Хавсралт-1-ийн (б), (в)-ээс** харна уу.

5.2 ШИЙДЭГДЭЭГҮЙ ЗӨРҮҮНҮҮД

5.2.1 ТАНИЛЦУУЛГА

Бүх тохируулга хийгдсэний дараа 36,840 мянган төгрөгийн шийдэгдээгүй зөрүү үлдсэн ба ЗГ-ын нийт хүлээн авсан татвар, төлбөр, хураамж, хандив, дэмжлэгийн дүнгийн 0.002 хувийг эзэлж байгаа нь материаллаг биш байна. .

Шийдэгдээгүй үлдсэн зөрүүний шалтгаан мэдэгдэхгүйгээс, ЗГ болон нэгтгэлд хамрагдаж буй компаниуд (хоёр тал)ын тайлагнасан тоо баримтыг тохируулах боломжгүйгээс үүссэн. Гэхдээ дараах хүснэгтээр шийдэгдээгүй зөрүүний нийтлэг шалтгааныг хураангуйлан харууллаа.

Шалтгаан	ЗГ	Компани	Дүн (мян.төг)
Нэмэлт мэдээлэл өгөөгүй	(31,954)	254,296	222,342
2 талаас ирсэн мэдээллүүд хоорондоо тохирохгүй	(87,970)	(77,773)	(165,743)
Компани дэлгэрэнгүй мэдээлэл өгөөгүй	8,008	(126,177)	(118,169)
Компани төлсөн татвараа, ЗГ хүлээн авсан татвараа тайлагнаагүй	(200)	1,644	1,444
Дэлгэрэнгүй мэдээлэл ирсэн боловч ашиглах боломжгүй	23,412	45	23,457
Материаллаг бус < MNT 100	(66)	(104)	(170)
Дүн	(88,770)	51,930	(36,840)

Хүснэгт-37

Засгийн газар талаас шалтгаалан шийдэгдээгүй үлдсэн зөрүүний 67 хувийг Орон нутгийн засаг захиргааны байгууллага, 29 хувийг Гаалийн ерөнхий газар, 4 хувийг Сангийн яам эзэлж байна.

Гаалийн ерөнхий газартай харилцаж ажиллахад хүндрэлтэй байсан ба үүссэн зөрүүг шийдвэрлэх тал дээр шуурхай дэмжлэг үзүүлээгүй.

Компани талаас шалтгаалан шийдэгдээгүй үлдсэн зөрүүний 64 хувийг Монголболгаргео ХХК, 23 хувийг Юшэнгминг ХХК, 5 хувийг Кожеговь, 4 хувийг Эм Ди Эф И ХХК тус тус эзэлж байна.

5.2.2 ШИЙДЭГДЭЭГҮЙ ЗӨРҮҮ САНХҮҮГИЙН УРСГАЛААР

Дараах хүснэгтээр:

- I. ЗГ болон компаниудын тайлагнасан дүнгийн анхны зөрүү
- II. Тайлагнагч байгууллагуудын ирүүлсэн нотлох баримтанд үндэслэн ЗГ болон компаниудын дүнд хийсэн тохируулга
- III. Тохируулгын дараах ЗГ болон компаниудын дүн
- IV. Санхүүгийн урсгал тус бүрээрх шийдэгдээгүй зөрүүг харуулав.

№	Үзүүлэлт	Анхны зөрүү	Тохируулга			Тохируулгын дараа		
			ЗГ	Компани	Зөрүү	ЗГ	Компани	Зөрүү
1	Улсын төсөвт төлсөн албан татвар, төлбөр, хураамж, ногдол ашиг	44,549	(20,792)	23,604	(44,396)	1,452,544	1,452,392	153
1.1	Татвар	(30,634)	(25,140)	(55,741)	30,601	492,923	492,957	(33)
1.2	Төлбөр	42,859	4,270	46,932	(42,662)	670,695	670,497	197
1.3	Үйлчилгээний хураамж	11,176	(1,292)	9,883	(11,175)	29,278	29,278	1
1.4	Төрийн өмчийн ногдол ашиг	(6)	-	(6)	6	70,429	70,429	-
1.5	Засгийн газрын хүлээн авсан урьдчилгаа төлбөрүүд	58,961	-	58,961	(58,961)	187,666	187,666	-
1.6	Бусад	(37,808)	1,371	(36,425)	37,796	1,553	1,565	(12)
2	Орон нутгийн төсөвт төлсөн албан татвар, төлбөр, хураамж, ногдол ашиг	828	(30,336)	(29,392)	(943)	84,273	84,389	(116)
2.1	Орон нутгийн төсөвт төлсөн албан татвар	409	(177)	244	(421)	14,556	14,568	(12)
2.2	Төлбөр	1,195	(7,593)	(6,350)	(1,243)	58,103	58,151	(48)
2.3	Орон нутгийн төрийн өмчийн ногдол ашиг	7,797	2	7,799	(7,797)	7,817	7,817	-
2.4	Бусад	(8,573)	(22,568)	(31,085)	8,518	3,797	3,853	(56)
3	Төрийн байгууллагад өгсөн хандив, дэмжлэг	(10,833)	27,512	16,753	10,759	39,197	39,270	(74)
	Нийт	34,544	(23,615)	10,965	(34,581)	1,576,014	1,576,051	(37)

Хүснэгт-38

Нэгтгэл тайлангийн ажил эхэлсэн хугацаа нь олборлох үйлдвэрлэл эрхэлж буй компаниудын ид ажлын үе, мөн ихэнх Төр, Засгийн байгууллага болон аж ахуйн нэгжүүдэд ажиллагсдын ээлжийн амралтын үетэй давхцаж байсан учраас, компаниуд болон Төр, Засгийн байгууллагаас тайлангийн явцад тодруулах мэдээлэл албан бичигт дурьдсан хугацаанд ирээгүй, хугацаа их алдсан.

Шийдвэрлэгдээгүй үлдсэн зөрүүний шалтгаан нь дараах байдалтай байна. Үүнд:

- ОУИТБС-ын ажлын албанд 2013 оны тайлангаа, мөн нэгтгэл тайлангийн явцад дэлгэрэнгүй мэдээлэл гаргаж өгөөгүй “Монголболгаргео”, “Бужгар орд”, “Угалзан цамхаг” зэрэг компаниудын шийдэгдээгүй зөрүү нь нийт эерэг зөрүүний 42 хувийг эзэлж байна.
- Орон нутгийн засаг захиргааны байгууллага нь зарим татвар, төлбөр, хандив, дэмжлэгийг хүлээн аваагүй гэсэн хариу ирүүлсэн. Харин компаниуд төлсөн татвар, төлбөр, үзүүлсэн хандив, дэмжлэгийн дүнг нотолсон анхан шатны баримтаа ирүүлсэн бөгөөд энэ шалтгааны улмаас үүссэн зөрүү нь сөрөг зөрүүний 51 хувийг эзэлж байна.
- Компаниуд торгуулийг төлөхдөө төлбөрийн баримтанд аж ахуйн нэгжийн нэрийг тодорхой бичихгүй, хувь хүний нэрээр төлдөг тохиолдол байна. Энэ тохиолдолд Сангийн яамны Төрийн сангийн төсвийн орлогын программаас компанийн нэрээр шүүгээд төлөлт харагдахгүй байна. Энэ мэт шалтгааны улмаас компани талаас төлсөн торгуулийн дүнг ЗГ-ын мэдээллээр нотолж чадахгүй байна.

Нэмэлт дэлгэрэнгүйг 6.2-т харуулав.

5.2.3 ШИЙДЭГДЭЭГҮЙ ЗӨРҮҮНИЙ ШАЛТГААНЫ ТОЙМ

5.2.3.1 НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ ӨГӨӨГҮЙ КОМПАНИУД

№	Компанийн нэр	Дүн (мян.төг)
108	Монголболгаргео ХХК	160,710
250	Юүшэнгминг ХХК	82,467
194	Хунт-Өгөөж ХХК	(11,910)
175	Тэн Хун ХХК	(5,660)
	Бусад	(3,265)
	Дүн	222,343

Хүснэгт-39

“Монголболгаргео” ХХК нь ОУИТБС-ын Ажлын албанд 2013 оны тайлангаа гаргаж өгөөгүй ба нэгтгэл тайлангийн явцад тайлан болон дэлгэрэнгүй мэдээлэл гаргуулж авахаар 2014 оны 08 дугаар сарын 14-ний өдөр ОУИТБС-ын Ажлын алба, “Улаанбаатар аудит корпораци” ХХК-ийн хамтарсан 2/196 тоот албан бичгийг хүргүүлж, олон дахин шаардсан хэдий ч тус компаниас ямар нэгэн мэдээлэл аваагүй учраас зөрүү шийдвэрлэгдээгүй үлдсэн.

Юүшэнгминг ХХК-иас нэгтгэл тайлангийн явцад нэмэлт (дэлгэрэнгүй) мэдээлэл авахын тулд компанийн захирал, нягтлан бодогч нарын утсаар олон удаа шаардсан боловч мэдээлэл гаргаж өгөөгүй.

5.2.3.2 ХОЁР ТАЛААС ИРСЭН МЭДЭЭЛЛҮҮД ХООРОНДОО ТОХИРОХГҮЙ БАЙГААГААС ҮҮССЭН ЗӨРҮҮ

№	Компанийн нэр	Дүн (мян.төг)
250	Юүшэнгминг ХХК	(52,178)
233	Эм Си Ти Ти ХХК	(17,645)
121	МОЭНКО ХХК	(15,667)
123	Мөнхноён суварга ХХК	(13,809)
246	Этүгэн-Эе ХХК	(9,493)
221	Шинэ Илион Нэн Юань ХХК	(8,953)
97	Кожеговь ХХК	(7,256)
17	Арева монгол ХХК	(7,086)
150	Сентеррагоулд Монголия ХХК	(6,035)
192	Хоту ХХК	(5,066)

№	Компанийн нэр	Дүн (мян.төг)
199	Хүрээ дэл ХХК	(5,000)
85	Илт гоулд ХХК	(5,000)
102	Маль флюорит ХХК	(5,000)
	Бусад	(7,555)
	Дүн	(165,743)

Хүснэгт-40

Засгийн газрын холбогдох байгууллагуудаас болон компаниудаас ирүүлсэн мэдээлэл нь хоорондоо тохирохгүйн улмаас зөрүү шийдвэрлэгдэхгүй үлдэж байна.

Тухайлбал: “Юүшэнгминг” ХХК-ийн мэдээлэл Засгийн газрын байгууллагуудаас дэлгэрэнгүй задаргаагаар ирсэн боловч компани нь мэдээллээ тодорхой ирүүлээгүйгээс, “Эм Си Ти Ти” ХХК-ийн гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр, гаалийн үйлчилгээний хураамж, АТӨЯХАТатвар, ус ашигласны төлбөр, “МОЭНКО” ХХК-ийн Ховд аймагт өгсөн хандив, дэмжлэг, “Мөнх ноён суварга” ХХК-ийн гаалийн албан татвар зэрэг нь тохирохгүй байна.

Автотээвэр өөрөө явагч хэрэгслийн албан татвар, байгаль хамгаалах зардлын 50 хувь, Төр, засгийн байгууллагад өгсөн хандив, дэмжлэгийн дүнгийн шийдэгдээгүй зөрүү нь компани талаас төлсөн, ЗГ-ын байгууллага нь хүлээн аваагүй байна гэсэн хариу өгсөн. (Компаниудаас тухайн төлбөрийг төлсөн анхан шатны баримтыг хуулбарлан авсан). **Дэлгэрэнгүйг Хавсралт 23-аас харна уу.**

5.2.3.3 КОМПАНИ ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЭЛ ӨГӨӨГҮЙ

№	Компанийн нэр	Дүн (мян.төг)
41	Бужгар-Орд ХХК	(71,846)
115	Монгол Алт МАК ХХК	(34,496)
101	Лут чулуу ХХК	(7,778)
	Бусад	(4,049)
	Дүн	(118,169)

Хүснэгт-41

Нэгтгэл тайлангийн явцад “Бужгар-Орд” ХХК-ийн удирдлага болон нягтлан бодогчтой огт холбогдож дэлгэрэнгүй мэдээлэл авч чадаагүйн улмаас Засгийн газрын дүнд үндэслэн тохируулга хийж, зөрүүг шийдвэрлэх боломжгүй байна.

5.2.3.4 КОМПАНИ ТӨЛСӨН ТАТВАРАА, ЗГ ХҮЛЭЭН АВСАН ТАТВАРААА ТАЙЛАГНААГҮЙ

№	Компанийн нэр	Дүн (мян.төг)
115	Монгол Алт МАК ХХК	2,364
	Бусад	(920)
	Дүн	1,444

Хүснэгт-42

5.2.3.5 ИРҮҮЛСЭН МЭДЭЭЛЛҮҮД ТОХИРУУЛГА ХИЙХ ШААРДЛАГА ХАНГАХГҮЙ БАЙГАА ЗӨРҮҮНҮҮД

№	Компанийн нэр	Дүн (мян.төг)
97	Кожеговь ХХК	19,523
229	Эм Ди Эф И ХХК	10,049
26	Баян айраг эксплорэйшн ХХК	(5,658)
	Бусад	(457)
	Дүн	23,457

Хүснэгт-43

Энд үүссэн зөрүү нь гаалийн албан татвар болон гаалийн үйлчилгээний хураамжтай холбоотой байна. Компаниуд гаальд төлсөн гаалийн албан татвар болон хураамжийн дүнг дэлгэрэнгүй задаргаагаар ирүүлдэг, харин Гаалийн ерөнхий газар нь компаниудаас хүлээн авсан гаалийн албан татвар, НӨАТ, гаалийн үйлчилгээний хураамжийн дүнг дэлгэрэнгүй задаргаагаар бус бөөн дүнг (тухайн компанийн жилийн турш төлсөн дүнг)-ээр ирүүлдэг учраас 2 талын дүнг тулгаж зөрүүний шалтгааныг тодорхойлох боломжгүй болсон.

5.3 НЭГТГЭЛД ХАМРАГДСАН КОМПАНИУДЫН БУСАД МЭДЭЭЛЭЛ

АМГ-аас нэгтгэлд хамрагдсан компаниудын 2013 онд үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний мэдээллийг ирүүлсэнийг **Хавсралт 11-д** дэлгэрэнгүй оруулав.

Дараах хүснэгтээр уг компаниудын үйлдвэрлэсэн ба борлуулсан бүтээгдэхүүний хураангуйг харуулж байна.

д/д	Бүтээгдэхүүний нэр	Үйлдвэрлэл		Борлуулалт	
		Тоо хэмжээ	Үнийн дүн /мян.төг/	Тоо хэмжээ	Үнийн дүн /мян.төг/
1	Зэсийн баяжмал	801,839.6	1,489,270,910.0	531,498.3	1,204,396,963.1
2	Молибдены баяжмал	3,700.0	19,186,346.5	3,638.0	44,188,792.5
3	Алт	7,932.0	382,185,405.9	26,328.2	506,701,710.4
4	Мөнгө	403.4	9,700,212.0	1,286.7	2,078,208.8
5	Нүүрс	7,190,950.9	148,661,737.2	7,115,783.1	153,870,451.2
6	Чулуун нүүрс	1,042,945.1	40,757,115.5	1,126,809.1	77,912,620.4
7	Давирхай	143.8	129,798.6	143.8	40,685.1
8	Хагас коксжсон нүүрс	1,606.5	1,449,951.3	1,606.5	219,064.1
10	Баяжуулсан коксжих нүүрс	5,306,300.0	187,800,532.0	4,421,538.5	614,632,139.9
11	Нүүрс /дайвар бүтээгдэхүүн/	2,289,304.0	10,892,387.0	1,318,302.3	57,880,605.6
13	Коксжсон нүүрс	8,635,500.1	259,544,187.0	-	-
14	Жоншны баяжмал	84,200.3	8,055,417.6	66,739.2	14,572,258.5
15	Жоншны хүдэр	18,070.5	88,100,994.4	12,131.8	1,550,955.0
16	Төмрийн хүдэр	4,099,403.0	156,151,987.7	3,183,340.4	235,862,196.1
17	Төмрийн хүдрийн баяжмал (бүхэл)	2,851,683.4	176,441,907.3	2,929,847.3	266,280,036.6
18	Төмрийн хүдрийн баяжмал (нунтаг)	3,891,405.5	9,434,828.5	519,754.4	19,946,065.4
19	Тоосго	5,041.7	794,038.3	4,774.0	749,569.6
20	Хар тугалганы баяжмал	1,141.3	4,075,114.3	1,071.3	2,744,359.3
21	Гянтболдын баяжмал	303.9	7,765,384.0	263.9	7,765,384.0
23	Хүхэрт натри	1,020.0	918,000.0	700.0	686,066.0
24	Цагаан тугалганы баяжмал	273.0	-	318.9	4,860,405.6
27	Цайр	114,674.1	28,707,030.0	130,630.6	105,661,080.5

Хүснэгт-44

6. АЖЛЫН ДААЛГАВАРТ ШААРДСАН НЭМЭЛТ СУДАЛГААНУУД

Ажлын даалгаварт заасны дагуу ОУИТБС-ын 2013 оны тайланд хэд хэдэн судалгаа хийхийг шаардсан. Үүнд:

1. Бүх хандив тусламжийн судалгааг холбогдох компани, Засгийн газрын байгууллага тус бүрээр Сангийн сайдын 2010 оны 45 дугаар тушаалын биелэлт,
2. Тайлангийн нэгтгэлд оролцож буй компаниудаас тэдгээр компаниудын 2013 оны санхүүгийн нэгдсэн тайлан ямар аудиторроор баталгаажсан, санхүүгийн тайлагналын олон улсын стандарт мөрдөгдсөн эсэх судалгааг компани бүрээр,
3. Тайлангийн нэгтгэлд орж буй компаниудын байгаль орчны нөхөн сэргээлтийн тайлан болон жилийн уулын ажлын төлөвлөгөөний биелэлтийн судалгаа,
4. Тайлангийн нэгтгэлд орж буй компаниудын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн судалгаа,
5. Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар заалтын дагуу олборлох үйлдвэрлэлийн компаниуд, орон нутгийн захиргаатай байгуулсан гэрээний судалгаа,
6. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой, орон нутгийн өмчийн оролцоотой компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийн судалгаа зэргийг гаргана.

Энэ бүлэгт дээрх даалгаврын дагуу хийсэн судалгаа болон үр дүнг хураангуйлан оруулав.

6.1 САНГИЙН САЙДЫН 2010 ОНЫ 45 ДУГААР ТУШААЛЫН БИЕЛЭЛТ

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах зарим арга хэмжээний тухай ЗГ-ын 2012 оны 222 дугаар тогтоолоор баталсан хавсралтад тухайн нутаг дэвсгэрт ашигт малтмал, газрын тосны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж болон туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгжээс орон нутгийн төсөвт төлсөн татвар, төлбөр, хураамж, үйлчилгээний хөлс, ногдол ашиг, торгууль, хандив, тусламж зэрэг орлогын тайланг аудит хийгдсэн санхүүгийн тоо баримтад үндэслэн гаргаж, нийтэд мэдээлэх ажлыг 2012 оноос эхлэн хэрэгжүүлэх, цаашид уг мэдээг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад жил бүрийн 4 дүгээр сарын 15-ны дотор тайлагнаж, нийтэд мэдээлэх ажлыг хэвшил болгох талаар тодорхой тусгасан.

Гэсэн хэдий ч жил бүрийн нэгтгэл тайланд Төрийн байгууллагууд болон орон нутгийн төсвийн байгууллагуудад үзүүлсэн хандив, дэмжлэгийн дүн тусгагдахгүй буюу хагас дутуу нэгтгэсний улмаас зөрүү үүсдэг.

Доорх хүснэгтэд тушаалын хэрэгжилтийг аймгуудын хувьд сумдаар нь, Улаанбаатарын хувьд Төр, засгийн байгууллагаар нь харуулж байна. Үүнд:




График-19

Тухайлбал, аймгуудын хувьд 45 дугаар тушаалыг 59 сум хэрэгжүүлж, 61 сум хэрэгжүүлээгүй байна.

Нийслэл дэх улсын байгууллагын тухайд дараах байгууллагууд 45 дугаар тушаалыг хэрэгжүүлээгүй байна. Үүнд:

- Хил хамгаалах ерөнхий газар,
- Налайх-хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сан,
- Богдхааны ордон музей,
- Чойжин ламын сүм музей,
- Дүрслэх урлагын музей,
- Монголын театрын музей,
- Монголын Үндэсний музей,
- Хөдөлмөрийн Яамны Мэргэжлийн Боловсрол Сургалтын Газар,
- Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв.

Төрийн байгууллага болон орон нутгийн байгууллагуудын 45-р тушаалын хэрэгжилтийн **дэлгэрэнгүйг Хавсралт 7-а,б–ээс харна уу.**

6.2 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОЛОН УЛСЫН СТАНДАРТ (СТОУС)-ЫН МӨРДӨЛТ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАН АУДИТЛАГДСАН БАЙДАЛ

Нэгтгэлийн ажлын нэг хэсэг болгож бид тайланд хамрагдаж буй 250 компанид 2013 оны аудитын тайлан (боломжгүй бол хамгийн сүүлийн аудитын тайлан)-гийн хуулбар ирүүлэх хүсэлт тавьсан. Хүлээж авсан тайлангуудаас:

- Санхүүгийн тайланг СТОУС болон НББОУС-д нийцүүлэн бэлтгэсэн
- Аудитыг Аудитын олон улсын стандартын дагуу хийж гүйцэтгэсэн гэсэн аудиторын мэдэгдэл байгаа эсэхийг шалгасан.

Мөн аудитын тайлангуудад хязгаарлалттай дүгнэлт өгсөн эсэхийг шалгаж үзсэн.

Дээрх судалгаанд компаниуд дараах байдлаар хариуллаа:

Аудитын тайлан гаргаж өгсөн компани 205

Аудитын тайлан гаргаж өгөөгүй компани 45

Нэгтгэл тайланд хамрагдаж буй компани 250

Үүнээс үзэхэд нийт компанийн 22% нь дээрх хүсэлтэд хариу ирүүлээгүй байна.

Аудитын тайлангаа ирүүлсэн 205 компаниас 181 компанийн аудитын тайлан зөрчилгүй дүгнэлттэй, 16 компани хязгаарлалттай санал дүгнэлттэй, 2 компанийн аудитын тайланд дүгнэлт өгөхөөс татгалзсан, 6 компани аудит хийлгээгүй байна.

Хариу ирүүлсэн компаниудын аудитын дүгнэлтийн 88.3 хувь нь зөрчилгүй дүгнэлт, 8.8 хувь нь зөрчилтэй болон бусад хэлбэрийн аудитын дүгнэлтийг авсан ба, 2.9 хувь нь аудит хийлгээгүй байна.




График-20

Судалгааны дэлгэрэнгүйг **Хавсралт 8-аас** харна уу.

6.3 УУЛЫН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН СУДАЛГАА

АМГ-аас нүүрс үйлдвэрлэгчдээс бусад уул уурхайн 92 компанийн уулын ажлын төлөвлөгөөний биелэлтийн мэдээлэл ирсэн.

Мэдээлэл нь ирээгүй 159 компанийн 65 нь хайгуулын тусгай зөвшөөрөлтэй, 93 нь ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй компаниуд байна.

МОУИТБС-ын наймдугаар тайлан буюу 2013 оны нэгтгэлийн тайлан

№	Компанийн нэр	Per. №	Бүт.нэр
1.	Адил-Оч ХХК	2707969	Хайлуур жонш
2.	Алтайнхүдэр ХХК	5095549	Төмөр
3.	Алтандорнод монгол ХХК	2112868	Шороон алт
4.	Андын тэмүүлэл ХХК	5205581	Алтны шороон орд
5.	Анхай-Интернэшнл ХХК	2863847	Төмрийн хүдэр
6.	Баян айраг эксплорэйшн ХХК	2708701	Алт
7.	Баянжонш ХХК	2696304	Хүдэр
8.	Баянтэгш импекс ХХК	2609436	Жонш
9.	Баян-Эрдэс ХХК	2551764	Алт
10.	Болдтөмөр ерөө гол ХХК	2855119	Төмрийн хүдэр
11.	Бороогоулд ХХК	2094533	Алт
12.	Булгангангат ХХК	5091462	Алт
13.	Газархэвлий ХХК	4247434	Алт
14.	ГБНБ ХХК	2615797	Алт
15.	Гурвантөхөм ХХК	2086166	Алт
16.	Дарханы төмөрлөгийн үйлдвэр ХК	2051303	Төмрийн хүдэр
17.	Дацантрейд ХХК	2061848	Алт
18.	Дорнын хүдэр ХХК	5197201	Төмрийн хүдэр
19.	Дунфанлунма ХХК	5180953	Хайлуур жонш
20.	Дун-Эрдэнэ ХХК	2010933	Алт
21.	Дун-Юань ХХК	2724146	Хар тугалганы баяжмал
22.	Жамп-Алт ХХК	3738191	Алт
23.	Жинхуа орд ХХК	5002486	Хүдэр
24.	Жотойнбажууна ХХК	5089417	Алт
25.	Засаг чандмань майнэ ХХК	5382432	Төмөр
26.	Зө-Ююе ХХК	5016665	Төмрийн хүдэр
27.	Илтгоулд ХХК	5073189	Алт
28.	Инфинетиспэйс ХХК	5467268	Төмрийн хүдэр
29.	Коммод ХХК	2685841	жонш
30.	Лут чулуу ХХК	5396662	Төмрийн хүдэр
31.	Маркополо ХХК	2069792	Алт
32.	МИМС ХХК	5082544	Хайлуур жонш
33.	Монвольфрам ХХК	2743744	гянт бол
34.	Монголболгаргео ХХК	2550245	Алт
35.	Монголжюаньли ХХК	5051304	Хайлуур жонш
36.	Монголросцветмет ХХК	2550466	Алт,жонш,нүүрс, мөнгө
37.	Монголчех металл ХХК	5051134	Хайлуур жонш
38.	Монголын алт МАК ХХК	2095025	Нүүрс, алт

№	Компанийн нэр	Per. №	Бүт.нэр
39.	Мондулаан трейд ХХК	2554518	Алтны шороон орд
40.	Монлаа ХХК	2045931	Төмрийн хүдэр
41.	Монполимет ХХК	2029278	Алт
42.	МОНСКОРГ ХХК	5359015	Гянт болд
43.	НАБД ХХК	5082137	Алт
44.	НК ХХК	2703068	Шавар,тоосго
45.	Нордвинд ХХК	5003539	жонш
46.	Ньюпэрл ХХК	5010314	Алт
47.	Нэйшнлхимикал ХХК	2646455	Хүхэр
48.	Олова ХХК	2782944	цагаан тугалга
49.	Орлойван ХХК	4187083	жонш
50.	Оюу Толгой ХХК	2657457	зэс, алт
51.	Өгөөжбаян хангай ХХК	5515882	алт
52.	Өрмөн-Уул ХХК	2617749	алт
53.	Рео ХХК	5018056	Ховор металл, алт
54.	Си Эм Кей Ай ХХК	5288703	Хайлуур жонш
55.	Сонортрейд ХХК	2590565	алт
56.	СС Монголиа ХХК	2587645	Гянтболд
57.	Тод-Ундрага ХХК	2872943	алт
58.	Томшижир ХХК	5363136	алт
59.	Тэн Хун ХХК ХХК	2839717	алт
60.	Тэнүүн байгаль ХХК	2582457	хайлуур жонш
61.	Улз гол ХХК	2344343	алт
62.	Уулс Заамар ХХК	2819996	алт
63.	Фокусметал майнинг ХХК	5567319	төмрийн хүдэр
64.	Ханхас трейд ХХК	2787318	хайлуур жонш
65.	Хонг Чанг Ли ХХК	5352959	Цагаан тугалга, гянт болдын баяжмал
66.	Хосхас ХХК	2100231	алт
67.	Хоту ХХК	2763788	Алт
68.	Хунт-Өгөөж ХХК	2166631	Хайлуур жонш
69.	Хурай ХХК	2019086	Алт
70.	Хүдэр-Эрдэнэ ХХК	2041391	Алт, мөнгө
71.	Хүслэмж ХХК	2872722	Алт, төмөр, зэс полиметалл
72.	Хэрлэн-Импекс ХХК	2009765	Хайлуур жонш
73.	Хэрлэн-Энерго ХХК	2871114	Жонш
74.	Цайртминерал ХХК	2548747	Хүдэр, хайгуулын талбай
75.	Цогт-Онон ХХК	2097109	Вольфрам
76.	Цэвдэг ХХК	2587025	Алтны шороон орд

№	Компанийн нэр	Per. №	Бүт.нэр
77.	Цэнгэг-Орог ХХК	5320798	Алт
78.	Чинхаш ХХК	5374367	Төмрийн хүдэр
79.	Чулуут Интернэшнл ХХК	2800497	Жонш
80.	Шанжин Орд ХХК	5197325	Төмөр
81.	Шижирталст ХХК	2770601	Алт
82.	Шинь Шинь ХХК	2830213	Холимог металл
83.	Шинэ мандал өргөө ХХК	5173442	Алтны шороон орд
84.	Эм Ди Эф И ХХК	5504767	Хайлуур жонш
85.	Эм Жи Би ХХК	5018536	Жонш
86.	Эм Си Ти Ти ХХК	5015243	Жонш
87.	Эрдэнэлинк ХХК	5074495	Цагаан тугалга, Вольфрам
88.	Эрдэнэт ХХК	2074192	Зэс, Молибден
89.	Эрдэс групп ХХК	5145789	төмрийн хүдэр
90.	Эс Би Эф ХХК	5184851	алт
91.	Эс Жи Майнинг Эрдэс ХХК	5381584	алт
92.	Юүшэнгминг ХХК	5382475	Хар тугалга

Хүснэгт-45

Доорх хүснэгтэд давхардсан тоогоор (нүүрс ороогүйгээр) **117** компанийн уулын ажлын төлөвлөгөө, түүний гүйцэтгэлийг 15 нэр төрлийн бүтээгдэхүүнээр гарган харуулав. Бүтээгдэхүүний хэмжээг тухайн бүтээгдэхүүний хэмжих нэгжээр илэрхийлсэн. **(Дэлгэрэнгүйг Хавсралт 12-ийн “а,б”-аас харна уу).**

№	Бүтээгдэхүүний нэр, төрөл	Компанийн тоо	Хөрс хуулалт, мян.м3			Хүдэр олборлолт, мян.м3 /үндсэн ордод мян.тн/			Хүдэр боловсруулалт, мян.м3 /үндсэн ордод мян.тн/			Бүтээгдэхүүн гаргалт /Ау, Аг-кг, элс, хайрга- мян.м3, Cu,Mo, Fe, Zn, W, Sn, нүүрс,жонш, шохой- мян.тн, тоосго- сая.ширхэг/			Бүтээгдэхүүн борлуулалт /Ау, Аг-кг, элс, хайрга- мян.м3, Cu,Mo, Fe, Zn, W, Sn, нүүрс,жонш, шохой- мян.тн, тоосго- сая.ширхэг/		
			Төл-гөө	Гүй-л	Хувь	Төл-гөө	Гүй-л	Хувь	Төл-гөө	Гүй-л	Хувь	Төл-гөө	Гүй-л	Хувь	Төл-гөө	Гүй-л	Хувь
1	Алт	41	26,987.59	23,560.53	87%	5,681.00	4,605.83	81%	9,865.79	11,176.25	113%	5,397.32	5,415.10	100%	5,351.79	4,882.77	91%
2	Алт-зэс*	1	57,135.80	-	0%	52,539.31	-	0%	33,263.49	-	0%	640.10	-	0%	640.10	-	0%
3	Гөлтгөнө	1	17.50	53.00	303%	20.00	114.94	575%	-	-		20.00	-	0%	20.00	-	0%
4	Гянтболд, гянтболдын баяжмал	3	-	-		21.13	204.01	965%	21.13	204.01	965%	769.24	263.86	34%	769.24	263.86	34%
5	Жонш	24	1,274.38	658.52	52%	1,067.15	468.25	44%	1,210.54	461.11	38%	536.73	94.01	18%	518.58	252.36	49%
6	Зэс, зэсийн баяжмал	2	4,957.00	49,428.00	997%	27,650.00	58,663.82	212%	25,650.00	46,361.86	181%	499.89	802.84	161%	-	531.58	
7	Мөнгө, Төмөр, Хар тугалга холимог	1	-	-		132.00	14.50	11%	132.00	5.80	4%	5,346.00	-	0%	10,560.00	-	0%
8	Төмөр, төмрийн баяжмал	15	34,870.35	16,588.56	48%	17,951.08	10,981.28	61%	17,035.88	9,289.18	55%	9,930.22	5,479.37	55%	9,756.07	5,436.22	56%
9	Хар тугалага, цайр, алт мөнгө	1				682.56			400.00		0%	15,668.80		0%	14.00	-	0%
10	Холимог металл	1		486.63			66.02										
11	Хүхэрт натри	1	26.16		0%	69.50		0%	52.50		0%	9.07		0%	9.00	-	0%
12	Цагаан тугалга, цагаан тугалганы баяжмал	3	237.24	251.57	106%	711.64	162.36	23%	711.64	162.36	23%	235.16	-	0%	310.02	-	0%
13	Цайрын баяжмал	2	1,351.90	1,395.33	103%	534.25	5,783.24	1082%	517.82	392.43	76%	7,815.50	103.53	1%	9,348.50	117.95	1%
14	Элс, хайрга	2	2.50	-	0%	245.72	5.90	2%	-	-		245.72	5.90	2%	245.72	5.90	2%
15	Тоосго	1		-			6.24			6.24			2.54			2.27	
*Оюу толгой ХХК-ийн бүтээгдэхүүнийг алт, зэсээр нь салгасан мэдээлэл АМГ-аас ирүүлээгүй учир тусад нь харуулав.																	

Хүснэгт-46

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн мэдээ, уулын ажлын төлөвлөгөө болон түүний биелэлтийн судалгааг АМГ-аас гаргаж ирүүлсэн мэдээ материалд үндэслэн гаргасан.

Алт олборлодог 41 компаниас хөрс хуулалт, хүдэр олборлолт, боловсруулалт болон бүтээгдэхүүн гаргалт, борлуулалтаараа томоохон дүн бүхий 9 компанийг сонгож харуулбал:

№	Бүтээгдэхүүний нэр, төрөл	Хөрс хуулалт, мян.м3			Хүдэр олборлолт, мян.м3 /Үндсэн ордод мян.тн/			Хүдэр боловсруулалт, мян.м3 /Үндсэн ордод мян.тн/			Бүтээгдэхүүн гаргалт /Au, Ag-кг, элс, хайрга- мян.м3, Cu,Mo, Fe, Zn, W, Sn, нүүрс,жонш, шохой- мян.тн, тоосгосая.ширхэг/			Бүтээгдэхүүн борлуулалт /Au, Ag-кг, элс, хайрга- мян.м3, Cu,Mo, Fe, Zn, W, Sn, нүүрс,жонш, шохой- мян.тн, тоосгосая.ширхэг/		
		Төл-гөө	Гүй-л	Хувь	Төл-гөө	Гүй-л	Хувь	Төл-гөө	Гүй-л	Хувь	Төл-гөө	Гүй-л	Хувь	Төл-гөө	Гүй-л	Хувь
1	Уулс заамар	386.18	9,416.46	2438%	303.00	679.66	224%	303.00	679.66	224%	75.70	228.49	302%	75.70	228.49	302%
2	Улз гол	1,370.77	1,925.30	140%	113.28	165.34	146%	113.28	165.34	146%	81.20	113.26	139%	81.20	113.26	139%
3	Монголросцветмет	1,207.40	1,439.00	119%	73.90	78.90	107%	73.90	78.90	107%	90.30	60.20	67%	90.30	60.40	67%
4	Монполимет	1,802.40	2,353.70	131%	1,945.11	1,701.20	87%	1,945.11	1,701.20	87%	415.17	524.10	126%	415.17	-	0%
5	Эс Би Эф	1,126.90	1,126.00	100%	45.40	45.40	100%	45.40	45.40	100%	32.20	57.80	180%	32.20	57.80	180%
6	Алтандорнод монгол	8,345.10	3.10	0%	321.90	127.90	40%	321.90	127.90	40%	858.00	436.00	51%	858.00	436.00	51%
7	Булгангангат	1,307.47	613.90	47%	90.97	25.93	29%	90.97	25.93	29%	153.19	30.72	20%	153.19	30.72	20%
8	Хосхас	1,673.98	487.43	29%	103.94	32.11	31%	103.94	32.11	31%	69.44	16.69	24%	-	16.69	-
9	Баян айраг эксплорэйшн	1,486.78	352.40	24%	462.37	136.39	29%	278.95	-	0%	311.25	-	0%	311.25	-	0%
	Дүн	18,706.97	17,717.29	95%	3,459.87	2,992.82	87%	3,276.45	2,856.43	87%	2,086.45	1,467.26	70%	2,017.01	943.36	47%
	Нийт дүнд эзлэх хувь	69%	75%		61%	65%		33%	26%		39%	27%	0%	38%	19%	

Хүснэгт-47

Төмөр, төмрийн хүдэр, баяжмал олборлодог 15 компаниас ирүүлсэн мэдээллээс томоохон дүн бүхий 8 компанийг сонгож хөрс хуулалт, хүдэр олборлолт, боловсруулалт, бүтээгдэхүүн гаргалт болон борлуулалтын мэдээллийг харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

№	Бүтээгдэхүүний нэр, төрөл	Хөрс хуулалт, мян.м3			Хүдэр олборлолт, мян.м3 /Үндсэн ордод мян.тн/			Хүдэр боловсруулалт, мян.м3 /Үндсэн ордод мян.тн/			Бүтээгдэхүүн гаргалт /Au, Ag-кг, элс, хайрга- мян.м3, Cu,Mo, Fe, Zn, W, Sn, нүүрс,жонш, шохой- мян.тн, тоосгосая.ширхэг/			Бүтээгдэхүүн борлуулалт /Au, Ag-кг, элс, хайрга- мян.м3, Cu,Mo, Fe, Zn, W, Sn, нүүрс,жонш, шохой- мян.тн, тоосгосая.ширхэг/		
		Төл-гөө	Гүй-л	Хувь	Төл-гөө	Гүй-л	Хувь	Төл-гөө	Гүй-л	Хувь	Төл-гөө	Гүй-л	Хувь	Төл-гөө	Гүй-л	Хувь
1	Дарханы төмөрлөгийн үйлдвэр	1,800.00	2,763.00	153.5%	1,000.00	1,003.00	100.3%	1,000.00	-	0.0%	650.00	-	0.0%	650.00	-	0.0%
2	Алтайнхүдэр	7,859.40	6,092.06	77.5%	6,084.00	5,848.83	96.1%	5,868.80	5,124.69	87.3%	2,523.60	2,246.74	89.0%	2,523.60	2,224.99	88.2%
3	Дарханы төмөрлөгийн	4,400.00	-	0.0%	1,000.00	-	0.0%	1,000.00	-	0.0%	650.00	-	0.0%	650.00	-	0.0%
4	Монлаа	1,589.50	-	0.0%	728.77	-	0.0%	728.77	-	0.0%	218.63	-	0.0%	218.63	-	0.0%
5	Эрдэсгрупп	1,054.20	630.90	59.8%	503.30	215.20	42.8%	503.30	222.80	44.3%	327.10	132.30	40.4%	350.00	226.50	64.7%
6	Болдтөмөр ерөө гол	13,306.00	5,782.96	43.5%	5,970.90	2,486.59	41.6%	5,970.90	2,514.91	42.1%	4,000.00	2,069.39	51.7%	4,000.00	2,069.39	51.7%
7	Монголросцветмет	1,500.00	-	0.0%	600.00	-	0.0%	400.00	-	0.0%	186.00	-	0.0%	186.00	-	0.0%
8	Инфинити спэйс	1,240.45	194.57	15.7%	500.00	164.95	33.0%	-	164.95	-	500.00	148.45	29.7%	500.00	148.45	29.7%
	Дүн	32,749.55	15,463.49	47.2%	16,386.97	9,718.57	59.3%	15,471.77	8,027.35	51.9%	9,055.33	4,596.88	50.8%	9,078.23	4,669.33	51.4%
	Нийт дүнд эзлэх хувь	94%	93%	99%	91%	89%	97%	91%	86%	95%	91%	84%	92%	93%	86%	92%

Хүснэгт-48

Доорхи хүснэгтэд 32 нүүрс олборлогч компаниудын уулын ажлын төлөвлөгөө болон гүйцэтгэлийн судалгааг харуулав. **(Дэлгэрэнгүйг Хавсралт 12-б-ээс харна уу).**

Хөрс хуулалт (мян.м3)			Бүтээгдэхүүн гаргалт (Нүүрс, мян.тн)			Бүтээгдэхүүн борлуулалт (Нүүрс, мян.тн)		
төл-гөө	гүйц-л	хувь	төл-гөө	гүйц-л	хувь	төл-гөө	гүйц-л	хувь
250,373.56	149,527.66	59.72	54,781.24	33,549.03	61.24	41,830.91	20,685.31	49.45

Хүснэгт-49

2013 онд хөрс хуулалтын байдлыг хамгийн их хөрс хуулсан компаниас эхлэн бага руу нь задлан харуулбал дараах байдалтай байна.

Компанийн нэрс	Хөрс хуулалт (мян.м3)	Ашигт малтмалын төрөл
Энержи ресурс ХХК	52,900.00	Нүүрс
Оюу толгой ХХК	42,783.30	Алт, зэс
Эрдэнэс Таван толгой ХК	19,654.40	Нүүрс
Багануур ХК	18,640.50	Нүүрс
Монголын алт МАК ХХК	12,955.60	Нүүрс
Уулс заамар ХХК	9,416.46	Алт
Таван толгой ХК	9,355.20	Нүүрс
Саусгоби сэндс ХХК	8,450.00	Нүүрс
Шивээ-Овоо ХК	7,061.50	Нүүрс
Эрдэнэт үйлдвэр ХХК	6,644.70	Зэс
Алтай хүдэр ХХК	6,092.06	Төмрийн хүдэр
Болд төмөр ерөө гол ХХК	5,782.96	Төмрийн хүдэр
Чин Хуа МАК Нарийн сухайт ХХК	4,300.80	Нүүрс
Шарын гол ХК	3,592.80	Нүүрс
Бусад	34,319.52	Нүүрс
Дүн	241,949.80	

Хүснэгт-50

Компаниуд нь янз бүрийн чиглэлээр олборлох үйл ажиллагаа явуулж байгаа тул олборлолт, боловсруулалт, бүтээгдэхүүн гаргалт, бүтээгдэхүүн борлуулалтын биет хэмжээг хооронд нь харьцуулах боломжгүй учраас ижил нэгжээр илэрхийлэгдэх байдлаар нь ангилж харууллаа.

Судалгааны үр дүнгийн **дэлгэрэнгүйг Хавсралт-12-ийн “а,б”-д харуулав.**

6.4 БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН МЭДЭЭ

Энэ судалгааны хариултын хувь доогуур байна.

Мэдээлэл ирүүлсэн компани	95	38.0%
Мэдээлэл ирүүлээгүй компаниуд:		
Хайгуул	20	8.0%
АМГ-т мэдээ, тайлангаа өгөөгүй	129	51.6%
Газрын тос /хайгуул/	6	2.4%
Судалгаанд хамрагдсан нийт компани	250	100.0%

АМГ-аас ирүүлсэн мэдээлэлд үндэслэн гаргасан байгаль хамгаалал, нөхөн сэргээлтийн тайланг **Хавсралт 10-ын а, б, в-д** хураангуйлан харуулав.

Доорх хүснэгтэд нөхөн сэргээлт хийсэн 95 (газрын тосны тусгай зөвшөөрөл эзэмшигч 8 компаниас бусад) компанийн **хураангуйг Хавсралт 10-ийн “а,б,”-д харуулав.**

Техникийн нөхөн сэргээлт (мян.м3)			Шимт хөрсний нөхөн сэргээлт (мян.м3)			Биологийн нөхөн сэргээлт (мян.м3)			Зарцуулагдах хөрөнгийн хэмжээ (мян.төг-р)		
Төл	Гүй-л	Хувь	Төл	Гүй-л	Хувь	Төл	Гүй-л	Хувь	Төл	Гүй-л	Хувь
503.0	640.5	127.4	523.5	477.0	91.1	426.4	296.0	69.4	11,991.1	12,117.2	101.0

Хүснэгт-51

Нөхөн сэргээлтийн мэдээнээс техникийн, шимт хөрсний, биологийн нөхөн сэргээлтийг “Алтандорнод монгол”, “Бороогоулд”, “Гурван төхөм”, “Монполимет”, “Өрмөн-Уул”, “Хүдэр-Эрдэнэ” зэрэг компаниуд 100 хувийн гүйцэтгэлтэй хийсэн байна.

“Бороо гоулд” ХХК нь 2013 онд нийт 40 га талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг хийж, орон нутагт албан ёсоор хүлээлгэн өгсөн байна.

Цаашид 2014-2018 оныг хүртэл нийт 406.8 га талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг хийхээр төлөвлөн ажиллаж байна.

Мөн компани нь ойжуулалтын хөтөлбөрийг 2008 оноос хэрэгжүүлж эхэлсэн байна. “Tree global” ХХК-тай хамтран 2013 онд 28.8 га талбайд 34,500 мод, бутыг амжилттай тарьж суулгасан байна.

Компани нь ХААИС, Биологийн хүрээлэнгийн судлаачидтай хамтран нөхөн сэргээсэн талбайд биологийн олон янз байдлын судалгаа буюу био мониторингийн ажлыг 2010-2012 онуудад амжилттай хэрэгжүүлсэн бөгөөд хяналт шинжилгээний үр дүнд уурхайн нөхөн сэргээсэн талбайнуудын хэмжээнд 13 зүйл хөхтөн амьтан, 63 зүйл шувуу, 1 зүйл хоёр нутагтан, 2 зүйл мөлхөгч, 109 зүйлийн шавж бүртгэгдсэн байна. Бүртгэгдсэн амьтдын олонх нь нутгийн уугуул зүйлүүд бөгөөд байгалийн талбайгаас уурхайн нөхөн сэргээлт хийгдсэн талбайд шилжин суурьшиж байгаа нь биологийн нөхөн сэргээлтийн тодорхой үр дүн буюу нөхөн сэргээлт сайн явагдаж буйг нотлох үзүүлэлт болсон байна.

Харин Цөмийн энергийн газарт “Кожеговь”, “Арева монгол” зэрэг компаниуд нь байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх мэдээ тайлангаа гаргаж өгөөгүй байна.

Газрын тосны тусгай зөвшөөрөл эзэмшигч “Петрочайна дачин тамсаг” ХХК Бүтээгдэхүүн хуваах гэрээт XIX, XXI зэрэг талбайн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх мэдээг ирүүлсэн. **Дэлгэрэнгүйг Хавсралт 10-ы “в”-д харуулав.**

2013 оны байгаль орчныг хамгаалах ажлын гүйцэтгэл Тосон-Уул XIX талбайд 64.5%, Тамсаг XXI талбайд 35%-тай байна.

Нөхөн сэргээлтэд хамгийн их зарцуулалт хийсэн компанийг дурьдвал:

- “Бороо гоулд” ХХК 968.0 сая төгрөг,
- “Монполимет” ХХК 516.9 сая төгрөг,
- “Алтандорнод Монгол” ХХК 443.4 сая төгрөг тус тус зарцуулсан байна.

БОНХЯ-наас авсан мэдээллээр нэр бүхий 155 компани 2013 онд 1,545,178.7 мянган төгрөгийг Байгаль орчныг хамгаалах тусгай дансанд төвлөрүүлсэн байна. **(Хавсралт-18-ын “а,б”-ээс үзнэ үү).**

Тусгай дансанд байршуулсан хөрөнгийн бүртгэлээс харахад нэр бүхий 6 компани 2013 онд нөхөн сэргээлтийн ажлаа бүрэн хийж, төвлөрүүлсэн хөрөнгө 225,173.6 мянган төгрөгийг буцааж авсан байна.

Нөхөн сэргээлтийн тусгай дансанд 2006-2013 онд төвлөрүүлсэн орлогыг дараах хүснэгтээр харуулж байна.

Он	Орлого (төгрөгөөр)	Зарлага (төгрөгөөр)
2006	21,803,500.00	-
2007	611,860,364.00	-
2008	566,095,963.00	21,030,496.00
2009	385,383,450.00	125,510,000.00
2010	942,356,949.00	1,000,000.00
2011	1,215,632,023.00	5,400,000.00
2012	2,013,865,962.26	15,700,000.00
2013	1,545,178,703.50	225,173,585.00
Дүн	7,302,176,914.76	393,814,081.00
Эцсийн үлдэгдэл	-	6,908,362,833.76

Хүснэгт-52

6.5 АШИГЛАЛТЫН БОЛОН ХАЙГУУЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

6.5.1 ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Бид 2014 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөр нэгтгэж гаргасан ашигт малтмал, газрын тос, байгалийн хийн хайгуул болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн мэдээллийг авсан бөгөөд Хавсралт 13-т дэлгэрэнгүй харуулж байна. Үүнд:

1. Нэгтгэл тайланд хамрагдсан 250 компанийн лицензийн жагсаалт (**Хавсралт 13-а**)
2. Нийт лиценз эзэмшигчдийн жагсаалт (**Хавсралт 13-б**)
3. Цацраг идэвхт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн жагсаалт (**Хавсралт 13-в**)
4. Газрын тосны тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн жагсаалт (**Хавсралт 13-г**)

АМГ-аас ирүүлсэн мэдээллээс харахад 2014 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн байдлаар нийт 1,660 аж ахуйн нэгж 3,029 ширхэг лиценз эзэмшиж байна.

6.5.2 АШИГЛАЛТЫН БОЛОН ХАЙГУУЛЫН ХАМГИЙН ОЛОН ЛИЦЕНЗ ЭЗЭМШИГЧ

Нэгтгэл тайланд хамрагдсан 250 компаниудаас хамгийн олон лиценз эзэмшиж буй компанийг дараах байдлаар харуулав. Үүнд:

Д/Д	Нэрс	БОНССа нд барьцаа мян.төг	"А" лицен з	"Х" лицен з	Бүг д	Өмчийн хэлбэр
1	Алтандорнод Монгол ХХК	-	30	23	53	100 хувь монголын Хөрөнгө оруулалттай
2	Монголросцветмет ХХК	8,500.0	32	2	34	100 хувь монголын Хөрөнгө оруулалттай
3	Монголын алт МАК ХХК	29,566.0	23	4	27	100 хувь монголын Хөрөнгө оруулалттай
4	Кожеговь ХХК	-		25	25	100 хувь монголын Хөрөнгө оруулалттай
5	МОНЭНКО ХХК	-	10	7	17	100 хувь гадаадын Хөрөнгө оруулалттай
6	Гоби коул энд энерги ХХК	3,500.0	9	7	16	100 хувь монголын Хөрөнгө оруулалттай
7	Олон овоот гоулд ХХК	-	8	8	16	100 хувь монголын Хөрөнгө оруулалттай
8	Бумбат ХХК	-	7	8	15	100 хувь монголын Хөрөнгө оруулалттай
9	Сентеррагоулд монголия	800.0	8	6	14	100 хувь гадаадын Хөрөнгө

д/д	Нэрс	БОНССа нд барьцаа мян.төг	"А" лицен з	"Х" лицен з	Бүг д	Өмчийн хэлбэр
	ХХК					оруулалттай
10	Пибодивинсвэй ресорсез ХХК	3,600.0	5	8	13	100 хувь гадаадын Хөрөнгө оруулалттай
11	Тефис майнинг ХХК	-	2	9	11	100 хувь гадаадын Хөрөнгө оруулалттай
	Нийт	41,566.0	134	107	241	

Хүснэгт-53

6.5.3 АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХӨДӨЛГӨӨН

Нэгтгэлд хамрагдсан компаниудын ашиглалтын болон хайгуулын лицензийн хөдөлгөөнийг харуулбал дараах байдалтай байна. **(Дэлгэрэнгүйг Хавсралт 13-ын "а" –аас харна уу).**

	Нийт лицензийн тоо			
	2013 оны эхэнд	Шинээр авсан	Хасагдсан	2013 оны эцэст
Нэгтгэлд хамрагдсан компаниудын хувьд	938	-	86	852

Хүснэгт-54

Тусгай зөвшөөрлийг дараах шалтгаануудын улмаас хассан байна:

- Ордын нөөцийг улсын бүртгэлд бүртгүүлээгүй
- Тусгай зөвшөөрлийн жилийн төлбөрөө хийгээгүй
- Бусад

Цацраг идэвхт ашигт малтмалын 68 лицензийг 14 аж ахуйн нэгж эзэмшиж хайгуулын үйл ажиллагаа явуулж байна. 2013 оны эхэнд 85 лицензийг 16 аж ахуйн нэгж эзэмшиж байсан ба тухайн ондоо 16 лицензийг бүхэлд нь буцаах, мөн 1 лицензийг шүүхийн шийдвэрт үндэслэн хүчингүй болгох зэрэг шалтгаанаар нийт 17 лицензийг хасч, 2013 оны эцэст 68 лиценз бүртгэлтэй байна. **(Дэлгэрэнгүйг Хавсралт 13-ын "в"-ээс харна уу).**

6.5.4 ГАЗРЫН ТОС, БАЙГАЛИЙН ХИЙН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХӨДӨЛГӨӨН

Газрын тосны лицензийг 21 талбайд 16 аж ахуйн нэгж эзэмшин үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс 3 талбайд олборлолтын үйл ажиллагаа явагдаж байна. Цаашид Галба XI гэсэн талбайгаас газрын тос олборлох магадлал өндөр байна. **(Дэлгэрэнгүйг Хавсралт 13-ын "г"-ээс харна уу)**

6.6 ОЛБОРЛОХ КОМПАНИУД ОРОН НУТГИЙН ЗАСАГ ЗАХИРГААТАЙ МОНГОЛ УЛСЫН АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН 42 ДУГААР ЗҮЙЛИЙН ДАГУУ БАЙГУУЛСАН ГЭРЭЭ

6.6.1 ХУУЛИЙН ЗААЛТ

Монгол улсын Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн дараах заалтуудаар уул уурхайн тусгай зөвшөөрөл эзэмшигч болон орон нутгийн захиргааны байгууллага хоорондын харилцааг зохицуулдаг. Үүнд:

1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж ажиллана.
2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 42.1-д заасан асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай хамтран олон нийтийн хэлэлцүүлэг явуулж болно.
3. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн болон түүний байгаль орчныг нөхөн сэргээх үйл ажиллагаанд олон нийтийн хяналт тавих үүрэг бүхий төлөөлөгчийг иргэд дундаасаа сонгон ажиллуулж болно.

6.6.2 АРГАЧЛАЛ

Нэгтгэл тайлангийн ажил эхлэхэд орон нутгийн засаг захиргааны байгууллагуудад “Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн компаниуд болон орон нутгийн засаг захиргааны хооронд байгуулсан гэрээний хуулбар, эсхүл биелэлтийн товч тайлан”-г хавсралтаар гаргаж явуулна уу гэж 2014 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 2/240 тоот албан бичгээр хандсан.

Өвөрхангай, Сүхбаатар, Увс зэрэг 3 аймаг гэрээний судалгааг дутуу ирүүлсэн ба 5 аймаг хариу огт ирүүлээгүй. Өмнөх жилүүдийн туршлагаас харахад компаниудаас гэрээний судалгаа авахаар үр дүн бага нэгтгэлийн шаардлагын түвшинд мэдээлэл ирдэггүй тул компаниудаас гэрээний судалгаа аваагүй болно. Тиймээс бид орон нутгийн засаг захиргааны байгууллагад гэрээний бүртгэл бэлэн, мөн гүйцэтгэлийг дүгнэсэн акт, протокол байдаг гэсэн үндэслэлээр орон нутагт хандаж, хавсралтаар мэдээлэл авсан.

Судалгаагаар компаниуд нийт 153 гэрээг орон нутгийн ЗДТГ-тай байгуулсан байна.

Гэрээний хураангуйг дараах хүснэгтээр харуулав.

д/д	Гэрээний утга	Гэрээ хийсэн компанийн тоо		Хийсэн гэрээний тоо		Гэрээнд хамрагдсан орон нутаг	
		2013	2014	2013	2014	2013	2014
1	Хамтран ажиллах гэрээ	7	8	14	8	6	8
2	Нийгмийн хариуцлагын гэрээ	9	14	12	15	3	6
3	Ус ашиглах гэрээ	23	15	30	16	11	8
4	Газар ашиглах гэрээ	16	10	27	10	10	8
5	Орд ашиглалтын гэрээ	6	1	6	1	3	1
6	Байгаль орчныг нөхөн сэргээх гэрээ	7	1	8	1	2	1
7	Бусад	0	4	0	5	0	1
	Нийт	68	53	97	56	35	33

Хүснэгт-55

Дэлгэрэнгүйг Хавсралт 14-ийн “а,б”-ээс харна уу.

6.7 ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙН СУДАЛГАА

Нэгтгэл тайлангийн явцад төрийн болон төрийн өмчийн оролцоотой, орон нутгийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компаниудад албан бичиг хүргүүлж, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн судалгааг авсан.

Судалгаанд төрийн болон төрийн өмчийн оролцоотой 8, орон нутгийн болон орон нутгийн өмчийн оролцоотой 3 компани хамрагдсан.

“Дарханы хар төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК -иас бусад нь мэдээллийг гаргаж ирүүлсэн. “Дарханы хар төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК нь Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн судалгааг өөрчлөгдсөнөөр ирүүлээгүй хуучин гишүүдээр, мөн мэдээллийг (гишүүдийн албан тушаал тодорхой бус) дутуу өгсөн.

(Дэлгэрэнгүйг Хавсралт-15-аас харна уу).

7. БУСАД АСУУДЛУУД

Ажлын даалгаврын явцад авч үзсэн бусад асуудлууд:-

7.1 ДЭД БҮТЦИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ БОЛОН БАРТЕРЫН СОЛИЛЦОО (ХЭЛЦЭЛ)

Нийгмийн үйлчилгээ, нийтийн дэд бүтэцийн зардлын төлбөрийн хэмжээг тодруулж дараах хүснэгтээр орууллаа.

Нийтийн дэд бүтцийн чиглэлээр Компаниудын хийсэн хөрөнгө оруулалт

д/д	Компанийн нэр	Хөрөнгө оруулалтын утга	ХО хийж эхэлсэн огноо	Нийт хөрөнгө оруулалт /мян.төг/	Тайлбар
1	Мондулаан трейд ХХК	9 км Цахилгаан дамжуулах шугамыг Төв аймгийн Заамар суманд	2013	165,000	100% хувийн хөрөнгө оруулалт
2	Оюу Толгой ХХК	Оюу Толгой ордоос Ханбогд сум хүртэлх зам	2010	2,301,321	100% хувийн хөрөнгө оруулалт
3	Оюу Толгой ХХК	Оюу Толгой ордоос Жавхланта сум хүртэлх зам	2011	536,274	100% хувийн хөрөнгө оруулалт
4	Оюу Толгой ХХК	Цахилгаан дамжуулах сүлжээ	2011	7,016,922	100% хувийн хөрөнгө оруулалт
5	Оюу Толгой ХХК	Цахилгаан хуваарилалтын шугам	2013	49,902	100% хувийн хөрөнгө оруулалт
6	Оюу Толгой ХХК	Хотын үйлчилгээний менежмент Дэд бүтцийн хөгжил	2013	2,213,658	100% хувийн хөрөнгө оруулалт
7	Оюу Толгой ХХК	Дотоодын болон бүсийн төлөвлөгөө, дэд бүтэц	2013	568,091	100% хувийн хөрөнгө оруулалт
8	Оюу Толгой ХХК	Худаг хөгжүүлэлт болон усан хангамж	2013	1,961,965	100% хувийн хөрөнгө оруулалт
9	Саусгоби сэндс ХХК	Өмнөговь аймгийн Гурвантэс суманд "Нарийн сухайт-Шивээхүрэн чиглэлийн хатуу хучилттай зам" барих төсөл	2011	35,109,396	Саусгоби сэндс ХХК- 40%-ын НТВ ХХК-60%-ын хөрөнгө оруулалт хийж, 15 жилийн дараа улсад хүлээлгэж өгөх
10	Терра Энержи ХХК	Өмнөговь, Ноён суманд "98.4 км автозам, Нарийн сухайт-Шивээхүрэн"	2013	15,600,607	100% хувийн хөрөнгө оруулалт хийж, 20 жилийн дараа улсад хүлээлгэж өгөх
	Нийт			65,523,136	

Хүснэгт-56

Эдгээр компаниудаас “Терра Энержи” ХХК, “Саусгоби Сэндс” ХХК-иудаас бусад нь буцалтгүй тусламж хэлбэртэй хөрөнгө оруулалт хийсэн байна. Үүнд:

- “Саусгоби Сэндс” ХХК нь ЗГ-тай концессын гэрээгээр Өмнөговь аймгийн Гурвантэс суманд Нарийн сухайт-Шивээхүрэн чиглэлд хатуу хучилттай автозам барьж, 15 жилийн дараа Монгол улсад хүлээлгэж өгөхөөр тохиролцсон.
- “Терра Энержи” ХХК нь концессын гэрээний зарчимд суурилсан гэрээг Зам тээврийн яамтай байгуулсан бөгөөд гэрээний хугацаа дуусгавар болох эсвэл цуцлагдах үед (20 жил) эзэмшигч нь замын байгууламжийн эзэмших, ашиглах эрхийг захиалагчид шилжүүлэхээр тохиролцжээ.

Нийгмийн хөрөнгө оруулалт, зарцуулалт

Боломжтой нийгмийн зардлуудыг ил тод болгох ажлын даалгаврын дагуу компаниудаас төрийн байгууллага, орон нутагт шилжүүлсэн нийгмийн шинжтэй хөрөнгө оруулалтыг харуулбал:

д/д	Компанийн нэр	Хөрөнгө оруулалтын утга	Хөрөнгө оруулалт хийж эхэлсэн огноо	Нийт хөрөнгө оруулалт /мян.төг/	Тайлбар
1.	Оюу Толгой ХХК	МСҮТ-ийн санхүүжилт	2010	5,633,170	100% хувийн хөрөнгө оруулалт
2.	Оюу Толгой ХХК	Дотоод бизнес, эдийн засгийг хөгжүүлэх программ	2013	617,317	100% хувийн хөрөнгө оруулалт
3.	Оюу Толгой ХХК	Хэсэгчилсэн бүс нутгийн ЭЗ дэд бүтэц (Хотын)	2013	669,626	100% хувийн хөрөнгө оруулалт
4.	Оюу Толгой ХХК	Хаягдлын менежмент-Ханбогд сум дахь хог хаях цэг	2013	48,367	100% хувийн хөрөнгө оруулалт
5.	Оюу Толгой ХХК	Тоглоомын талбай Ханбогд сум дахь нийтийн парк	2013	122,696	100% хувийн хөрөнгө оруулалт
6.	Оюу Толгой ХХК	Ханбогд сум дахь худаг нөхөн сэргээлтийн төсөл	2013	423,567	100% хувийн хөрөнгө оруулалт
	Нийт			7,514,743	

Хүснэгт-57

Бараа солилцоогоор хийгдсэн гэрээ хэлцэл байхгүй байна.

7.2 НИЙГМИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААРХ ЗАРДАЛ (КОМПАНИУДЫН ЗҮГЭЭС ҮЗҮҮЛСЭН ХАНДИВ, ДЭМЖЛЭГ)

Анхны тайлан болон нэгтгэл тайлангийн явцад компаниудын зүгээс Төр, засгийн байгууллагуудад 39,270.1 сая төгрөгийн хандив, дэмжлэг үзүүлсэн гэж тусгаж өгсөний дагуу Төр, засгийн байгууллагуудад хандаж хариу мэдээлэл авахад (Төр, Засгийн байгууллага 15,951.7 сая төгрөгийн, орон нутгийн засаг захиргааны байгууллага 23,244.8 сая төгрөгийн) нийт 39,196.5 сая төгрөгийн хандив, дэмжлэгийг хүлээн авсан гэсэн хариу өгч, 73.7 сая төгрөгийн зөрүү шийдэгдээгүй үлдсэн байна. **(Дэлгэрэнгүйг Хавсралт-19-ээс харна уу).**

А. Төр, засгийн байгууллагуудад үзүүлсэн хандив, дэмжлэг

№	Хүлээн авагч тал	ЗГ (мян.төг)	Хандивлагчид	
			Багууллагын нэр	Тоо
1	Богдхааны ордон музей	20,520	Оюу Толгой ХХК	1
2	Дулааны цахилгаан станц-3	3,000	Шивээ Овоо ХК	1
3	Занабазарын Дүрслэх урлагын музей	10,051	Оюу Толгой ХХК	1
4	Монголын театрын музей	3,135	Оюу Толгой ХХК	1
5	Монголын Үндэсний музей	25,002	Оюу Толгой ХХК	1
6	Мэргэжлийн боловсрол сургалтын газар	11,480,166	Оюу Толгой ХХК	1
7	Налайх дүүрэг-Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	4,178,810	Налайх Алхам ХХК, Оюу Толгой ХХК	2
8	Хил хамгаалах ерөнхий газар	4,996	Петро чайна дачин тамсаг” ХХК	1
9	Хүүхдийн асран хүмүүжүүлэх төв	10,900	Кожеговь ХХК, Петро чайна дачин тамсаг ХХК	2
10	Чойжин ламын сүм музей	12,540	Оюу Толгой ХХК	1
11	Эрүүл мэндийн яам	200,817	Бороогоулд ХХК	1
12	Эх нялхасын эрүүл мэндийн төв	1,798	Гурван Төхөм ХХК	1
	Нийт	15,951,735		14

Хүснэгт-58

Б. Орон нутгийн засаг захиргаанд өгсөн хандив, дэмжлэг

д/д	Хандив хүлээн авагчийн нэр	ЗГ-ын дүн (мян.төг)	Хандив өгсөн компанийн	
			Нэр	Тоо
1	Архангай	22,000	Алтандорнод Монгол ХХК, Алтай голд ХХК	2
2	Баянхонгор	120,797	Баялаг орд ХХК, Гобикоул энд Энержи ХХК, Жамп алт ХХК, Мондулаан трейд ХХК, Монлаа ХХК, Том шижир ХХК, Аниан ресорсиз ХХК	7
3	Булган	347,000	Өрмөн-Уул ХХК, Фокус метал майнинг ХХК, Хосхас ХХК, Монполимет ХХК, ГБНБ ХХК, ХОТУ ХХК	6
4	Говь-Алтай	130,276	Алтайнхүдэр ХХК, Гобикоул энд Энержи ХХК, Хүннү Говь Алтай ХХК, Марко поло ХХК	4
5	Говьсүмбэр	60,302	Шивээ овоо ХК, Шэйман ХХК, Оюу Толгой ХХК, Эм Си Ти Ти ХХК	4
6	Дархан-Уул	525,289	Оюу Толгой ХХК, Болдтөмөр Ерөө Гол ХХК, Шарын гол ХК	3
7	Дорноговь	366,969	Синотум Монголиа ХХК, Арева Монгол ХХК, Галаксимайнинг монголиа ХХК, Доншен газрын тос ХХК, Казмон контакт ХХК, КМНГ ХХК, Кожеговь ХХК, Фрийгүүд эрин ХХК, Рео ХХК, Си Өү Эй Эл ХХК, Дунфанлунома ХХК, Монлаа ХХК	12
8	Дорнод	894,173	Хар мөрөн монгол ХХК, Адуунчулуун ХК, Цэнгэг орог ХХК, Шанлун ХХК, Эрдэнэт Үйлдвэр ХХК, Сентерра Гоулд ХХК, ХОТУ ХХК, Эж Балей ХХК, Улз гол ХХК, Дун-Эрдэнэ ХХК, Петрочайна дачин тамсаг ХХК, Би Эйч Эм ХХК, Монголын алт МАК, Оюу Толгой ХХК	14
9	Дундговь	316,167	Адил Оч ХХК, Чинхаш ХХК, Тэмтэл ХХК, Монголын алт МАК, Эм Жи Би ХХК, Эм Си Ти Ти ХХК, Билэгтхайрхан уул, Ган-Илч ХХК, Голден Погада ХХК, Шанжин Орд ХХК, Эм Ди Эф И ХХК, Талын шигтгээ ХХК, Терра-Энержи ХХК	13
10	Орхон	25,148	Эрдэнэт Үйлдвэр ХХК	1
11	Өмнөговь	16,717,916	Энержи ресурс ХХК, Чинхуа мак нарийн сухайт ХХК, Мөст Олон Булаг ХХК, Олон Овоот Гоулд ХХК, Хүрээ дэл ХХК, Цагаан Эвөлжөө ХХК, Альшаа хайрхан ХХК, Шинэ Илион Нэн Юань ХХК, Түгэн-Эе ХХК, Оюу Толгой ХХК, Саусгоби сэндс ХХК, Монголын алт МАК, Мөнхноён суварга, Энержи ресурс ХХК, Жи Эс Би майнинг ХХК	15
12	Сүхбаатар	1,051,126	Андын Илч ХХК, Цайртминерал ХХК, Арева Монгол ХХК, Вульф Петролеум ХХК, Кожеговь ХХК	5
